

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**
/2023 оны жилийн эцсийн байдлаар/

2024 оны 02 дугаар сарын 14

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2023 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан. Хяналтад авсан нийт 170 шийдвэрийн 336 зүйл, заалтыг салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **88.89** хувийн биелэлттэй гэж дүгнэв.

Нийт 170 шийдвэрийн 336 зүйл, заалтаас 38 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 298 зүйл, заалтын 205 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 80 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 13 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
/Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-1

	Бүгд	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал
Хяналтад авагдсан шийдвэрийн тоо	170	10	17	20	2	52	61	4	2	2	-	-
Заалтын тоо	336	20	44	64	2	66	128	8	2	2	-	-
Үүнээс	“бүрэн хэрэгжсэн” 100%	205	14	15	33	2	46	86	6	2	1	-
	“хэрэгжих шатанд” 70.0%	80	2	21	16	-	9	30	1	-	1	-
	“хэрэгжилт хангалтгүй” 30.0%	13	1	2	2	-	3	5	-	-	-	-
	“хэрэгжээгүй” 0%	0	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Үнэлгээ өгөөгүй	38	3	6	13	-	8	7	1	-	-	-
	Үнэлгээ	88.89	92.35	79.74	87.84	100	91.72	89.67	95.71	100	85	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 10 хуулийн 20 заалтын хэрэгжилт – 92.35%
- Улсын Их Хурлын 17 тогтоолын 44 заалтын хэрэгжилт – 79.74%
- УИХ-ын Байнгын хорооны 20 тогтоол 64 заалтын хэрэгжилт – 87.84%
- Ерөнхийлөгчийн 2 зарлиг 2 заалтыг хэрэгжилт – 100%
- Засгийн газрын 52 тогтоолын 66 заалтын хэрэгжилт – 91.72%;
- Засгийн газрын хуралдааны 61 тэмдэглэлийн 128 заалтын хэрэгжилт – 89.67%;
- Засгийн газрын 8 албан даалгаврын 8 заалтын хэрэгжилт – 95.71%
- Ерөнхий сайдын 2 захирамж 2 заалтын хэрэгжилт - 100.0%
- ҮАБЗ-ийн 2 зөвлөмж 2 заалтын хэрэгжилт - 85%

Дөрөв. Дүгнэлт.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 170 шийдвэрийн 336 зүйл, заалтын хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар **88.89** хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.
2. Нийт 170 шийдвэрийн 336 зүйл, заалтаас 38 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 298 зүйл, заалтын 205 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 80 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 13 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан), баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж.

1. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан) гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх, үг үсэг, утга найруулгын алдааг засах, хариуцсан нэгжүүдийг тодорхой зааж өгөх;
2. “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг хариуцсан газрууд эрчимжүүлэх, тодорхой арга хэмжээг авч ажиллах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
1	2	3	4	5	6
МУ-ын хууль					
1	1	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01	14.1.1. бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан салбарын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх; (14.1.Төрийн захиргааны бусад төв байгууллага нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан бөгөөд тус үзэл баримтлалын 4.4.3-т “Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрийг нийтлэг байдлаар хөгжүүлнэ” гэж заасан байдаг. Энэ хүрээнд ЗГҮАХ, Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөө, УУХҮЯ-ны 2022-2024 оны Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/81 дүгээр тушаалаар “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөө”-г баталж, уг төлөвлөгөөнд бүсчилсэн хөгжлийн бодлого, удирдлага, зохицуулалтын талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал, Дархан-Сэлэнгэ, төв болон говийн бүсийн аймгуудад үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

	2		<p>14.1.3.. бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар тухайн салбарын хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг Үндэсний хороонд тайлагнах;</p>	<p>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газарт тайлагнан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар ОҮИТБС-д нэгдсэнтэй холбогдуулан 2006 оны 295 дугаар тогтоолоор ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг удирдах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдаар анх ахлуулан байгуулсан. Засгийн газраас 2018 оны 289 дүгээр тогтоолоор Үндэсний зөвлөлийн даргаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагчаар УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргыг тус тус өөрчлөн томилсон нь ил тод хариуцлагатай уул уурхайн бодлогыг тус яам дээр зангидах болсон. Энэ хүрээнд Засгийн газрын 2012 оны 222, 2017 оны 263 дугаар тогтоолууд тус тус батлагдаж Монголын олборлох үйлдвэрлэлийн ил байдлын санаачилгыг эрчимжүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил болгон УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Энэ хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр УУХҮЯ, АМГТГ, МУУҮА, Монголын ОҮИТБС-ын Ажлын алба хамтран эрдэс баялгийн салбарын ач холбогдол, үр нөлөөг хэлэлцэх, уул уурхайн чиглэлээр хариуцлагатай үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, төсөл, хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох зорилгоор “Хариуцлагатай уул уурхай” өдөрлөг-арга хэмжээг дөрвөн бүсийн хэмжээнд зохион байгуулсан. Хангайн бүсийн арга хэмжээг Эрдэнэт хотод 2023 оны 05 дугаар сард, төвийн бүсийн арга хэмжээг Дархан хотод 2023 оны 07 дугаар сард, баруун бүсийн арга хэмжээг Алтай хотод 2023 оны 09 дүгээр сард, зүүн бүсийн арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сард тус тус зохион байгуулж, төр, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын 1000 орчим төлөөллүүд оролцож санал солилцсон.</p>	100%
--	---	--	--	---	------

	3		<p>14.1.2. эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдуулан салбарын бүсчлэл, байршлын бүдүүвчийг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил, байршлыг зохицуулах;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Эдийн засгийн бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг харгалзан баруун бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; хангайн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэрийг; төвийн бүсэд: бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээг; зүүн бүсэд: уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалыг; Улаанбаатарын бүсэд: оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тусгасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас “Монгол улсын хүнд үйлдвэрийн төлөвлөлтийн судалгаа”-г 2017 онд хийж гүйцэтгэсэн. Тус судалгаагаар үйлдвэр байгуулахад зайлшгүй шаардлагатай хүн амын нутагшил, суурьшил, байгаль, цаг уурын онцлог, байгалийн бүсчлэл, дэд бүтцийн хөгжил, нөлөөллийн хүрээ, түүхий эдийн нөөц, боловсруулах үйлдвэрийн байршил, зах зээл, гидрогеологи зэрэг суурь хүчин зүйлүүдийг харгалзан “Веберийн аж үйлдвэрийн байршлын загвар”-ыг онолын үндэслэл болгон анхдагч түүхий эд, хоёрдогч түүхий эд, зах зээлийн хамгийн оновчтой байршилд үйлдвэрийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, орон зайн болон тоон мэдээний өгөгдлийг ArcGIS программд оруулж зураглалын аргыг ашиглан үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутгуудыг тодорхойлж, хүнд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх байршил болон Монгол улсын хүнд үйлдвэржилтийн газрын зургийг боловсруулсан. Тус судалгааны үр дүнд үндэслэн Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП) байгуулна. Паркийн бүрэлдэхүүнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр болон исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор</p>	100%
--	---	--	---	---	------

				катодын зэсийн үйлдвэр байгуулна.Тавантолгой нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. Хар төмөрлөгийн /кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр/ үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлнэ, Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна зэрэг төсөл, арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	
	4		14.1.5. Салбарын зорилтыг бүс нутгийн хөгжлийн асуудалтай уялдуулах зорилгоор бүсчилсэн зөвлөлгөөн, уулзалт санаачлан зохион байгуулах;	Аж үйлдвэржилтийн үндэсний зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Тус үндэсний зөвлөгөөнд 1200 гаруй зочид төлөөгчид оролцож, 7 илтгэл танилцуулж, 2 панел хэлэлцүүлгийг зохион байгуулж, аж үйлдвэржилтийг эрчимжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцсэн.	100%
2	5	Цөмийн энергийн тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16	28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. (28.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.)	Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 21 дүгээр захирамжаар уурхайн нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагаанаас тусдаа зөвхөн гэнэтийн аюул, осолтой холбогдон нийгэмд бий болох хохирлыг /Эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал/ арилгахад шаардагдах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтооход чиглэсэн Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах энерги” ХХК-ийн ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын дагуу Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах гэрээний төслийг УУХҮЯамнаас боловсруулан СЯ, БОАЖЯ, МХЕГ, ЦЭК, АМГТГ-аас холбогдох саналыг авч тусгасан. Гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн дарга, “Бадрах Энержи”ХХК-ийн гүйцэтгэх захирал нар байгуулж, “Бадрах Энержи”ХХК нь Төрийн сангийн 100900018351 тоот дансанд	100%

				900,000.0 /есөн зуун мянга/ ам.долларыг тухайн өдрийн Монголбанкны ханшаар байршуулсан.	
	6		15.2. Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ: 15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх; 15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах; 15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх.	Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт 192.2 мян.тн ураны геологийн нөөц байна. 2023 оны 9 дүгээр сарын байдлаар ураны хайгуулын 6, ашиглалтын 8 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх Түр зөвшөөрөл бүхий "Элемент"ХХК Тосон-Уул XIX талбайд хуримтлагдсан хугацаа хэтэрсэн химийн бодисыг устгах ажлыг гүйцэтгэж байгаа ба 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд нийт 20 удаагийн тээвэрлэлтээр 592 тонн химийн бодисыг Налайх дүүрэгт байрлах өөрийн үйлдвэр рүү тээвэрлэн хүргэж бүрэн устгаж дууссан.	100%
3	7	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/130 дугаар тушаалаар яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг, 2023 оны А/128 дугаар тушаалаар яамны төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
4	8	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай	15.6. Тэсэлгээчний эрхийг Монгол Улсын иргэнд олгох бөгөөд тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хүчингүй болгосон.	Х.Б
	9	хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-01-30 Дугаар 2020-1-30	17.3. Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрмийг батлах" гэж заасны дагуу тус яамнаас дүрмийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/2895 дугаар албан бичгээр яамдаас санал авч байна. Засгийн газрын тогтоолын төсөл батлагдсаны дараа "Монгол Улсад ашиглах үзвэрийн	70%

				болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалт"-ыг батлуулахаар төлөвлөж байна.	
	10		17.6. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд уг хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийг хүчингүй болгосон.	Х.Б
5	11	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ.	"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил, хагас жилийн байдлаар гаргаж холбогдох нэгжид хүргүүлж байна.	100%
6	12	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон яамны худалдан авах ажиллагааны мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны мэдээллийг 9 удаа, худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг 3 удаа оруулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн.	100%
7	13	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	5.1. Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.	Тогтоолын дагуу дэд дарга нарыг чөлөөлсөн.	100%
	14		13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно.	Х.Б

			хэмнэлтэд тооцох; (13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1. Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)		
8	15	Хөрөнгийн үнэлгээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-06-17 Дугаар 2023.01.01	7.2.12. ашигт малтмал болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран; (7.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаар, эсхүл доор дурдсан төрийн байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцсэн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг батална:)	Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 330 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулснаар МОНВАЛ Кодексыг боловсруулж эхэлсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын үнэт цаасны бирж”ХК, Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт болон Австрали–Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн төлөөлөл орж ажилласан бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний үндэсний кодексын төслийг боловсруулсан.	30%
9	16	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	8.1.2. дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, эрэлт хэрэгцээний хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор паркийн	"Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан үүсгэх, бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам"-ыг Сайдын 2023 оны 12 дугаар 08-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлуулсан.	100%

		2022-07-05 Дугаар 2022.07.05	мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, холбогдох журмыг батлах;	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 6505 дугаарт бүртгэгдсэн.	
17			13.6. Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журмыг Засгийн газар тогтооно.	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах баримт бичгүүдийг тус яамнаас санаачлан болон хамтран боловсруулж, батлуулаад байна. Үүнд:</p> <p>1.Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасны дагуу “Технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам” (тус журмын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/281, А/210 дугаар хамтарсан тушаалаар “Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв” ХХК-д, 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/454, А/320 дугаар хамтарсан тушаалаар Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургууль (Геологи, уул уурхайн сургууль, Механик, тээврийн сургууль, Уул уурхайн хүрээлэн)-д тус тус Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай олгосон);</p> <p>2.Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасны дагуу “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлал”;</p> <p>3.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу “Үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх журам”;</p> <p>4.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу “Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд</p>	100%

				<p>дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”;</p> <p>5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6-д заасны дагуу “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, албан татвараас чөлөөлөх журам”-ыг Сангийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор батлуулаад байна.</p> <p>6. Хүнд үйлдвэрийн паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журам"-ыг 2024 оны II улиралд багтаан боловсруулахаар УУХҮЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.</p>	
10	18	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай 2022-12-23 Дугаар 2022.12.23	10.2. Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосны дагуу Засгийн газар батална.	Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоолоор “Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал”-ыг батлуулсан.	100%
	19		16.2. Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох журмыг батална.	<p>УУХҮ-ийн Сайдын 2023 оны А/96 дугаар тушаалаар УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулж, Эдийн засаг хөгжлийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөллийг оролцуулан “Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох журам”-ын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсэг биржээр арилжаалсан уул уурхайн бүтээгдэхүүнийг хадгалах дэд бүтцийг байгуулах, лабораторийн шинжилгээнд хамруулах, гаалийн бүрдүүлэлт хийх, тээвэрлэлтийг зохион байгуулах, хилээр нэвтрүүлэх харилцааг хамааруулан журмын төсөл боловсруулсан.</p> <p>Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлтийг “Гаалийн тухай хууль”, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/41 дүгээр тушаалаар батлагдсан “Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим” –ыг хэрэгжүүлэх журам, ГЕГ-ын</p>	70%

				<p>даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/226 дугаар тушаалын батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”, ГЕГ-ын даргын 2015 оны А/287 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал, уул уурхайн бүтээгдэхүүн тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих технологи ажиллагааны заавар”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ний ТУЗ-ийн 2023 оны “Биржийн зах зээлийн зарим оролцогчийг итгэмжлэх, тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулах журам”, биржээр арилжаалсан бүтээгдэхүүний тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх харилцааг Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Нээлттэй цахимаар арилжсан нүүрсний экспортын талаар авах зарим арга хэмжээний тухай” 159 дугаар тогтоол, Хилийн боомтын захиргааны даргын 2022 оны “Гашуунсухайт дахь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-аар тус тус зохицуулагдан уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалагдаж байна.</p> <p>Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж байгаа тул, биржийн арилжааны явцад тулгарах асуудал, саад бэрхшээлийг тандан судалж, асуудлыг тодорхойлж тус журамд тусгах нь зүйтэй гэж ажлын хэсэг үзсэн тул УУХҮ-ийн сайдаас “Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох журам”-ыг Засгийн газраар IV улиралд хэлэлцүүлэн батлуулах ажлыг түр хойшлуулсан.</p>	
20			<p>17.3. Хороо нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам батална.</p>	<p>"Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх" журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 318/А/231 тоот хамтарсан тушаалаар баталсан.</p>	100%
УИХ-ЫН ТОГТООЛ					

11	21	<p>Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14 Дугаар 2001№57</p>	<p>4.7.1.б.бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох;</p>	<p>Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах төсөл: 2023 оны III улиралд Баяжуулах-II үйлдвэрийг ашиглалтад оруулснаар бүрэн хүчин чадлаар ажиллаж жилд 600 мян.тн хүдэр боловсруулж, борлуулалтын орлого ойролцоогоор 65%-аар өссөн.</p> <p>Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл: Зүүн цагаан дэлийн далд уурхайн 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн. Уурхайн 1140 м түвшинд тээвэрлэлтийн налуу малталт, агааржуулалтын босоо малталт болон түр усан сан, насосын камерын нэвтрэлтийн ажлууд явагдаж байна. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.</p> <p>"Оюу Толгой" төслийн далд уурхайг ашиглалтад оруулах төсөл: "Оюу толгой" төслийн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 92.1%, налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 84.3 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 33.6 хувь, агааржуулалтын III босоо амны нэвтрэлт 865 метр, агааржуулалтын IV босоо амны нэвтрэлт 959 метрт тус тус хүрээд байна. Далд уурхайгаас хүдэр олборлолтын ажил явагдаж байна.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх төсөл: Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн /Өөрөө нунтаглах хэсгийн хүдэр боловсруулах IV шинэ шугам, Хам баяжуулалтын 12 сая тн/жил хүчин чадалтай V секцийг шинэчлэх/ төслүүд 100% хийгдэж, одоо баяжуулах үйлдвэрт 4 төсөл хэрэгжиж байна. Хүрсэн түвшин 90% гүйцэтгэлтэй.</p>	100%
----	----	--	--	--	------

			<p>Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтыг эхлүүлэх:</p> <p>УХОХ-т Асгатын мөнгөний ордын хайгуул, туршилт судалгаа, ТЭЗҮ, баяжуулалтын технологийн судалгаа хийхэд 2023 оны төсөвт 57,615.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгаснаас 2023 оны 11.1 тэрбум төгрөгт зөвхөн нэмэлт хайгуулын ажил, лабораторийн туршилт, нөөцийг ОУ-ын ангилалд нийцүүлсэн үр дүнгийн тайлан хийхээр төлөвлөсөн.</p> <p>Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл:</p> <p>Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн бүтээн байгуулалтын гүйцэтгэл 63.51%-тай байгаа ба 510.44 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Уулын зарим техник, тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч байгаа ба конвейерийн системийн ТЭЗҮ-ийг батлуулсан бөгөөд түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 83.84%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн гүйцэтгэл 92%-д хүрсэн.</p> <p>Цагаансуваргын ордыг ашиглалтад оруулсан байх:</p> <p>Төслийн хүрээнд 2023 онд анхан бутлуурын хүчитгэсэн хананы угсралт, барилга болон тоног төхөөрөмжийн суурийн цутгалт, барилгын металл хийц угсралтыг хийсэн. Үндсэн болон туслах тоног төхөөрөмж, материалын тээврийг хийж байна. Мөн туслах тоног төхөөрөмжийн захиалга, үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p> <p>Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах:</p> <p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж нийт 4 багц ажлаас бүрдэж байгаа бөгөөд "Технологийн бус барилга байгууламжийн /EPC-1/-ийн барилга угсралтын ажил 2023 оны эцсийн байдлаар 98.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Төсөл</p>
--	--	--	--

			<p>хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”ТӨХХК нь үйлдвэрийн анхдагч процессын байгууламж /EPC-2/, үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/-ын барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийг 2022 онд, лицензтэй технологийн байгууламж /EPC-4/-ийн ерөнхий гүйцэтгэгчийг 2023 онд тус тус шалгаруулж БНЭУ-ын “Megha Engineering Infrastructures Limited” компанитай гэрээг байгуулаад байна.</p> <p>Үйлдвэр ашиглалтад орсноор шингэрүүлсэн шатдаг хий 43 мян.тн, авто бензин 339 мян.тн, дизель түлш 824 мян.тн, тийрэлтэт хөдөлгүүрийн түлш 80 мян.тн, зуухны түлш 47 мян.тн, нийт 1,33 мян.тн стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тооцоололтой бөгөөд энэ нь манай улсын дотоодын хэрэглээний 55.0 хувийг хангах боломж бүрдэх юм.</p> <p>Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл: “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээг “ЭҮ” ТӨҮГ болон “Майнинг Шорт Лонг Терм”ХХК-хооронд 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан.</p> <p>Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын “Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай” 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан. ТЭЗҮ-д тусгаснаар: Зэсийн үнийг 8500\$/тн-оор тооцож, нийт хөрөнгө оруулалтыг 109.8 сая.\$ буюу 362.4 тэрбум төгрөг, үүний анхны хөрөнгө оруулалт 197.6 тэрбум төгрөг, ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт 164.8 тэрбум төгрөг байхаар тооцсон. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд нийт 1,584.78 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байгаа бөгөөд ажлын хэсгийн хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл,</p>
--	--	--	---

			<p>хуулийн төслийн бичвэрийг эцэслэн боловсруулж, хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 171 иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1315 орчим саналыг хянаж, яамдаас ирүүлсэн саналд тайлбар,тодруулга бэлтгэх засвар өөрчлөлтүүдийг хийсэн.</p> <p>. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах, Гангийн үйлдвэр байгуулах, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийг байгуулах, Дорноговь аймагт “Алтанширээт” аж үйлдвэрийн парк байгуулах, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэрлэл технологийн парк байгуулах зэрэг төсөл арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>. Уул уурхайн салбар нь 2023 оны байдлаар эрдэс баялгийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 27%, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 71%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 78%, экспортын орлогын 92%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 77%, улсын төсвийн орлогын 34%-ийг дангаараа бүрдүүлж эдийн засгийн тэргүүлэх салбар болон хөгжиж байна.</p> <p>. 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 67,259.5 мян.тн нүүрс, 1,482.6 мян.тн зэсийн баяжмал, 5,437.1 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 147.6 мян.тн цайрын баяжмал, 1047.6 мян.тн хайлуур жоншны баяжмал экспортолсон. Алт олборлолт 17.0 мян.тн. Нүүрсний экспортын гүйцэтгэл +134.5%, алт олборлолт 82.0%, зэсийн баяжмал 102.0%, төмрийн хүдэр, баяжмал 64.6%, цайрын баяжмал +147.6%, хайлуур жоншны баяжмал +261.9%-ийн гүйцэтгэлтэй байна.</p>	
--	--	--	---	--

12	22	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	ҮАБЗ, ОБЕГ, НЗДТГ хамтран Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт хийхтэй холбогдуулан харъяа мэргэжлийн ангиудад мэдээллийг хүргүүлж 4 удаагийн сургалтанд хамрагдав. Мөн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан команд штабын сургуулилтад АМГТГ, ҮГА, ГСШТ ТӨҮГ-ын гамшгийн асуудал хариуцсан ажилтнуудын хамтран амжилттай оролцсон.	100%
	23		8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2018 онд баталж, 2019, 2020 онд тус тус тодотгосон. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардлагатай зардлыг байгууллагын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%
13	24	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-06-29 Дугаар 2018 №73	1.1/. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх;	Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамнаас “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” саналыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 296 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоолын дагуу байгуулж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцүүлэн олон улсын болон дотоодын зах зээлд үе шаттайгаар үнэт цаас гаргах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээ авах гэрээг байгуулан ажиллаж байсан. Гэвч УИХ 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас баталсан 2019 оны 296 дугаар тогтоолыг 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул гадаадын хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.	Х.Б

25		<p>1.4/. Өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийг байгуулсан. Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /СМЕС/ боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус яамнаас "Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" компани шалгарч 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр ЕРС гэрээг байгуулсан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төслийн гүйцэтгэл 65%-тай байна.</p>	70%
26		<p>1.5/. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны захиалгаар Дэлхийн банкны "2030-Усны нөөцийн бүлэг" нь "Монголын өмнөд говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик шинжилгээ"-г 2020 онд хийж гүйцэтгэсэн. Судалгаа, шинжилгээний үр дүнд өмнийн говийн ашиглах боломжтой газрын доорх усны нийт 20 ордыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны шалгуур үзүүлэлтээр үнэлж, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн газрын доорх усны ордоос эхэлж ашиглах талаар зөвлөмж өгсөн ба үүнд өмнийн говийн бүсэд гадаргын усыг шилжүүлэн ашиглах төсөл хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд Загийн усны хоолой болон Цагаан цавын газрын доорх усны ордуудыг ашиглах боломжтойг тодорхойлсон. Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг</p>	70%

				<p>боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах ажлыг дуусан тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулсан. Загийн усны ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч түншлэлүүдтэй гэрээ байгуулан ажлыг 2022 оны 03 дугаар сараас эхлүүлсэн. Одоогоор гүний худгуудын өрөмдлөгийн ажил болон өргөх насосын барилгууд дууссан. Усан сангууд болон шугам хоолойн ажлууд хийгдэж байна. Төслийн нийт гүйцэтгэл 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 90.4%-ийн гүйцэтгэлтэй байна.</p>	
14	27	<p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2018-11-15 Дугаар 2018 №84</p>	<p>2.9/. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.</p>	<p>Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрээр “Эрдэнэс Алт Ресурс”ХХК-ийг 100 хувь төрийн өмчит компани хэлбэрээр байгуулсан. “Эрдэнэс алт ресурс”ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба “Түлхүүр гардуулах” нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, “Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол”ХХК-ийн гүйцэтгэх захирлын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” ХХК-ийн боловсруулсан 81.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүхий ТЭЗҮ-ийг хянаж, ТЭЗҮ-ийн эдийн засгийн тооцооллыг зассан ч ТЭЗҮ бодит байдалтай нийцэхгүй, хөрөнгө оруулалтын зардлыг хэт өндөр байна гэж дүгнэсэн. Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамнаас 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 30-309 дугаартай захидлаар “Сымбат инженеринг”ХХК нь алт цэвэршүүлэх үйлдвэр барихад 80 сая</p>	30%

				ам.долларын санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтойг уламжилсан саналд “Эрдэнэс алт ресурс”ХХК нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хүлээн авч бүх талаар хамтран ажиллах саналаа илэрхийлж 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ЕА 22/65 албан бичгээр хүргүүлсэн байна. Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02/47 дугаар албан бичгээр БНКазУ-ын “Сымбат инженеринг”ХХК-тай цаашид баримтлах байр сууриа яамны зүгээс илэрхийлсэн. Төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй байна.	
15	28	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.7/г/. уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олон улсын чиг хандлага, техник, технологийн хөгжилтэй уялдсан аюулгүй ажиллагааны дүрмүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулан аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдүүлэх, хяналт шалгалт хийх бололцоог бүрдүүлж, уурхайчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах аюулгүй ажиллагааны дүрмүүдийг шинэчлэн боловсруулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд: “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм” (2019 он); “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” (2020 он) “Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” (2020 он)	100%
16	29	Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай 2019-11-21 Дугаар 2019 №92	1.1/. 1.Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Ви Ви Ай) Лтд, Оюу	Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны №174, 2021 оны №45, 2022 оны №198, 2023 оны №165 дугаартай захирамжаар “Ажлын хэсэг” байгуулагдаж, “Оюу Толгой” төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийгдэж байна. Тогтоолын уг заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус “Ажлын хэсэг”-т “Эрдэнэс Оюутолгой”ХХК-иас 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний 118, Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 42, “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах саналыг боловсруулан Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын	70%

			<p>Толгой Нидерланд Би Ви, Оюу Толгой ХХК хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” 40 дүгээр тогтоол, 2009 оны “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах;</p>	<p>хэсгийн ахлагч Х.Нямбаатарт 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр хүргүүлж, танилцуулсан. Мөн “Оюу Толгой” төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Atticus Communications” (Atticus Partners) компанийн дэмжлэгтэй, Jefferies (Australia) болон PWP (PERELLA WEINBERG PARTNERS)-с санхүүгийн зөвлөх үйлчилгээг Монгол Улсын Засгийн газар болон “Эрдэнэс Оюутолгой” ХХК аваад байна.</p>	
	30		<p>1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах;</p>	<p>“Эрдэнэс Оюутолгой”ХХК-иас 2015 онд байгуулагдсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах саналыг боловсруулан Хууль зүй, Дотоод хэргийн сайд, ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр хүргүүлж, танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 59 дүгээр хуралдааны тэмдэглэлийн дагуу “Эрдэнэс Оюутолгой”ХХК-иас ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх саналыг боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яам болон Эрчим хүчний яаманд тус тус хүргүүлсэн. Түүнчлэн “Оюу толгой” төслийн хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж буй шинэчлэн байгуулагдсан ажлын хэсэгт “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”, “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувь</p>	70%

			нийлүүлэгчдийн гэрээ"-нд тусгагдсан Монголын талын эрх ашигт сөргөөр нөлөөлж буй асуудал болон дээр дурьдсан гэрээнүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, "Цуцалж дуусгавар болгох" зэрэг асуудлаас үүсч болзошгүй эрсдлийн талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулсан.	
31		1.3/. Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд зааснаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;	"Эрдэнэс Оюутолгой"ХХК-ийн зүгээс Монголын талын "Оюу толгой" төслөөс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх боломжит хувилбаруудыг тодорхойлж, урт хугацааны санхүүгийн загварт оруулж төсөл болон хувьцаа эзэмшигчдийн өгөөжид хэрхэн нөлөөлөх, Монгол Улсын Засгийн газрын өгөөжийг хэдий хэмжээгээр өсгөх боломжтой зэрэг дээр харьцуулсан тооцоолол танилцуулга бэлтгэж, ажлын хэсэгт танилцуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/275 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших "Оюу толгой зэс-алтны ордыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл"-ийн тодотголын төсөлд шүүмж, дүгнэлт гаргах шинжээчдийн хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус шинжээчдийн хэсэгт Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн төлөөлөл ажиллаж байна.	70%
32		1.4/. Оюу толгой ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартын дагуу дахин хийж, үүнд үндэслэсэн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших "Оюу толгой зэс-алтны орд"-д 2019 онд гүйцэтгэсэн нөөцийн шинэчилсэн тооцооны үр дүнд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий "Шинжээчдийн хэсэг"-ийг байгуулж, тайланг 2021 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаан"-аар хэлэлцэж, хүлээн авсан. Тус тайланд Оюу толгойн бүлэг ордын хэмжээнд нөөцийг тооцохдоо ил уурхайн сульфидын хүдрийн нөөцөд зэсийн дүйцүүлсэн захын агуулгыг 0.22%-иас 0.24% болгож өсгөсөн, далд уурхайн сульфидын хүдрийн нөөцөд зэсийн дүйцүүлсэн захын агуулгыг 0.37%-иас 0.41% өсгөсөн нь нийт геологийн нөөцийг 8%-аар бууруулсан байна. Улмаар УУХҮ-ийн Сайдын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/275 дугаар	70%

			тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюу толгой зэс-алтны орд”-ыг ил болон далд аргаар ашиглах ТЭЗҮ-ийн тодотголын төсөлд шүүмж, дүгнэлт гаргах шинжээчдийн хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус шинжээчдийн хэсэгт Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн төлөөлөл ажиллаж байна.	
33		1.5/. Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 тоот “Газрыг улсын хэрэгцээнд авах тухай” тогтоолыг өөрчилж, говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох;	“Оюу Толгой”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар холбогдох төсвийг хэлэлцүүлэх үед “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас 2022 онд “Оюу Толгой” төслийн ашиглаж буй усны гол эх үүсвэр болох гүний хоолойн газрын доорх усны ордын ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлэх ажлыг гүйцэтгэх саналыг хүргүүлэн, зардлыг төсөвт батлуулсан. Тус ажлыг гүйцэтгэх гэрээт компани сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулах явцад хөндлөнгийн, хараат бус, олон улсын байгууллага, мэргэжлийн зөвлөлтэй хамтран гүйцэтгэх, мөн усны нөөцийг үнэлэхдээ дотоодын болон олон улсын жишиг олон талт арга, аргачлалыг ашиглах тухай саналыг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, Усны газартай хамтран боловсруулж “Оюутолгой” ХХК-д хүргүүлсэн. Үүний дагуу “Оюу Толгой”ХХК нь ажлын даалгаврыг боловсруулан Усны газраар батлуулан, үүний үндсэн дээр гэрээт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд усны нөөцийг дахин үнэлэх ажил хийгдэж байна.	70%
34		1.6/. Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах;	Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан “Оюу Толгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсэг нь: ХөОГ, НӨОДТХНГ, ДУББСТ зэрэг баримт бичиг боловсруулахад оролцсон Монголын талын төлөөлөл УИХ-ын 2008 оны 40, 2009 оны 57 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийг бүрэн баримталж ажиллаагүй, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулийн зарим заалтыг зөрчсөн, хөрөнгө оруулагч талд давуу байдал олгосон зэрэг нь төслийн үйл ажиллагааны үр	70%

				<p>дүнгээс Монголын талын хүртэх үр ашиг, өгөөжийг бууруулах нөхцөл байдалд хүргэсэн.</p> <p>ХеОГ, НӨОДТХНГ-нд хяналт шинжилгээ, үнэлгээ мониторинг хийх хоёр талын төлөөлөл оролцсон ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар гэрээг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.</p> <p>Дубай хотноо байгуулсан ДУББСТ, ДУББСНТ, Менежментийн гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомж болон ХеОГ, Хувь нийлүүлэгчдийн гэрээний зүйл, заалтыг зөрчсөн учир түүнийг нягтлан судалж, хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны №174, 2021 оны №45, 2022 оны №198, 2023 оны №165 дугаартай захирамжаар “Ажлын хэсэг” байгуулагдаж, “Оюу Толгой” төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийгдэж байна. Тогтоолын уг заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус “Ажлын хэсэг”-т “Эрдэнэс Оюутолгой”ХХК-иас 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний 118, “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 42, “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах саналыг боловсруулан Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр хүргүүлж, танилцуулсан. “Оюу толгой” төслийн хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд холбогдох ажлууд хийгдэж байна.</p>	
	35		1.7/. Оюу толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх.	<p>“Оюу Толгой”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн ээлжит 46 дугаар хурлын үргэлжлэл хурлаар Монголын талаас санал болгосон “Гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөлд тавих хяналтыг сайжруулах” тухай 274 дүгээр тогтоол батлагдан, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтэд тусгагдсанаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий хөндлөнгийн фирмээр “Далд уурхайн бүтээн байгуулалтын өргөтгөлийн зардал”-д хөндлөнгийн аудит хийлгэх боломж</p>	70%

			<p>бүрдсэн. Түүнчлэн, тус тогтоолд “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-иас далд уурхайн төсөлд хяналт тавих чиг үүргийг тодотгож, санхүүгийн чадавхыг сайжруулахтай холбоотой дараах заалтууд тусгагдсан. Эдгээрт:</p> <p>“Эрдэнэс Оюу Толгой”ХХК-ийн зүгээс гүний уурхайн төсөлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан ба энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, дүгнэлтэд заасны дагуу төслийн менежментийг сайжруулах зорилгоор, “Оюу Толгой” ХХК-ийн засаглалын тогтолцоо, холбогдох гэрээний хүрээнд “Эрдэнэс Оюу Толгой”ХХК болон түүний нэр дэвшүүлсэн этгээд (тухайлбал “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-иас нэр дэвшүүлж, “Оюу Толгой” ХХК-д мэдэгдсэн ажилтан буюу зөвлөх)-тэй нягт хамтарч ажиллахыг Оюу Толгой ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад даалгасугай. Энэхүү хяналт тавих үйл ажиллагаа нь “Гүний уурхайн төсөл бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд” эсхүл “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-ийн зүгээс төсөлд хяналт тавих шаардлагагүй болсон гэж үзэх хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Гүний уурхайн төсөлтэй холбогдуулан “Эрдэнэс Оюу Толгой”ХХК болон түүний нэр дэвшүүлсэн этгээдтэй нягт уялдаатай хамтран ажиллаж, тэднийг төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай аливаа мэдээллээр хурдан шуурхай, аливаа хязгаарлалтгүйгээр хангаж ажиллахыг “Оюу Толгой”ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.</p> <p>Дээр дурдсан төслийн хяналтын чиг үүрэг нь төслийн хяналтын ерөнхий чиг үүргүүд, хуваарь гаргах үйл явц, сар тутмын явцын тайлан, зураг төсөл, хангамж, барилга угсралтын менежментийн тайлагнал, зардлын хяналт зэргийг багтаах ба төрийн эсхүл төрийн зохицуулалтын аливаа зөвшөөрөл, батламж, хяналт шалгалт болон/эсхүл эрх авах хүсэлтэд хамаарахгүй болохыг дурдсугай.</p> <p>“Эрдэнэс Оюу Толгой”ХХК-ийн зүгээс төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг санхүүжүүлэхийн тулд “Авилга болон хээл хахуулийн эсрэг хууль, тогтоомж”-ийн дагуу, “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-иас төсөлд хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгон 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө 5 сая хүртэлх ам.долларын нийт үнийн дүн бүхий төлбөрийг “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-д түүний ирүүлэх төсөвтэй нийцүүлэн олгохыг “Оюу Толгой”ХХК-д даалгасугай.</p> <p>Тус дэмжлэг нь:</p>
--	--	--	--

				<p>Төслийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах нөөц бололцоог бүрдүүлэх төлбөр;</p> <p>Төсөлд хяналт тавих чиг үүрэг гүйцэтгэх улирал тутмын төлбөрийг улирал тутмын эцэст бичгээр гаргасан нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш арав (10) хоногийн дотор "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д төлөх төлбөр байна. "Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь төслийн хэрэгжилтэд тавих хяналтын чиг үүргийн гүйцэтгэлийн явцын тайланг улирал тутам гаргаж, холбогдох зардлын дэлгэрэнгүй задаргааг тайланд тусгах бөгөөд "Оюу Толгой" ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын зүгээс хүсэлт гаргасан боломжит бүхий л нотлох баримтыг гаргаж өгнө." гэж тусгагдсан.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд "Оюу Толгой төсөл"-ийн далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн хяналтыг сайжруулах зорилгоор болон цаашид төсөлд тавих Монголын талын хувьцаа эзэмшигчийн хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотойгоор гадаад мэргэжилтнүүд, зөвлөх авч ажиллуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан. Түүнчлэн "Оюу толгой" төсөлд холбогдох гэрээ, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, төслийн өнөөгийн явц байдал, тулгамдсан болон шийдвэрлэвэл зохих зарим асуудлын талаар 2021 оны 10 дугаар сард УИХ дахь намын бүлгийн хуралдаанд танилцуулга хийгдсэн.</p> <p>"Оюу толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 274 дүгээр тогтоолын дагуу "Оюу толгой" ХХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдал болон Байгаль орчин, Нийгэм, Засаглалыг сайжруулах үүднээс "Эрдэнэс Оюутолгой" ХХК-аас дэмжлэг авч, хамтран ажиллахыг "Оюутолгой" ХХК-д даалгаж баталсны дагуу "Оюу толгой" төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэхээр ажиллаж байна.</p>	
17	36	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль	УУХҮЯ хуулийн төсөл 2020. Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УУХҮ-ийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар "Ашигт малтмалын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн	70%

		<p>ТОГТООМЖИЙГ нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-01-09 Дугаар 2020 №02</p>		<p>зүгээс “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 15.5-д заасны дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан. Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.</p>	
	37		<p>СЯ хуулийн төсөл 2020. Үндэсний баялгийн сангийн тухай /Анхдагч хууль/ Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>ЭЗХЯ-нд шилжүүлсэн тул биелэлт гаргах боломжгүй.</p>	Х.Б
18	38	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52</p>	<p>3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг,</p>	<p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгаж, хэрэгжилтийг хангах ажлыг гүйцэтгэж байна.</p>	70%

			нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;		
19	39	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020-08-28 Дугаар 2020 №24	2.4/. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтийн явц: "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын санхүүжилтийн ажлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК хариуцан ажиллаж, ашиглалтад оруулсан. "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын санхүүжилтийн ажлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК хариуцан ажиллаж, ашиглалтад оруулсан. "Эрдэнэт үйлдвэр"ТӨҮГ-ийн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн ажил 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 100%-д хүрсэн байна. Зүүнцагаан дэлийн ордыг ашиглалтад оруулах төслийн гүйцэтгэл 100%-д хүрсэн байна. Салхитын мөнгөний ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн төслийн гүйцэтгэл 100%-д хүрсэн байна. "Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 12 дугаар сарын 31-ний байдлаар 65%-тай байгаа бөгөөд 2024 оны 02 дугаар хагаст ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. "Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн "Загийн усны хоолойн ус хангамжийн төсөл"-ийн гүйцэтгэл 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 90.4%-тай байна. "Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн Тавантолгойн нүүрс ачилтын логикийн төвийн гүйцэтгэл 12 дугаар сарын 31-ний байдлаар 84.44%-тай байна. "Тавантолгой дулааны цахилгаан станц төсөл"-ийн ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулан 2023 оны 05 сарын 15-ны өдөр ЭХЯ-ны ШУТЗ-аар батлуулсан бөгөөд эхний шатанд 597.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдахаар байна.	100%

				<p>. Газрын тос дамжуулах хоолойн төслийн гүйцэтгэл 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 38.8%-тай байна.</p> <p>. Засгийн газрын 2017 оны 59 дүгээр тогтоолоор БНЭУ-ын “Экспорт-Импорт банк”-ны зээлээр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийн хүрээнд үйлдвэрт тос дамжуулах хоолой байгуулах төслийн санхүүжилтийг “ЭТТ” ХК-ийн бүтээгдэхүүн урьдчилан борлуулах нөхцлөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэж төслийг хэрэгжүүлж байна.</p>	
20	40	<p>Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12</p>	<p>3. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.</p>	<p>Засгийн газрын хуралдааны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэхь заалт, Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжид заасны дагуу УУХҮ-ийн Сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар тусгайлан эрх олгогдсон зохицуулалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах зорилтыг УУХҮЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.2-т тусган батлуулж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар батлуулсан.</p>	100%
	41		<p>4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.</p>	<p>“Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран баталсан. Түүний дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн төсөл /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулан яамдаас холбогдох саналыг авсан. Ирүүлсэн саналыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгах шаардлагатай зохицуулалтыг тусгасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээс 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/2849 дугаартай албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тухай зөвшөөрөл хүссэн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, бүрдүүлбэрийг ханган ажилласан</p>	70%

			бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	
42		УУХҮЯ хуулийн төсөл 2021. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай Баялгийн сангийн тухай Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хүнд үйлдвэрийг дэмжих тухай	УУХҮ-ийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 15.5-д заасны дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан. Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулж УИХ-ын чуулганы 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. “Газрын тосны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох судалгааг боловсруулсан.	70%
43		УУХҮЯ хуулийн төсөл 2023. Газрын хэвлийн тухай /Шинэчилсэн найруулга/	“Газрын хэвлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Газрын удирдлага болон УУХҮ-ийн Сайдад 2023 оны 02 дугаар сарын 21-ний өдөр танилцуулсан. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга УИХ-аар батлагдсаны дараа хуулийн төслийг оруулна гэж удирдлагаас чиглэл өгч хойшлуулсан.	70%

				<p>УУХҮ-ийн Сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/325 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсантай холбогдуулж ажлын хэсгийн даргаас үүрэг даалгавар авч ажиллаж байна.</p> <p>“Газрын тухай хууль”-ийн багц хуулийн төсөл болон УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэнгийн санаачилсан “Газрын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан холбогдох саналыг бэлтгэн Геологийн бодлогын газрын саналд тусгуулсан.</p>	
21	44	Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай 2021-12-30 Дугаар 2021 №103	<p>1.1/. Оюу толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34 хувь /Эрдэнэс Оюу Толгой ХХК/-д ногдох Оюу Толгой ХХК-иас Туркойс Хилл Ресурсес Лтд-д төлөгдөх 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хуримтлагдаад байгаа нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь тэглэх; (1.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналыг харгалзаж дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:)</p>	<p>1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 174 дүгээр захирамжаар ““Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчилсэн.</p> <p>2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 74 дүгээр тогтоолын 1 дэхь заалтаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Ажлын ерөнхий төлөвлөгөө” батлагдсан. Улмаар дээрх ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Ажлын дэд хэсэг байгуулах тухай” 23 дугаар тушаалаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий “Ажлын дэд хэсэг”-ийг санхүүгийн асуудал хариуцсан, хуулийн асуудал хариуцсан,</p>	100%

			<p>техникийн хамтарсан хэсэгтэйгээр байгуулж, тэдгээрийн ажиллах чиглэлийг заажээ. Уг ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.</p> <p>3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдөр цахимаар, 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр ХЗДХЯ-ны хурлын танхимд, 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит танхим”-д, 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сум “Оюутолгой”ХХК-ийн уурхайд тус тус зохион байгуулсан.</p> <p>4. “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”, 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.</p> <p>5. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.</p> <p>6.ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг 2021 оны 10</p>	
--	--	--	---	--

				<p>дугаар сарын 18-ны өдөр УИХ дахь МАН бүлэгт, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.</p> <p>7. УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолын 1.1-д "... шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах ..." гэсний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс сонгогдсон 3 хуулийн этгээд, 2 зөвлөх тогтоолын хэрэгжилтийг хангуулахад гэрээний үндсэн дээр /нууцлалын/ мэргэшлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажилласан.</p> <p>Улмаар УИХ-ын чуулганы 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанд "Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын багийн хэрэгжүүлж буй ажлын явцын талаарх мэдээллийг танилцуулсан болно.</p>	
45			<p>1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК-ийн хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" болон "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө"-г хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох;</p>	<p>1. "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-нд гарын үсэг зурах эрх олгосон Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 27, 94, 99, 123 дугаартай захирамжуудыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 128/ШШ2019/0808 дугаартай шийдвэрээр илт хууль бус болохыг тус шүүхийн шийдвэрээр тогтоож хүчин төгөлдөр болсон. Уг шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай нэр бүхий иргэдийн хүсэлтийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШТ2021/0090 дугаартай тогтоолоор хангахаас татгалзаж, уг тогтоолыг давж заалдах гомдол гаргах эрхгүй байх заалтыг тусгаж шийдвэрлэсэн.</p> <p>2. 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр</p>	70%

				<p>Хууль зүй, Дотоод хэргийн сайд, ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.</p> <p>3. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.</p> <p>4. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр УИХ дахь МАН бүлэгт, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.</p> <p>5. ДУББСТ, ДУББСНТ-г дуусгавар болгох, цуцлах тухай хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн төсөлд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн зүгээс “ДУББСТ, ДУББСНТ-ийг хүчин төгөлдөр бус болохыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ”-г байгуулах саналыг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, 2022 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр, 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд тус тус “Ажлын хэсэг”-т хүргүүлсэн.</p> <p>6. Уг асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалж, санал дүгнэлтээ гаргах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн тохиролцох ажиллагаа явагдаж байна.</p>	
46			<p>1.3/. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх;</p>	<p>1. “Оюу Толгой” ХХК-аас ирүүлсэн санхүүгийн загварт нарийвчилсан шинжилгээ хийж, гол параметруудийн Монгол Улсын Засгийн газрын төслөөс хүртэх мөнгөн урсгалд нөлөөлөх мэдрэмжийн шинжилгээг хийж, нөлөөллөөр нь эрэмбэлсэн.</p> <p>2. Дээрх судалгаанд үндэслэж Монгол Улсад ногдох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх боломжит хувилбаруудыг боловсруулж, үр</p>	30%

				<p>дүнг тооцоолж, танилцуулга материал бэлтгэж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан.</p> <p>3. Хөрөнгө оруулагчдын хоорондох хэлэлцээрт шаардлагатай мэдээллийг бэлтгэж, Монгол Улсын Засгийн газрын 34 хувийн эзэмшилд ногдох зээлийн үлдэгдлийг тэглэхтэй холбоотой санхүүгийн тооцоолол, мэдээллийг бэлтгэж эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>4. Монгол Улсын Засгийн газарт ногдох 34%-ийн хувьцааны зээлийн өр болох 2,363 сая ам.долларын өр 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр тэглэгдсэнээр Монгол Улсын Засгийн газар төслөөс бодит мөнгөн ногдол ашиг хүртэх нөхцөл бүрдсэн бөгөөд ирээдүйд төслөөс хүртэх өгөөжийн хувь 53%-д хүрэх төсөөлөлтэй байна.</p>	
47			<p>1.4/. Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх;</p>	<p>1. “Оюу Толгой” ХХК-иас ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар 15-ны өдрийн хуралд компанийн 2022-2024 оны санхүүжилтийн төлөвлөгөөг танилцуулсан байна. Үүнд:</p> <p>Төслийн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, үндсэн төлбөрийн төлөлтийг хойшлуулах; Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт хийх; Давуу эрхтэй төслийн зээл нэмж авах зэрэг санхүүжилтийн хувилбаруудыг танилцуулсан.</p> <p>“Эрдэнэс Оюутолгой”ХХК-ийн зүгээс санхүүжилтийн хувилбаруудын нөхцлүүдийг нарийвчлан судалж, урьдчилгаа төлбөрийн гэрээний нөхцөлийг УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолд нийцүүлэх тухай санал боловсруулж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.</p> <p>Уг асуудлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хуралдахаар товлогдсон “Оюутолгой” ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус 45 дугаар хурлын хэлэлцэх асуудалд багтаасан боловч “Оюу толгой” төслийн санхүүжилттэй холбогдуулан танилцуулсан “Урьдчилгаа төлбөрийн гэрээ”-ний нөхцөл нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад: “Оюу толгой төслийн</p>	100%

			<p>гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, “Оюу Толгой”ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх,” гэсэнтэй нийцүүлэх шаардлагыг тавьж, зарим нэмэлт мэдээлэл, санхүүгийн тооцоолол, харьцуулсан судалгаа, холбогдох хариу тайлбартай танилцах тухай ТУЗ-ийн Монголын талын гишүүдийн гаргасан санал, шаардлагын дагуу уг хурал түр завсарласан.</p> <p>“Оюутолгой”ХХК-ийн ТУЗ-ийн Монголын талын гишүүдийн гаргасан саналын дагуу нэмэлт мэдээллийг ирүүлж, хувьцаа эзэмшигчид зарим асуудлыг харилцан тохиролцож, “Урьдчилгаа төлбөрийн гэрээ”-ний нөхцөл болон түүнийг баталгаажуулах ТУЗ-ийн тогтоолд зарим өөрчлөлтүүдийг оруулан шинэчилсэн мэдээллийг ирүүлж, тэдгээрт үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчийн баримтлах удирдамж”-ийн 2-т: “...Урьдчилгаа төлбөрийн гэрээний төсөлд далд уурхайн төсөл тогтвортой үйлдвэрлэлд хүрэх хүртэл урьдчилгаа төлбөрийг хүү, дискаунтаас чөлөөлж, тогтвортой үйлдвэрлэлд хүрсний дараах сараас дискаунт факторын нөхцөл үйлчилж эхэлнэ гэсэн өөрчлөлт оруулсан нь УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын агуулгатай нийцэж байгаа гэж УИХ-ын 2019 оны “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 92 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг үзэж, уг асуудлыг дэмжих үүрэг чиглэл өгсөн тул шинэчлэн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн гэрээг хавсаргаж, урьдчилгаа төлбөрийн гэрээний тухай” тогтоолыг дэмжих” гэсний дагуу ТУЗ-ийн Монголын талын гишүүд “Оюутолгой” ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус 45 дугаар хурал 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр үргэлжлэн хуралдахад дээрх байр суурийг илэрхийлж, “Урьдчилгаа төлбөрийн гэрээ”-ний нөхцлийг баталсан.</p>	
--	--	--	---	--

			<p>УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын дагуу “Оюу Толгой” ХХК нь энгийн хувьцааг 2021 оны 03 дугаар сараас хойш нэмж гаргаагүй.</p> <p>2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хийхээр товлосон “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус 46 дугаар хурлын материалд 1.6 тэрбум ам.долларын “Спонсорын давуу эрхтэй зээл батлах асуудал”-ыг оруулж ирсэн. Үүнтэй холбоотойгоор 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр толгой компани “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн даргаас “Оюу Толгой” ХХК-ийн санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан “Спонсорын давуу эрхтэй зээл батлах асуудал”-аар 1.6 тэрбум /нэг тэрбум зургаан зуун сая/ ам.долларыг бүхэлд нь дэмжихгүй, харин Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ 2023 тодотголыг холбогдох санхүүгийн тооцооллын хамт 2023 оны 06 дугаар сард багтаан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд зохих ёсоор хүргүүлж, хэлэлцүүлэх шаардлага тавьж, “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын 5.1.9. “Хөрөнгө оруулалтын тооцоо, хайгуулын ажлын зардал 20 хүртэл хувийн нарийвчлалтай байна.” гэснийг үндэслэн холбогдох хязгаарын дотор 2023 он дуустал шаардлагатай санхүүжилтийг 580 сая /Таван зуун наяд/ хүртэл ам.доллароор “дэмжих” байр суурийг Монголын талын төлөөлөл илэрхийлэх” гэсэн “Удирдамж” ирсэн. Удирдамжийн дагуу Монголын талын төлөөлөл уг асуудлыг дэмжсэн.</p> <p>2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр “Оюутолгой” ХХК-ийн ТУЗ-өөс 322 дугаар тогтоол баталж, 580 сая ам.долларын “Спонсорын давуу эрхтэй зээл” авахыг зөвшөөрч, “Спонсорын давуу эрхтэй зээлийн гэрээ” болон холбогдох “Спонсорын давуу эрхтэй зээлийн баримт бичиг”-ийг байгуулах эрхийг “Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад олгосон.</p> <p>2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан “Оюутолгой” ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 55-р хурлын үргэлжлэл хурлаар “Оюутолгой төсөл”-д 2024 оны 10 дугаар сар хүртэл шаардагатай нэмэлт санхүүжилтийн хэрэгцээг санхүүжүүлэх</p>	
--	--	--	--	--

				<p>зорилгоор “Спонсорын давуу эрхтэй зээлийн гэрээ”-нд тусгасан Спонсорын давуу эрхтэй зээлийн нийт эрхийн хэмжээг 580 сая ам.доллороос 1,651 сая ам.доллар болгон 1,071 сая ам.доллар (“Спонсорын давуу эрхтэй зээлийн нэмэгдүүлсэн хэмжээ” гэх)-оор нэмэгдүүлсэн.</p> <p>Монголын талын хувьцаа эзэмшигчийн хувьд буюу “Эрдэнэс Оюутолгой”ХХК-ийн хувьд уг санхүүжилтийг хууль тогтоомжид нийцэхгүй үндэслэлээр дэмжихгүй байх байр суурьтай байж, түүнийгээ “Эрдэнэс Монгол”ХХК-ийн ТУЗ-д илэрхийлж, “Эрдэнэс Монгол”ХХК-ийн ТУЗ-өөс өгсөн “Спонсорын давуу эрхтэй зээл”-ийг дэмжихгүй байх удирдамжийг хэрэгжүүлж ажилласан.</p>	
48			<p>1.5/. Оюу Толгой ХХК-ийн засаглалыг сайжруулах, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах, ус ашиглалт, байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;</p>	<p>“Оюутолгой” ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 274 дүгээр тогтоолоор “Оюутолгой”ХХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдал болон байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах үүднээс “Эрдэнэс Оюутолгой”ХХК-иас дэмжлэг авч, хамтран ажиллахыг даалгасан. Дээрх тогтоолын дагуу “Эрдэнэс Оюутолгой”ХХК болон “Оюутолгой” ХХК-иудын хооронд байгуулсан “Байгаль орчин, нийгэм, засаглалын түншлэлийн гэрээ”-ний төсөлд холбогдох санал дүгнэлтийг боловсруулж, хүргүүлэн ажилласан бөгөөд тус гэрээний хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 198 дугаар тушаалаар байгуулагдсан “Оюутолгой төсөл”-тэй холбоотой ажлын хэсгийн төлөөллүүд, “Усны газар”, “Эрдэнэс Оюутолгой”ХХК хамтран “Хэрлэн-Тооно төсөл”-ийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын ерөнхий даалгаврыг боловсруулж “Усны газар”-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 23/01 тушаалаар батлуулсан. Тухайн ажлын ерөнхий даалгаврыг нарийвчлан боловсруулах шаардлага үүсэж, “Оюутолгой”ХХК-иас саналыг тусган ажлын нарийвчилсан даалгаврыг боловсруулан 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр “Усны газар”-аар батлуулсан.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд “Оюу Толгой”ХХК-иас “Эрдэнэс Оюу Толгой”ХХК-д ирүүлсэн 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Ор/2082 дугаартай албан бичигт:</p> <p>“Эрдэнэс Оюу Толгой”ХХК (эсвэл Усны газар) ажил гүйцэтгэх гэрээт компанийг сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, улмаар шалгарсан этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээг</p>	100%

			<p>байгуулах нь зүйтэй гэж бид үзэж байна. Учир нь “Хэрлэн-Тооно төсөл”-ийг Засгийн газар санаачилж, Засгийн газрын бодлогын түвшинд олон тооны баримт бичигт тусгагдсан ба Усны газар нь энэхүү “Хэрлэн-Тооно төсөл”-ийг захиалагч гэж ойлгож байна. Төслийг амжилттай дуусгахад санхүүжилтийг зохих ёсоор зарцуулж байгаад хяналт тавих үүднээс сонгон шалгаруулалтын процесст “Оюу Толгой” ХХК-ийн төлөөллийг оролцуулах саналтай байна.</p> <p>“Оюу толгой” ХХК нь “Хэрлэн-Тооно төсөл”-ийн ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулах төсөлд санхүүжүүлэгчийн хувиар оролцож байгаа. Иймд “Оюутолгой” ХХК нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан төлбөрийн хуваарьт үндэслэн гэрээт компанид төлбөрийг шууд төлнө. Энэ хүрээнд захиалагч, шалгарсан гэрээт компанитай гурван талт гэрээ байгуулах боломжтой.”</p> <p>гэсний дагуу цаашид “Хэрлэн-Тооно төсөл”-ийн ТЭЗҮ-ийн тодотгол болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотойгоор “Эрдэнэс Оюутолгой” ХХК дараах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:</p> <p>“Хэрлэн-Тооно төсөл”-ийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах ажлын гэрээт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, сонгон шалгаруулсан этгээд болон “Оюутолгой” ХХК-тай санхүүжилтийн талаар гэрээг байгуулах;</p> <p>Дээрх сонгон шалгаруулсан гэрээт гүйцэтгэгчийн ажилд хяналтыг хэрэгжүүлэх зэрэг болно.</p> <p>Эрчим хүч: “Оюу Толгой” ХХК нь “Оюутолгой төсөл”-ийн талбайгаас Монгол Улсаас Хятад Улсын хил хүртэлх 220 киловольт хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугамыг барьж, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрчим хүчний компанитай 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр “Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” (ЭХХХАГ)-г байгуулсан бөгөөд 2017 оны 07 дугаар сард дахин 6 (4+2) жилээр үргэлжлүүлэн сунган эрчим хүч импортолж байна. Тус гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүртэл 6 (зургаан) жил, эрчим хүчний үнийг 10.1 цент/кВт цаг (өнөөгийн ханшаар)-аар тохирсон байдаг. 2023 оны 7 дугаар сард дуусгавар болох байсан дээрх гэрээг сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулсан нь “Оюутолгой” ХХК-ийн эрчим хүчний найдвартай байдалд нэн чухал шаардлагатай байсан бөгөөд</p>
--	--	--	--

				<p>хэлэлцээр хийсний үр дүнд талууд 2023 оны 05 дугаар сарын 18-нд тохиролцож, импортын эрчим хүчний гэрээг 2026+2+2 жил хүртэл сунгасан.</p> <p>Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2020 оны 217 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон “Оюутолгой” ХХК нь хамтран ажиллаж ХӨОГ-ний 7.3.3-т заасны дагуу Монгол Улсын Нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээний төслийг харилцан тохиролцсон байдаг. Улмаар 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс “Оюу Толгой” уурхайг урт хугацаанд “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-г “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ”ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болон “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулагдаад байна.</p>	
49			<p>1.6/. татварын актуудын биелэлтийг хангуулах, цаашид нэг мөр ойлгож дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх.</p>	<p>“Татварын актуудын биелэлтийг хангуулах, цаашид нэг мөр ойлгож дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх” тухай заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд:</p> <p>Дотоодын шүүхийн маргааны талаар: Татварын улсын байцаагч нар “Оюу Толгой”ХХК-ийн 2013-2015 оны татварын жилд хамаарах зохих тайлан, санхүүгийн баримт, татварын тайлагнал, төлөлтөд хяналтыг хэрэгжүүлж 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн №367201801 дугаартай “Шийтгэлийн хуудас”-аар 377.1 тэрбум төгрөгийн татвар, торгууль, болон алданги ногдуулсан. Түүнчлэн, татварын улсын байцаагч нар “Оюу Толгой”ХХК-ийн 2016-2018 оныг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд /Эрсдэлд суурилсан/ татварын хяналт шалгалт хийж, 432.7 тэрбум төгрөгийн нөхөн татвар, 130 тэрбум төгрөгийн торгууль, 86.6 тэрбум төгрөгийн алданги, нийт 649.4 тэрбум төгрөгийн төлбөр төлүүлэхээр 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №36191100046 дугаартай “Нөхөн ногдуулалтын акт” үйлдэж, “Оюу Толгой” ХХК-д хүргүүлсэн. “Оюу Толгой”ХХК нь 2013-2015 оны татварын жилд хамаарах шийтгэлийн хуудаснаас 359.7 тэрбум төгрөгийг эс зөвшөөрч Нийслэл дэхь “Захиргааны хэргийн анхан шатны шүүх”-д нэхэмжлэл гаргаж;</p> <p>“Анхан шатны шүүх”-ийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 0336 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож буюу шийтгэлийн хуудсаар</p>	70%

			<p>оногдуулсан төлбөрөөс 5.8 тэрбум төгрөгийн хүү, торгуулийг “Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамааруулж, шийтгэлийн хуудсаар оногдуулсан төлбөрийн хэмжээг бууруулж;</p> <p>“Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх”-ийн 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 393 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн 5.8 тэрбум төгрөгийн хүү, торгуулийг өршөөлд хамруулж, төлбөрийн хэмжээг бууруулж шийдвэрлэснийг “...ногдуулсан торгууль, алдангиас 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд хамаарах хэсгийг өршөөн хэтрүүлсүгэй.” гэж өөрчлөн, шийдвэрийн тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхиж;</p> <p>“Улсын дээд шүүх”-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 136 дугаар тогтоолоор анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж тус тус шийдвэрлэсэн.</p> <p>Арбитрын шүүхийн маргааны талаар: “Оюутолгой” ХХК нь 2013-2015 оны татварын жилд хамаарах “Шийтгэлийн хуудас”-тай холбоотойгоор “UNCITRAL-ийн дүрэм”-ийн дагуу Лондонгийн олон улсын арбитраж Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр арбитрын мэдэгдэл (нэхэмжлэл) гаргаж, 2016-2018 онд хамаарах “Нөхөн ногдуулалтын акт” нь өмнөх актын үргэлжлэл буюу асуудлууд нь олон улсын арбитраж хандсан асуудлуудтай үндсэндээ ижил төстэй, зарим нь адилхан байгаа гэж үзэж олон улсын арбитрын шүүхэд явагдаж буй ажиллагаанд нэмж оруулах буюу нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх хүсэлтийг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр гаргасан. Өөрөөр хэлбэл, “Оюутолгой” ХХК нь татварын улсын байцаагчдын “шийтгэлийн хуудас”-т холбогдох татварын маргааныг Монгол Улсын “Татварын тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-иудын хүрээнд дотоодын шүүхэд болон төсөлд холбогдох гэрээнүүдийн маргаан шийдвэрлэх аргачлалын дагуу “Арбитрын шүүх”-д давхардуулан хандсан ба холбогдох мэдээллийн талаар товч дурдвал:</p>	
--	--	--	--	--

Лондонгийн олон улсын арбитраж холбогдох 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Арбитрын мэдэгдэл”, 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн “Нэхэмжлэлийн мэдүүлэг”-ийг тус тус хүлээн авч, тэдгээрт хариу тайлбар өгөх асуудлаар “Ажлын хэсэг” байгуулагдсан. Үүнд: Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар захирамжаар Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитраж маргааны хууль зүйн үндэслэлийг судалж, холбогдох тайлбар, нотлох баримтыг гарган нэхэмжлэлийн шаардлагыг няцааж, Засгийн газрын байр суурь, чиглэлийг хамгаалах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд Ерөнхий сайдын захирамжуудаар тус “Ажлын хэсэг”-т нэмэлт, өөрчлөлт оруулж, “Ажлын хэсэг”-ийн ахлагчаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар ажилласан. Энэхүү ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 73 дугаар захирамжаар шинэчилж, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо ажиллаж байна.

Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан дээрх ажлын хэсэгт “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал гишүүнээр ажиллаж, хариу тайлбарын төсөлд саналаа тусгуулах, орчуулгын ажлыг зохион байгуулах, шаардлагатай баримт, мэдээлэл, судалгаа, тооцоолол, танилцуулгыг бэлтгэх, боловсруулах, хүргүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, Арбитрын бүрэлдэхүүний гаргасан маргаан шийдвэрлэх хуваарь ёсоор нэхэмжлэлийн хариу тайлбар, сөрөг нэхэмжлэлийг “UNCITRAL-ийн дүрэм”-ийн дагуу Лондонгийн олон улсын арбитраж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргах, хүргүүлэхэд шаардлагатай баримт мэдээлэл, судалгаа, тооцоолол, танилцуулгыг боловсруулах, Монголын талд үйлчилгээ үзүүлэгч хуулийн фирмээс ирүүлсэн асуултад хариулт бэлтгэх, хариу тайлбар боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгээд байна. Сөрөг нэхэмжлэлийн шаардлагад “Рио Тинто, Туркойз Хилл Ресурсэс компани” гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн байж болзошгүй, “Оюутолгой төсөл”-тэй холбогдуулж нийтийн албан тушаалтнууд хууль зөрчин, эрх мэдлээ урвуулан ашиглах замаар гадаадын хөрөнгө оруулагч талд илт давуу байдал олгосон байж болзошгүй зэрэг асуудлыг хамруулан авч үзэж байна.

				Арбитрын маргааныг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийн дагуу 2023 оны 08 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл 12 сарын хугацаагаар түдгэлзүүлснийг 2023 он дуустал дахин түдгэлзүүлсэн бөгөөд тус маргаантай холбоотой асуудал үргэлжилж байна.	
	50		2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолыг хэрэгжсэн гэж үзсүгэй.	УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэхь заалт бүрэн хэрэгжиж, тогтоолд заасан үр дүнг нэгтгэн үнэлсний дараа уг заалтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх боломж бүрдэнэ.	Х.Б
22	51	Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2022-01-18 Дугаар 2022 №08	1.1/. Ашигт малтмалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/; Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:	Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран баталсан. Түүний дагуу "Ашигт малтмалын тухай хууль"-ийн төсөл /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулан яамдаас холбогдох саналыг авсан. Ирүүлсэн саналыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгах шаардлагатай зохицуулалтыг тусгасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээс 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/2849 дугаартай албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тухай зөвшөөрөл хүссэн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, бүрдүүлбэрийг ханган ажилласан бөгөөд УИХ-ын 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	70%
23	52	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2022-07-05 Дугаар 2022 №46	1/. паркийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зориулалтаар жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;	УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль"-д заасны дагуу компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан паркийн ҮТП-ийн дэд бүтэц, нэгж үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт бүрэн хийгдэж, үйл ажиллагааг эхлэн, төсөвт орлого төвлөрүүлж эхлэхэд паркийн үйл	70%

				<p>ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зориулалтаар жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна. “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль” хүчин төгөлдөр болсноос хойш Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 267 дугаар тогтоолоор "Инфинити спейс" ХХК-д “Алтанширээт” ҮТП, "Си Өү Эй Эл" ХХК-д “Гэрэлт говь” ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 15 жилийн хугацаагаар олгосон бөгөөд “Алтанширээт” ҮТП-ийн бүтээн байгуулалтын ажил 45%, “Гэрэлт говь” ҮТП-ийн бүтээн байгуулалтын ажил 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Тус паркууд бүрэн ашиглалтад орж үйл ажиллагаа жигдэрснээр экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, улс, орон нутгийн татварын орлогыг жил бүр дунджаар 370 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, орон нутагт 2400 орчим шууд ажлын байрыг шинээр бий болгох зэрэг эдийн засаг, нийгмийн олон чухал ач холбогдолтой юм.</p>	
53		2/Үйлдвэрлэл, технологийн паркийн хууль, эрх зүйн зохицуулалт, татварын орчны талаарх танилцуулга, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах.		<p>“Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулгыг хүнд болон хөнгөн үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэл, технологийн паркийн төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдыг оролцуулан 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УУХҮЯ-ны хурлын танхимд зохион байгуулсан. Мөн “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/ болон холбогдох хуулийн эмхэтгэлийг УУХҮЯ-ны цахим хуудсанд 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр байршуулсан. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/ болон бусад хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн танилцуулгыг 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Орхон аймгийн иргэдэд танилцуулсан. 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Дорноговь аймагт зохион байгуулагдсан “Нээлттэй Дорноговь” чуулганы үеэр Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”</p>	100%

				/шинэчилсэн найруулга/ болон бусад хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг талаар Дорноговь аймгийн иргэдэд танилцуулж сурталчилсан.	
24	54	Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай 2022-11-11 Дугаар 2022 №68	1. Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, нөөц бүрдүүлэх нөхцөл үүссэн тохиолдолд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор 2023 онд багтаан эргэн төлөх нөхцөлтэй хийгдэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах.	Тус тогтоолоор Засгийн газарт “Өрийн баталгаа” гаргах зөвшөөрөл олгосны дагуу өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн үнийг тогтворжуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай” 160 дугаар тогтоолыг батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкуудаас олгох зээлийн үнийн дүнгийн 85 хүртэлх хувийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зээл олгуулах ажлыг Сангийн яам болон Монголбанк, арилжааны банкуудтай хамтран зохион байгуулсан. Үүний үр дүнд өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн жижиглэн борлуулалтын үнэ 2390 төгрөгөөр тогтвортой хэвээр байна.	100%
25	55	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл байхгүй болно.	Х.Б
	56		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн дагуу шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах төсвийн төсөлд тусган ажиллаж байна. УУХҮСайдын 2023, 2024 оны багцад улсын төсвийн хөрөнгө оруулалт батлагдаагүй.	Х.Б

26	57	<p style="text-align: center;">ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-12 Дугаар 2023 №06</p>	<p>1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нүүрсийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим системээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаатай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг баталж, мөрдүүлэх;</p>	<p>Монгол Улсын Засгийн газар 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа"-г "Монголын хөрөнгийн бирж"ТӨХК-аар гүйцэтгүүлэх тухай" 59 дүгээр тогтоолыг баталсан.</p> <p>"Монголын хөрөнгийн бирж"ТӨХК-иас уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжихтай холбоотой "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам", "Биржийн зах зээлийн зарим оролцогчийг итгэмжлэх, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах журам", "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам", "Нүүрсний арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам"-ыг, СЗХ-оос уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжихтай холбоотой "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам", "Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг тус тус баталсан.</p>	100%
	58		<p>1.2. Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтэц /итгэмжлэгдсэн лаборатори, агуулах, терминал, тээвэр логистикийн төв/-ийг бий болгох;</p>	<p>Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоолоор "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал"-ыг баталсан. "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт " Биржийн үйл ажиллагаанд ашиглагдах энэ хуулийн 5.3.2-т заасан агуулах, терминал, тээвэр логистикийн төв, шинжилгээний лабораторийг бирж нь бүртгэж, итгэмжлэл олгосноор үйл ажиллагаандаа ашиглана" гэж заасны дагуу биржээс нийт 12 агуулах терминал, 3 лаборатори, 32 тээвэр ложистикт итгэмжлэл олгосон.</p>	100%
	59		<p>1.3. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын</p>	<p>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл</p>	70%

			хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах.	ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах. Тогтоолын хүрээнд УУХҮЯ-ны төлөөлөл “Эрдэнэс Ай Ти” консорциумийн хөгжүүлсэн биржийн арилжааны платформийн хөгжүүлэлт, дэд бүтэц, технологийн шийдэлтэй танилцан, санал солилцож, УУХҮ-ийн Сайд болон МХБ-ийн удирдлагуудад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулсан.	
27	60	НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-19 Дугаар 2023 №08	1.а. а/Нүүрсний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаанд гарсан зөрчлүүдэд дүн шинжилгээ хийн, шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Нүүрсний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг эрхлэх асуудлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Боомтын сайд, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг байгууллагууд хариуцан ажиллаж байна.	70%
	61		1/б. б/Нүүрсний тээвэрлэлт, экспортын асуудлаарх Засгийн газрын шалгалтын ажлыг эрчимжүүлж, Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаатай уялдуулах, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл харилцан солилцох, нүүрсний тээвэрлэлт, экспортын хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүйгээр шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах;	Нүүрсний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг эрхлэх асуудлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Боомтын сайд, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг байгууллагууд хариуцан ажиллаж байна.	70%
	62		1/в. в/Байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударгаар хүртээх, баялгийн ашиглалт, хуваарилалтын ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх, 1991	1.“Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл болон “Хөгжлийн сангийн тухай хууль”-ийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр	Х.Б

		<p>онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судлан үзэж, саналаа Улсын Их Хуралд танилцуулах;</p>	<p>нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, УИХ-д уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан УИХ-д өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн.</p> <p>2.Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан ажиллаж байна.</p>	
63		<p>З/б. Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой оффтейк гэрээнүүд, түүнийг нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг</p>	<p>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/693 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс компанийн ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой төрийн болон албаны нууцад хамааралтай гэрээний хууль зүйн үндэслэлд шинжилгээ хийж, нууцаас гаргах талаарх дүгнэлт, Засгийн газрын тогтоолын төслийг хүргүүлэн батлуулж, нууцаас гаргасан. Нууц гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн www.ett.mn сайтад байршуулан олон нийтэнд хүргэсэн. Мөн Эдийн засаг, хөгжлийн яамны нууц хамгаалах</p>	100%

			хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд ил тод болгох;	ажилтанд 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 171 гэрээ, “Монголросцвет” ТӨҮГ-ын 18 гэрээ, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 27 гэрээ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн 6 гэрээ, нийт 222 гэрээг зохих журмын дагуу хүргүүлсэн.	
	64		3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх;	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-т заасан “Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина” гэж заасны дагуу экспортод гаргах бүтээгдэхүүнээ заавал биржээр арилжих үүргийг хүлээж байна.	100%
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
28	65	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.20. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллахыг салбарын 3 тал хэлэлцээрт тусгасан. Салбарын 2021-2022 оны 3 талт хамтын хэлэлцээрийг “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 15.4 дэхь хэсэгт заасны дагуу 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр бүртгэж авсан. Аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хэрэгжилтийг жил бүр дүгнэж байна. “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” УУХҮ-ийн Сайдын 2018 оны 06 дугаар албан даалгавар гарсан. Албан даалгаврыг аймаг нийслэлийн засаг дарга нар, байгууллага аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. УУХҮ-ийн Сайд болон Аймаг нийслэлийн засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжилтийг хангаж ажиллах, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахаар тусгасан. Энэхүү заалт нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар “Бичил уурхайн талбайд 18 нас хүрээгүй иргэнийг оруулахгүй байх” гэж тусгасан байдаг. Насанд	100%

				хүрээгүй хүнийг хөдөлмөр эрхлүүлсэн зөрчил 2023 оны байдлаар гараагүй байна.	
29	66	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу тус яам болон ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн (BGR)-ийн хамтын ажиллагааны хүрээнд АМГТГ-т ашиглагдаж буй Уул уурхайн кадастрын систем, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө тайлангийн цахим систем /e-reporting/ гэсэн 2 үндсэн цахим мэдээллийн системийг өргөтгөн сайжруулах, уялдаа холбоог нь хангах, цахим хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгжид мэдээлэл, лавлагаа хүргэх, төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбох зэрэг ажлуудыг хийж эхлээд байна.	70%
30	67	Чиглэл өгөх тухай 2018-10-30 Дугаар 2018 №32 ЭЗБХ	2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын улсын хилийн зурваст газрын тосны шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг баталсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тус 2 боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад "Шунхлай" ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №21, №22 дугаартай гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Өнөөгийн байдлаар Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрлах Гашуунсухайт хилийн боомт дахь газрын тосны бүтээгдэхүүний 8600м3 багтаамжтай, жилд 350-400 мянган тонн бүтээгдэхүүн шилжүүлэн ачих хүчин чадал бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төслийн ажлын гүйцэтгэл 90 хувь, инженер, геологийн судалгааны ажил 100 хувь, өндөршилт, нягтруулалт тэгшилгээний ажил 60 хувь, савны материал худалдан авалтын гүйцэтгэл 100 хувьтай үргэлжилж байна. Харин Өмнөговь аймгийн Гурван тэс суманд байрлах Шивээхүрэн хилийн боомт дагуу 1200м3 багтаамжтай, жилд 50-60 мянган тонн	100%

				газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих хүчин чадал бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын байгууламжийн гүйцэтгэлийн явц 90 хувь, авто замын төлөвлөлт, гүйцэтгэлийн ажил 70 хувьтай үргэлжилж байна. Төслийн гүйцэтгэлд АМГТГ тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.	
31	68	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019 №04 ЭЗБХ	2.4/. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтын 7 дахь дэд заалтад заасан эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлж, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих чиглэлээр хувьцааны болон зээлийн хөрөнгө оруулалтыг хийх.	УУХУ-ийн Сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хяналтаас хасуулах саналтай.	Х.Б
32	69	Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБХ/ 2019-05-28 Дугаар 2019 №04/01	1.1/. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах;	“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн. “Тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын дагуу гэрээ байгуулсан 22 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Туул голын сав газарт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн газрын судалгааг “Инженер геодези”ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 29750 мян/төг-ийн санхүүжилтээр хийлгэхэд 668 байршилд 7940.2 га талбай эвдрэлд өртсөн гэсэн судалгаа гарсан. Иймээс дээрх талбайд үе шаттайгаар нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байна. Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд 2023 онд хяналт шалгалт хийгээгүй болно.	30%

33	70	Ноос ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-04-06 Дугаар 2021 №02 ҮББХ	4. 4/Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.	УУХҮЯ-ны чиг үүрэгт хамааралгүй.	Х.Б
34	71	Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар 2021-10-05 Дугаар 2021 №04 ҮББХ	1. "МУИХ-аас баталсан ""Алсын хараа-2050"" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай"", МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай"" МУИХ-ын тогтоолд тусгагдсан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУЗГ-т чиглэл болгосугай. 1/Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг батлан мөрдүүлэх;"	Журмын төслийг Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 241 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
	72		2. Түүхий тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх;	Газрын тос дамжуулах хоолойн төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор төсөлд шаардагдах санхүүжилтийг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг зөвшөөрсөн. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч "МГТБҮ" ТӨХХК, Ерөнхий гүйцэтгэгч "Norinco International Cooperation" компани, санхүүжүүлэгч "ЭТТ" ХК, захиалагч УУХҮЯ хооронд 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр гэрээ байгуулж төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн.	100%
	73		3. Төслийн барилга, бүтээн байгуулалтын үе шатанд БНЭУ-аас нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний хэмжээг бууруулж, шардлагатай бараа материалыг хөрш орноос нийлүүлэх, дотоодын аж ахуйн	Зээлдүүлэгчийн талаас төсөлд нийлүүлэх бараа, материалын хувийг бууруулах талаар төсөл хэрэгжүүлэгчээс Энэтхэгийн талд хүсэлт тавьж, 2019 онд 75%-аас 65%, 2022 оны 03 дугаар сард I, II багцыг 65%-аас 55%, 2022 оны 05 дугаар сард II, III, IV дүгээр багцыг 50% болгож бууруулсан.	30%

		нэгж, үйлдвэрлэгчдийг төсөлд оролцох боломжийг нэмэгдүүлэх талаар БНЭУ-ын Засгийн газартай хамтран ажиллах		
74		4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга, бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай техник, тоногтөхөөрөмж, бараа материалыг импортлоход учирч байгаа хүндрэлийн талаар БНЭУ, БНХАУ-ын Гадаад харилцааны яамтай ярилцаж, шийдвэрлэх;	Цар тахлаас үүдэлтэй бараа материалын тээвэрлэлтэд үүссэн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх талаар Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгуулж шаардлагатай мэдээ мэдээллийг Шадар сайд, УУХҮЯ, ГХЯ, ЗТХЯ, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Худалдаа, эдийн засгийн атташе, Тяньжин боомт дахь Монгол улсыг хариуцсан БНХАУ-ын холбогдох албан тушаалтнуудад тухай бүр хүргүүлж, тулгамдсан асуудлуудыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран шийдвэрлэж ажилласан. Сангийн сайдын баталсан журмын дагуу төслийн хүрээнд импортлох бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд тухай бүр уламжлан хүргүүлж байна.	100%
75		5. Газрын тосны тухай хуульд заасны дагуутүүхий тосыг газрын тосны үйлдвэрт тэргүүн ээлжинд нийлүүлэх талаар газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй гэрээ, хэлцэл байгуулах;	“Газрын тосны тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх гэж Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулсан заалттай. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаарх ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний 96 дугаар захирамж гаргуулсан ба уг ажлын хэсгийг мэдээллээр ханган ажиллах дэд ажлын хэсгийг УУХҮ-ийн Сайдын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. Дэд ажлын хэсгийн хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай эхний яриа хэлцэлийг эхлүүлээд байна. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай гэрээ шинэчлэх талаар хэлэлцээрийг эхлүүлэх тухай албан бичгийг тус компанид хүргүүлээд байна. Дэд ажлын хэсгийн хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай 3 удаа уулзалт зохион байгуулж, Тосон-Уул ХИХ, Тамсаг ХХИ талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээг “Газрын тосны тухай хууль”-д нийцүүлэх талаар, мөн гэрээг шинэчлэхтэй холбогдуулан дэвшүүлэн тавьсан үндсэн дөрвөн асуудлын хүрээнд эдийн	70%

				засгийн харьцуулсан тооцооллыг хоёр тал гүйцэтгэж УУХҮ-ийн Сайдад танилцуулсан. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай гэрээ шинэчлэх талаар хэлэлцээрийг эхлүүлэх тухай албан бичгийг тус компанид хүргүүлж, толгой компани болох БНХАУ-ын “Синопек групп”-ын төлөөлөлтэй 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр уулзалт зохион байгуулж, гэрээг шинэчлэх талаар хэлэлцэв.	
	76		6. Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх замаар үйлдвэрийн түүхий эд, баталгаат нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, үүнтэй холбогдон гарах хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх	УУХҮ-ийн Сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/247, А/248, А/249 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Газрын тосны хайгуулын 15 (5, 5, 2, 1, 1, 1) талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Номгон IX, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII, Борзон VII талбайнуудад аж ахуй нэгжүүд захиалга ирүүлсэн. Тус 4 талбайд “Газрын тосны тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн дагуу ажлын хэсэг байгуулан ажиллаж ялагчийг тодруулан, “Бүтээгдэхүүн хуваах гэрээний төсөл”-ийг гэрээлэгчтэй хэлэлцэн тохиролцоод яамдуудаас санал авах шатанд байна. Уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хангалттай биелүүлсэн гэж дүгнэгдсэн Төв XXXVI талбайд “Юу Жи Эс”ХХК-тай, Ачит XXXVII талбайд “Тэмүүжин металс”ХХК-тай тус тус “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулахаар гэрээлэгч нартай тохиролцож гэрээний төсөлд холбогдох яамдуудаас санал авч байна. 2017 онд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан Гурванбаян ХХХ талбайд ялагчаар шалгарсан “Баянпетролиум”ХХК-ийн шүүхийн маргаан шийдвэрлэгдэж, яамдаас дахин санал авсан. Гурванбаян ХХХ, Дарьганга XXIV, Эрлийн гэрээнээс шилжиж буй “Юу Жи Эс”ХХК-ийн Төв XXXVI талбайнуудын “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний саналыг яамдаас авч дуусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	70%
35	77	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19	1.1/. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир,	Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/113 дугаартай бие бялдрын сорил авахад хамтран ажиллах тухай албан бичгийг ирүүлсэн. Хүсэлтийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан хаагчдыг бие бялдрын сорилд хамруулж идэвхтэй оролцсон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаас 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1921 дугаартай Засгийн газрын цом 2023 спортын тэмцээнд оролцох тухай албан бичгийг ирүүлсний дагуу тус тэмцээнд багаараа амжилттай оролцсон.	100%

		Дугаар 2021 №8 БСШУСБХ	спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах;		
36	78	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №06 ҮББХ	1. Таван толгойн нүүрсний ордыг ашиглах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, 2018 оны 73 дугаар тогтоол болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дараах төсөл, хөтөлбөрүүдийг шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/ нүүрсний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төслүүд (чингэлэгт тээврийн терминал, жолоочгүй тээврийн хэрэгсэл, дүүжин тээвэр, конвейерийн систем);	Засгийн газрын 2021 оны 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хилийн Гашуунсухайт боомтод чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулсан. Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Хилийн “Гашуунсухайт боомт”-д чингэлэгт тээврийн терминал, автомат удирдлагатай жолоочгүй тээврийн хэрэгсэл AGV зэрэг нь ашиглалтад орж, экспортын үйл ажиллагаа гүйцэтгэж байна.	100%
	79		2. Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд (Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, нүүрс ачилтын байгууламж, холболтын болон хилийн төмөр зам	Тус яам нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үүргийг 2018-2021 оны хооронд гүйцэтгэж байсан. УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.6.1.1.“Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ” гэж тусгагдсан. Энэ хүрээнд Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан "Тавантолгой төмөр зам" ХХК, Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан "Зүүнбаян	100%

				<p>төмөр зам” ХХК-иудад шаардагдах хөрөнгө оруулалтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас ТУЗ-ийн шийдвэрийн дагуу олгож Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулсан. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 104 дүгээр тушаалаар “Төмөр замын холболтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх”, “Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны хэлэлцээ хийх, төслийг тохирох”, “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих, үүнтэй холбоотойгоор хилийн түр гарц нээх, журам тогтоох асуудлаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл”-ийг Хятадын талтай хэлэлцэн тохиролцох” үүрэг бүхий 3 дэд ажлын хэсэг байгуулагдан, холбогдох хэлцлүүдийг хийн ажиллаж байна.</p>	
80		3. Үйлдвэрлэлийг дэмжих нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүд (Тавантолгой цахилгаан станц, нүүрс баяжуулах, кокс-химийн, төрөл бүрийн сайжруулсан түлшний үйлдвэр, метан хийн болон дамжуулах хоолойн төслүүд, тэдгээртэй холбоотой бусад барилга байгууламж);	<p>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй А6/20 хөтөлбөрт Кокс, эрчим хүчний үйлдвэрийн төсөл тусгагдсан бөгөөд үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд:</p> <p>Багануурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах стратегийн ач холбогдол бүхий “Нүүрс, химийн технологи-эрчим хүчний цогцолбор” төслийг хэрэгжүүлэгч “Тавантолгой түлш” ХХК болон төсөл боловсруулагч тал болох “Евро азиа майнз” ХХК-иас 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 25/23 дугаар, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03/694 дугаар албан хүсэлт тус тус ирүүлснийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/229 дугаар тушаалаар Төслийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчдийн хэсэг байгуулагдан 2023 оны 09 дүгээр сарын 27, 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрүүдэд тус тус дүгнэлт, зөвлөмж гаргасан.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаанаар 2019 оноос 2023 оны жилийн эцэс хүртэл нийт</p>	100%	

				<p>Кокс-химийн үйлдвэрийн 10 ТЭЗҮ-ийг хэлэлцэж, хүлээн авсан байна. Үүнд:</p> <p>“Ти ти си өү кей и” ХХК-ийн Дорноговь аймаг, Сайншанд суманд хэрэгжүүлэх “Кокс боловсруулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ (2 сая. тн/жил);</p> <p>“Тавантолгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн суманд хэрэгжүүлэх “Металлургийн коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ (500 мян.тн/жил);</p> <p>“Таван толгой транс” ХХК-ийн Өмнөговь аймаг, Баян-Овоо сум Зайрмагтайн хөндийд “Кокс үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр”-ийн ТЭЗҮ (246 мян.тн/жил);</p> <p>“Баян кокс энерги” ХХК-ийн Төв аймгийн Баян сумын нутагт хэрэгжүүлэх “Кокс-химийн үйлдвэр”-ийн ТЭЗҮ;</p> <p>“Энерги ресурс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Ухаа худаг ордыг түшиглэн байгуулах “Коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ /1 сая.тн/жил/;</p> <p>“Ян сарьдаг оргил” ХХК-ийн Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт хэрэгжүүлэх “Нүүрс баяжуулах болон металлургийн коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ /1.9 сая.тн/жил/;</p> <p>“Винсолд Интернэйшнл” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжүүлэх “Нүүрс баяжуулж, кокс-эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ (1 сая.тн/жил нүүрс баяжуулж, 450 мян.тн/жил кокс-эрчим хүч);</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр”-ийн ТЭЗҮ (2 мян.тн/жил нүүрс боловсруулж, 950 тн/жил диметилийн эфир);</p> <p>“Хөх тэнгэрийн мөнхийн гэрэл” ХХК-ийн Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлэх “Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр”-ийн ТЭЗҮ (66 мян.тн/жил);</p> <p>“Хотын түлш”ХХК Улаанбаатар хотын Налайх дүүрэгт “Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ;</p> <p>“Лузерн Эм Кей”ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт хэрэгжүүлэх “Шахмал түлшний үйлдвэр”-ийн ТЭЗҮ /жилд 80.0 мян.тн//.</p>	
--	--	--	--	--	--

			Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийг байгуулсан. Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /СМЕС/ боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 01-ий өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" Ltd шалгарч 2022 оны 04 дүгээр сарын 14-нд ЕРС гэрээг байгуулсан. 2023.12.31-ний өдрийн байдлаар төслийн гүйцэтгэл 65%-тай байна.	
81		6. Ил уурхайн ашиглалтын өртөг, зардлыг бууруулж, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлд далд уурхайн ашиглалтын технологийг нэвтрүүлэх боломжийг судлах	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Тавантолгой ордыг далдаар ашиглах урьдчилсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Далд уурхайн хайгуул, судалгааны өрөмдлөг цооногийн геофизикийн ажил, нүүрсний болон чулуулгийн физик, механикийн шинж чанар тодорхойлуулах ажил хүлээгдэж байна. Засгийн газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК-д "Онцгой дэглэм" тогтоосонтой холбогдуулан уг ажлын санхүүжилт зогссон тул биелэлт гаргах боломжгүй байна.	70%
82		2. Эрдэнэс-Тавантолгой хувьцаат компанийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг энэ тогтоолын 1 дэх	"Эрдэнэс-Тавантолгой"ХК нь 2021 онд стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой 2 их наяд хүртэлх	100%

			<p>заалтад тусгагдсанаар хязгаарлаж, тэдгээрийг тус компанийн борлуулалтын 1 орлого болон гадаад, дотоод зах зээлд үнэт цаас гаргах, зээл авах, нүүрс урьдчилан борлуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай зээл авах</p>	<p>төгрөгийн болон ам.долларын бонд гаргах хүсэлтийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлж Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо хянаж, холбогдох зөвшөөрлийг олгосны үндсэн дээр 2 удаагийн арилжааг хийж нийт 856.0 тэрбум төгрөг, 172.8 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлж, холбогдох төслүүдийг санхүүжүүлсэн.</p>	
83			<p>3. Төсөл, хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай.</p>	<p>“Эрдэнэс-Тавантолгой”ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой 2 их наяд хүртэлх төгрөгийн болон ам.долларын бонд гаргах хүсэлтийг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Монголын хөрөнгийн биржид хүргүүлж Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо хянаж, холбогдох зөвшөөрлийг олгосны үндсэн дээр арилжааг эхлүүлсэн. Эхний үе шатыг 600 тэрбум төгрөгийн хэмжээтэйгээр 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр арилжааг нээж, 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 17:00 цагаар тасалбар болгож, амжилттай зохион байгуулсан. Уг бондын арилжаа, санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд нийт 677.7 тэрбум төгрөгийн захиалгыг оролцогч талуудаас ирүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангасан байна. Арилжаанд 964 аж ахуйн нэгж байгууллага, иргэд оролцож, төгрөгийн 10%-ийн хүүтэй 336.6 тэрбум төгрөг, ам.долларын 6.3%-6.8% хүртэл хүүтэй 119.7 сая ам.долларын мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлээд байна. “ЭТТ Бонд”-ын II дахь транчийн хүрээнд ам.доллар болон төгрөгийн хосолсон нийт 200 сая хүртэлх ам.доллартай тэнцэх үнийн дүн бүхий бондын арилжааны маркетингийн ажлыг 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс эхлүүлсэн. Бондын II шатыг олон улсад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцох боломжтойгоор нийтэд санал болгож 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 17.30 цагт захиалгыг авч нэгтгэсэн. II шатны нэгтгэсэн дүнгээр 519.4 тэрбум төгрөг, 53.1 сая ам.долларын захиалгыг хийж анхны төлөвлөсөн хэмжээг 117 хувиар давуулан биелүүлсэн. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүргийг “Эрдэнэс Монгол”</p>	100%

				ХХК-иар дамжуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна.	
37	84	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №6 ҮБХ.	I.1. Нүүрсний экспортыг нэгдүүлэхтэй холбоотой хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төслүүд /чингэлэгт тээврийн терминал, жолоочгүй тээврийн хэрэгсэл, дүүжин тээвэр, конвейнерийн систем/	Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ асуудлын хүрээнд нүүрсний экспортын 95 орчим хувийг бүрдүүлдэг хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулан ажилласан. Гашуунсухайт боомтод чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хоёр сарын хугацаанд барьж дуусгасан. Терминал барьж байгуулахтай холбоотой санхүүжилтийн 60 хувийг “Эрдэнэс Таван Толгой”ХК, 15 хувийг “Таван-толгой” ХК, 25 хувийг “Энержи Ресурс” ХХК гаргажээ. Төслийн гүйцэтгэгчээр “Энержи Ресурс” компани ажиллаж, нийт 30 га талбайд терминал байгуулж, улсын комисс хүлээн авсан. Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах ажлын хүрээнд нүүрсний чингэлэгт тээврийн гаалийн хяналтын нэмэлт гарцыг “Монголын Алт” (МАК) ХХК барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Түүнчлэн Шивээхүрэн боомтод баригдах чингэлэг тээврийн терминалыг байгуулах ажлыг 11.6 га талбайн хэмжээнд нийт 8 аж ахуйн нэгж хамтран гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Мөн хилийн Гашуунсухайт боомтод жолоочгүй тээврийн систем (AGV)-ийг ашиглалтад оруулсан.	100%
	85		I.2. Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, нүүрс ачилтын байгууламж, холболтын болон хилийн төмөр зам/	<p>1.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтийн ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан ажиллаж, ашиглалтад оруулсан.</p> <p>2.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтийн ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан ажиллаж, ашиглалтад оруулсан.</p> <p>3.”Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрс ачилтын логикийн төвийн гүйцэтгэл 12 дугаар сарын 31-ний байдлаар 84.44%-тай байна.</p> <p>4. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 104 дүгээр тушаалаар "Төмөр замын холболтын</p>	100%

				<p>бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх", "Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны хэлэлцээ хийх, төслийг тохирох", ""Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих, үүнтэй холбоотойгоор хилийн түр гарц нээх, журам тогтоох асуудлаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл"-ийг Хятадын талтай хэлэлцэн тохиролцох" үүрэг бүхий 3 дэд ажлын хэсэг байгуулагдан, холбогдох хэлцлүүдийг хийн ажиллаж байна.</p> <p>5.Богдхан төмөр замын асуудал нууцлалын зэрэглэлтэй байгаа</p>	
86		I.3. Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүд /Тавантолгойн цахилгаан станц, нүүрс баяжуулах, кокс-химийн, төрөл бүрийн сайжруулсан түлшний үйлдвэр, метан хийн болон дамжуулах хоолойн төслүүд, тэдгээртэй холбоотой бусад барилга байгууламж/	<p>"Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй А6/20 хөтөлбөрт "Кокс, эрчим хүчний үйлдвэрийн төсөл" тусгагдсан бөгөөд үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд:</p> <p>Багануурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах стратегийн ач холбогдол бүхий "Нүүрс, химийн технологи-эрчим хүчний цогцолбор" төслийг хэрэгжүүлэгч "Тавантолгой түлш" ХХК болон төсөл боловсруулагч тал болох "Евро азиа майнз" ХХК-иас 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 25/23 дугаар, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03/694 дүгээр албан хүсэлт тус тус ирүүлснийг үндэслэн УУХҮ-ийн Сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/229 дугаар тушаалаар Төслийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий "Шинжээчдийн хэсэг" байгуулагдан 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр, 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрүүдэд тус тус дүгнэлт, зөвлөмж гаргасан.</p> <p>УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл"-ийн "Боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаан"-аар 2019 оноос 2023 оны жилийн эцэс хүртэл нийт "Кокс-химийн үйлдвэр"-ийн 10 ТЭЗҮ-ийг хэлэлцэж, хүлээн авсан байна. Үүнд:</p> <p>"Ти ти си өү кей и" ХХК-ийн Дорноговь аймаг, Сайншанд суманд хэрэгжүүлэх "Кокс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ (2 сая. тн/жил);</p>	100%	

				<p>“Тавантолгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн суманд хэрэгжүүлэх “Металлургийн коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ (500 мян.тн/жил);</p> <p>“Таван толгой транс” ХХК-ийн Өмнөговь аймаг, Баян-Овоо сум Зайрмагтайн хөндийд “Кокс үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр”-ийн ТЭЗҮ (246 мян.тн/жил);</p> <p>“Баян кокс энерги” ХХК-ийн Төв аймгийн Баян сумын нутагт хэрэгжүүлэх “Кокс-химийн үйлдвэр”-ийн ТЭЗҮ;</p> <p>“Энерги ресурс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Ухаа худаг ордыг түшиглэн байгуулах “Коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ /1 сая.тн/жил/;</p> <p>“Ян сарьдаг оргил” ХХК-ийн Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт хэрэгжүүлэх “Нүүрс баяжуулах болон металлургийн коксын үйлдвэр”-ийн ТЭЗҮ /1.9 сая.тн/жил/;</p> <p>“Винсолд Интернэйшнл” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжүүлэх “Нүүрс баяжуулж, кокс-эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ (1 сая.тн/жил нүүрс баяжуулж, 450 мян.тн/жил кокс-эрчим хүч);</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр”-ийн ТЭЗҮ (2 мян.тн/жил нүүрс боловсруулж, 950 тн/жил диметилийн эфир);</p> <p>“Хөх тэнгэрийн мөнхийн гэрэл” ХХК-ийн Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлэх “Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр”-ийн ТЭЗҮ (66 мян.тн/жил);</p> <p>“Хотын түлш” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт “Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ;</p> <p>“Лузерн Эм Кей”ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт хэрэгжүүлэх “Шахмал түлшний үйлдвэр”-ийн ТЭЗҮ /жилд 80.0 мян.тн//.</p>	
87			I.6. Ил уурхайн ашиглалтын өртөг, зардлыг бууруулж, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлд далд уурхайн ашиглалтын технологийг нэвтрүүлэх боломжийг судлах	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд	Х.Б

				<p>конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. “Тавантолгой ордыг далдаар ашиглах урьдчилсан судалгаа”-ны ажлыг хийж гүйцэтгэсэн. Далд уурхайн хайгуул, судалгааны өрөмдлөг цооногийн геофизикийн ажил, нүүрсний болон чулуулгийн физик, механикийн шинж чанар тодорхойлуулах ажил хүлээгдэж байна. Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д “Онцгой дэглэм” тогтоосонтой холбогдуулан уг ажлын санхүүжилт зогссон тул биелэлт гаргах боломжгүй байна.</p>	
88			<p>2. Эрдэнэс-Тавантолгой хувьцаат компанийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг энэ тогтоолын 1 дэх заалтад тусгагдсанаар хязгаарлаж, тэдгээрийг тус компанийн борлуулалтын орлого болон гадаад дотоод зах зээлд үнэт цаас гаргах, зээл авах, нүүрс урьдчилан борлуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай.</p>	<p>“Эрдэнэс-Тавантолгой”ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой 2 их наяд хүртэлх төгрөгийн болон ам.долларын бонд гаргах хүсэлтийг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж”-д хүргүүлж “Монголын хөрөнгийн бирж”, “Санхүүгийн зохицуулах хороо” хянаж, холбогдох зөвшөөрлийг олгосны үндсэн дээр арилжааг эхлүүлсэн. Эхний үе шатыг 600 тэрбум төгрөгийн хэмжээтэйгээр 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр арилжааг нээж, 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 17:00 цагаар тасалбар болгож, амжилттай зохион байгуулсан. Уг бондын арилжаа, санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд нийт 677.7 тэрбум төгрөгийн захиалгыг оролцогч талуудаас ирүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангасан байна. Арилжаанд 964 аж ахуйн нэгж байгууллага, иргэд оролцож, төгрөгийн 10%-ийн хүүтэй 336.6 тэрбум төгрөг, ам.долларын 6.3%-6.8% хүртэл хүүтэй 119.7 сая ам.долларын мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлээд байна. “ЭТТ Бонд”-ын II дахь транчийн хүрээнд ам.доллар болон төгрөгийн хосолсон нийт 200 сая хүртэлх ам.доллартай тэнцэх үнийн дүн бүхий бондын арилжааны маркетингийн ажлыг 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс эхлүүлсэн. Бондын II шатыг олон улсад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцох боломжтойгоор нийтэд санал болгож 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 17.30 цагт захиалгыг авч нэгтгэсэн. II шатны</p>	100%

				нэгтгэсэн дүнгээр 519.4 тэрбум төгрөг, 53.1 сая ам.долларын захиалгыг хийж анхны төлөвлөсөн хэмжээг 117 хувиар давуулан биелүүлсэн.	
	89		3. Төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч "Эрдэнэс-Монгол" ХХК нь өөрийн охин болон хараат компаниудын менежмент, засаглалын асуудлыг хариуцан ажиллаж байна.	100%
38	90	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-18 Дугаар 2022 №02 Түр хороо	2.1. "Оюу толгой төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, говийн бүсийн газрын гүний ус ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн (газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: (Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хэрэгжилтийг ханган ажиллах, ус бохирдуулсны төлбөр төлөлтийн дүн, мэдээлэлд үндэслэн ус бохирдуулсны төлбөрийг төлөөгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах;"	"Оюутолгой" ХХК нь өнгөрсөн хугацаанд "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай" Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан. "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-т өөрчлөлт оруулах тухай 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ус ашиглалтын төлбөрийг тооцон 2016-2022 онуудад нийт 100.4 тэрбум төгрөгийг (эх сурвалж: "Оюутолгой" ХХК-ийн 2022 оны ус ашиглалтын тайлан) Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харин 2023 оны 01 дүгээр сараас эхлэн "Оюутолгой" ХХК нь "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолын дагуу ус ашигласны төлбөрийг төлж байна. Өмнөх жилүүдэд "Оюутолгой" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу ашигт малтмал, олборлох баяжуулахад ашигласан усны төлбөрийг 959.04 ₮/м3 (1литр усанд 0.95 мөнгө)-аар тооцоолон төлж байсан бол 2022 оны 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсноор 1678.32 ₮/м3 (1 литр усанд 1.68 төгрөг)-аар тооцоолон төлбөр ногдуулахаар болсон. Энэ нь 1 литр усны төлбөр 0.72 мөнгөөр нэмэгдсэн байна.	Х.Б

	91		2.2. Тус төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний аудитын тайлан олон улсын стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавих.	Тухайн хуулийн хэрэгжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцаж байгаа тул биелэлт гаргах боломжгүй байна.	Х.Б
	92		2.3. Монгол Улсын Засгийн газар Оюу толгой ХХК-ийн гаргасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд үндэслэн байгаль экологид сөргөөр нөлөөлөх асуудал байхгүй мэтээр үнэлэлт дүгнэлт өгч ирсэн нь учир дутагдалтай байна. Энэ асуудлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийдэг, ашиг сонирхлын зөрчилгүй, олон улсын хөндлөнгийн байгууллагатай хамтран ажиллаж ур дунг тайлагнах замаар шийдвэрлэх.	Тухайн хуулийн хэрэгжилт нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцаж байх тул биелэлт гаргах боломжгүй байна.	Х.Б
39	93	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-18 Дугаар 2022 №03 Түр хороо	1.2. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу толгой Лтд, Оюу толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”, “Оюу толгойн далд уурхайг байгуулах, түүнийг санхүүжүүлэх нэмэлт төлөвлөгөө”, “Менежментийн гэрээ”-г Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж зөрчсөн гэж дүгнэсэн тул тус гэрээг бүхэлд нь цуцалж, хүчингүй болгох;	1.“Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”, “Оюу толгойн далд уурхайг байгуулах, түүнийг санхүүжүүлэх нэмэлт төлөвлөгөө”-г Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2.ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Н-16 дугаартай албан	70%

			<p>бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.</p> <p>3.ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн саналыг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр УИХ дахь МАН бүлэгт, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.</p> <p>4.Харин “Менежментийн гэрээ”-г Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, төслийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны №198 дугаар захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-т мэдээлэл хүргүүлэх-чиглэл авахаар хүргүүлсэн бөгөөд энэ талаар хариуг ирүүлээгүй байна.</p>	
94		2/б/. б/Эдгээр гэрээнүүдийн үндсэн дээр олгосон нэмэлт төлбөрүүдийг Оюу Толгой ХХК хариуцаж байгааг болиулах /Менежментийн үйлчилгээний төлбөр, Рио Тинто үйлчилгээний төлбөр, Рио Тинто баталгааны шимтгэлтэй холбоотой татвар, хураамж/.	<p>"Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, "Оюу толгой төсөл"-ийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 165 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Санхүү, татвар, хураамжийн асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд Сангийн яам, Татварын ерөнхий газар хариуцан ажиллаж байх тул биелэлт гаргах боломжгүй байна.</p>	Х.Б
95		3/а/. Оюу толгой төслөөс Монголын талын хүртэх үр өгөөжийг менежментийн төлбөр болон Менежментийн гэрээний дагуу бууруулж буй тул: а/Рио Тинто группийн менежментийн үйлчилгээний төлбөрөөс тусад нь нэхэмжлэн авч байгаа үйлчилгээний төлбөр нь нэг төрлийн үйлчилгээнд хоёр өөр нэрээр давхардуулан авч байгаа нэмэлт төлбөр бөгөөд зардлаар дамжуулан Хөрөнгө	<p>"Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, "Оюутолгой төсөл"-ийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 165 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Санхүү, татвар, хураамжийн асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд</p>	Х.Б

		оруулагч талд ногдох үр ашгийг нэмэгдүүлж байгааг зогсоох	Сангийн яам, Татварын ерөнхий газар хариуцан ажиллаж байгаа тул биелэлт гаргах боломжгүй байна.	
96		3/б/. б/Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөний дагуу Рио Тинто компани санхүүжилтийн баталгаа гаргасны төлөө шимтгэл авч, төслийн санхүүжилтийн зээлийн хүү гэсэн энэ хоёр төрлийн дүнгээс дахин менежментийн төлбөр авахаар тохирсон байгааг болиулах;	“Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, “Оюутолгой төсөл”-ийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 165 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Санхүү, татвар, хураамжийн асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд Сангийн яам, Татварын ерөнхий газар хариуцан ажиллаж байх тул биелэлт гаргах боломжгүй байна.	Х.Б
97		3/в/. в/2010 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан Техник, эдийн засгийн үндэслэлд тохирсон зардал өнөөгийн байдлаар хэд дахин өсч, цаашид нэмэгдэж болзошгүй байгаа тул техник, эдийн засгийн үндэслэлийг дахин нягтлах, хэтэрсэн зардлын хэмжээгээр Рио Тинто компанид олгох менежментийн төлбөрийг хасаж тооцох, болиулах, шаардлагатай гэж үзвэл ашгаас тооцох арга хэмжээг авах.	УУХҮ-ийн Сайдын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/275 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюу толгой зэс-алтны орд”-ыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын төсөлд шүүмж, дүгнэлт гаргах шинжээчдийн хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус шинжээчдийн хэсэгт Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн төлөөлөл ажиллаж байна.	70%
98		5. 5/Антре Гоулд компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас олборлох нийт 2.6 сая тонн зэсийн баяжмалын (алт, мөнгө багтсан) 34 хувийг Монголын тал эзэмших ёстой байтал 70-80 хувьд ногдох 34 хувийг эзэмшихээр нөхцөл байдал үүсэж, Монголын талын ногдол ашгийг 1.4 тэрбум ам.доллараар бууруулахад хүргэж байгаа зөрчлийг Монгол Улсын хууль тогтоомж болон Хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд шийдвэрлэх;	“Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, “Оюутолгой төсөл”-ийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 165 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Санхүү, татвар, хураамжийн асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд Сангийн яам, Татварын ерөнхий газар хариуцан ажиллаж байх тул биелэлт гаргах боломжгүй байна.	Х.Б

99		<p>7. 7/Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гаргасан тодорхой бус агуулга бүхий 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Стр-10/15 тоот дүгнэлтийг үндэслэл болгосон Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн т/109 тоот тушаал нь Ашигт малтмалын тухай хууль зөрчсөн тул Техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж иж бүрнээр нь хүлээн авах;</p>	<p>УУХҮ-ийн Сайдын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/275 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюу толгой зэс-алтны орд”-ыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын төсөлд шүүмж, дүгнэлт гаргах шинжээчдийн хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус шинжээчдийн хэсэгт Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн төлөөлөл ажиллаж байна.</p>	70%
100		<p>8. 8/Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 тоот Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” тогтоолын үндэслэлийг эргэн судалж, говийн бүсийн гүний ус ашиглах, төлбөр тооцох нөхцөлүүдийг шинээр тогтоох;</p>	<p>“Оюутолгой” ХХК нь өнгөрсөн хугацаанд “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан. “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-т өөрчлөлт оруулах тухай 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ус ашиглалтын төлбөрийг тооцон 2016-2022 онуудад нийт 100.4 тэрбум төгрөгийг (эх сурвалж: “Оюутолгой” ХХК-ийн 2022 оны ус ашиглалтын тайлан) Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харин 2023 оны 01 дүгээр сараас эхлэн “Оюутолгой” ХХК нь “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолын дагуу ус ашигласны төлбөрийг төлж байна. Өмнөх жилүүдэд “Оюутолгой” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу ашигт малтмал, олборлох баяжуулахад ашигласан усны төлбөрийг 959.04 ₮/м3 (1литр усанд 0.95 мөнгө)-аар тооцоолон төлж байсан бол 2022 оны 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсноор 1678.32 ₮/м3 (1 литр усанд 1.68 төгрөг)-аар тооцоолон төлбөр ногдуулахаар болсон. Энэ нь 1 литр усны төлбөр 0.72 мөнгөөр нэмэгдсэн байна. /Тухайн хуулийн хэрэгжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцаж байгаа тул биелэлт гаргах боломжгүй байна/</p>	100%
101		<p>2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар</p>	<p>"Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх</p>	70%

			<p>захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай</p>	<p>ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 165 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байна.</p>	
102			<p>1.1. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Оюу толгой ордын ашиглалтад Монгол ; Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоол болон Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр тогтоол, 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолд нийцээгүй “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон)”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах;</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 174 дүгээр захирамжаар ““Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, “Оюу толгой төсөл”-ийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчилсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 74 дүгээр тогтоолын 1 дэхь заалтаар “Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Ажлын ерөнхий төлөвлөгөө” батлагдсан. Улмаар дээрх ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Ажлын дэд хэсэг байгуулах тухай” 23 дугаар тушаалаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий “Ажлын дэд хэсэг”-ийг Санхүүгийн асуудал хариуцсан, Хуулийн асуудал хариуцсан, Техникийн хамтарсан хэсэгтэйгээр байгуулж, тэдгээрийн ажиллах чиглэлийг заажээ. Уг ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021</p>	70%

				<p>оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан “Ажлын хэсгийн хуралдаан” 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдөр цахимаар, 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр ХЗДХЯ-ны хурлын танхимд, 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит танхим”-д, 2021 оны 03 дугаар сарын 05-аас 06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сум “Оюутолгой ХХК”-ийн уурхайд тус тус зохион байгуулсан.</p> <p>“Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-г Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.</p>	
40	103	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-21 Дугаар 2022 №01 ҮББХ	1. "МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" МУ-ын Их Хурлын тогтоолд тусгагдсан асгатын ; мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУЗГ /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж, нөөцийг тодотгох гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2022 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулах"	“Эрдэнэс Монгол” ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил хийж, ордын нөөцийг баталгаажуулахаар 2023 оны төсөвт 9,182,096,276 төгрөг тусгасан. Одоогоор худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ТХААГ-т хүргүүлсэн байна. Мөн ордын бэлтгэл ажлын хүрээнд “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах”, “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх”, “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажлууд”-ыг ТХААГ-аар зохион байгуулагдаж, тус тендерүүдэд шалгарсан гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна.	70%
	104		3. Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх, техник эдийн	“Эрдэнэс Монгол” ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын	70%

			засгийн үндэслэл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хариуцуулах.	төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил хийж, ордын нөөцийг баталгаажуулахаар 2023 оны төсөвт 9,182,096,276 төгрөг тусгасан. Одоогоор худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ТХААГ-т хүргүүлсэн байна. "Эрдэнэс Монгол" ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил хийж, ордын нөөцийг баталгаажуулсны дараа Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
41	105	Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022-05-24 Дугаар 2022 №03 АБГББХ	1.1/. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчилж, хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах; (1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр болон газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөөц, нөхөн сэргээлтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай:)	<p>Монгол Улсын Их Хурлаар 2014 онд баталсан "Газрын тосны тухай хууль"-ийн /шинэчилсэн найруулга/ 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар"-т нийцүүлэн 2016-2019 онд 13 хайгуулын гэрээг шинэчилсэн ба ашиглалтын үе шатны 3 талбайн гэрээ шинэчлэх ажил гэрээлэгч талаас зарчмын зөрүүтэй санал гаргасны улмаас шинэчлэгдээгүй, мөн 4 талбайн гэрээг Засгийн газрын тогтоолоор цуцалсан ба 1 талбайн гэрээ шүүхийн маргаантай байсан болно.</p> <p>2024 оны 01 дүгээр сарын байдлаар газрын тосны хайгуулын 9, газрын тосны ашиглалтын 4 талбайн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Орон нутгийн иргэд болон Төрийн бус байгууллагуудын зүгээс гэрээг шинэчлэх Монгол улсад ногдох хэмжээг нэмэгдүүлэх, газрын тосны нөөц ашигласны төлбөрийг авах зэрэг асуудлаар газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, газрын тосны экспортын тээвэрлэлтэд саад учруулах зэрэг үйлдлийг удаа дараа гаргах болсон.</p> <p>Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг-XXI талбайнуудад байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний эрх үүргийг шилжүүлэн авсан БНХАУ-ын төрийн өмчит "Петрочайна дачин тамсаг" ХХК болон Бүтээгдэхүүн хуваах гэрээт-97 /БХГ-97/ талбайд мөн БНХАУ-ын төрийн өмчит "Доншен газрын тос (Монгол)" ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг 2016-2018 онд холбогдох</p>	100%

яам, агентлагийн түвшинд 4 удаа ажлын хэсэг байгуулж ажиллаж байсан боловч талууд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Гэрээлэгч талаас тухай бүр “Бүтээгдэхүүн хуваах гэрээ-”г хэвээр хадгалах байр суурийг илэрхийлж ирсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжаар “Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулсан. Мөн Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тушаалаар дээрх ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажиллах “Ажлын дэд хэсэг-”ийг ХЗДХ-ийн дэд сайд Б.Солонгоор ахлуулан байгуулсан. Тус ажлын дэд хэсгийн гишүүд “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж холбогдох танилцуулга, саналыг боловсруулан “Ажлын хэсэг-”т хүргүүлсэн.

Монгол Улсын Шадар сайд 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн ЗГ-2/679 тоот албан бичгээр “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хөрөнгө оруулагч болох “Петрочайна Дачин Ойлфийлд лимитэд” компанийг гэрээ шинэчлэх талаар яриа, хэлэлцээ хийхээр урьсан. Манай талаас яриа, хэлэлцээрийг эхлүүлэх талаар санаачилга гарган ажилласан.

Тус ажлын хэсгийн явцыг 2023 оны 05 сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 96 дугаар захирамжаар “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ-”г холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн байгуулах “Ажлын хэсэг-”ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулахаар тогтсон. Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд өөр

				<p>өөрсдийн хариуцсан чиг үүргийн мэдээллийг бэлтгэж нэгтгэсэн. Тухайн асуудлаар ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд БНХАУ-д ажиллаж “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дай Хоулян болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах “Ажлын хэсэг” томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Хятадын талын ажлын хэсгийг “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн дэд захирал Жан Даовэй ахлан ажиллахаар болсон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх Монголын талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан.</p>	
106		1.3/. Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	УУХҮ-ийн Сайдын 2023 оны 03 сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 15.5-д заасны дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан. Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж,	70%	

			Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн болгоод байна.	
107		1.4/. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдэд түшиглэн барьж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн тогтвортой нөөцөөр хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах, газрын тосны хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинээр нөөцийг тогтоох, ашиглах үйл ажиллагааг дэмжих;	“Петрочайна дачин тамсаг”ХХК-ийн үйл ажиллагаа болон “Газрын тос боловсруулах үйлдвэр”-т шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар танилцуулан 29 дүгээр тэмдэглэлийг гаргуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Уг тэмдэглэлийн дагуу 2022 онд газрын тосны хайгуулын Нялга-XVI, Хөхнуур-XVIII, Сүхбаатар-XXVII талбайнуудын хайгуулын хугацаа дууссан тул “Газрын тосны тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэхь заалтын дагуу “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г дуусгавар болгосон. УУХҮ-ийн Сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/248, А/249 дүгээр тушаалаар “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Засгийн газрын тогтоолоор цуцалсан, гэрээний хугацаа дуусгавар болсон, гэрээлэгчгүй байсан зэрэг нийт 15 талбайд газрын тосны хайгуулын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. Сонгон шалгаруулалтад 4 талбайд аж ахуйн нэгжүүдээс санал ирүүлж “Газрын тосны тухай хууль”, “Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу гүйцэтгэгчийг тодруулсан. Засгийн газрын хуралдаанаар 1 талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ хэлэлцүүлэхэд бэлэн болсон ба 2 талбайд гэрээний төсөлд холбогдох яамдуудаас санал авах шатанд, 1 талбайн гэрээний төслийг холбогдох хуульд нийцүүлэхээр “Ашигт малтмал, газрын тосны газар”-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна.	70%
108		1.5/. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Байгаль орчны менежментийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, 2021, 2022 оны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай баталж, хэрэгжилтэд хяналт	“Петрочайна дачин тамсаг”ХХК 2020 болон 2021 онд хийгдээгүй үлдсэн биологийн нөхөн сэргээлт, өрмийн шингэн хаягдлыг саармагжуулах, хатуу хог хаягдлыг ангилан боловсруулах, ашиглагдахгүй замын хөрсийг суллах, хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ, дүйцүүлэн хамгаалах ажил зэрэг байгаль орчны нөхөн сэргээлтийн 17 төслийг 2022 онд хэрэгжүүлсэн. Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох ажилтнууд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбай дээр 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 25-ны өдрийн хооронд ажиллаж, тус талбайнуудын 2020, 2021 онуудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлуудын гүйцэтгэлд дахин үнэлгээ өгч, дүгнэлт гаргуулан	100%

				<p>төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулсан. Үүний үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох ажилтнууд 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07-ны өдөр хүртэл Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад ажиллаж, 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр баталгаажуулсан болно. 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-нд тусгагдсан Тосон-Уул XIX талбайн хувьд 100 га эвдэрсэн газрыг хагалах, 5 ширхэг өрмийн шингэн хаягдлын сан, 3 ширхэг үйлдвэрийн шингэн хаягдлын санг нөхөн сэргээх, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх, хугацаа хэтэрч ашиглах боломжгүй болсон 592 тн химийн бодисыг устгах, 2020-2022 онд хуримтлагдсан аюултай хог хаягдлыг хуулийн дагуу устгах,Тэрбум мод үндэсний хүрээнд Матад суманд 15,000 ширхэг модны суулгац хүлээлгэн өгөх, орчны хяналт шинжилгээ мониторингийн ажлуудыг авч хэрэгжүүлсэн. Тамсаг XXI талбайн хувьд 100 га эвдэрсэн газрыг хагалах, 7 ширхэг өрмийн шингэн хаягдлын сан, 1 ширхэг үйлдвэрийн шингэн хаягдлын санг нөхөн сэргээх, 2.4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх, алслагдмал 200 цооногт галын бүс татах, 2020-2022 онд хуримтлагдсан аюултай хог хаягдлыг хуулийн дагуу устгах,Тэрбум мод үндэсний хүрээнд Халхгол суманд 10,000 ширхэг модны суулгац хүлээлгэн өгч талбайд 4,500 ширхэг мод тарих, орчны хяналт шинжилгээ мониторингийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга А.Гантулгаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т талбайд ажилласан бөгөөд БОМТ-ний биелэлтийг Тосон-Уул XIX талбайд 95.1 хувь, Тамсаг XXI талбайд 91% буюу хангалттай гэж дүгнэсэн.</p> <p>2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдэж байна.</p>	
109		1.6/. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу эцэслэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г хууль тогтоомжид нийцүүлэн олон улсын гэрээний түвшинд шинэчлэх, “Татварыг давхар ногдуулахгүй, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” Монгол Улсын Засгийн	70%	

			газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийн дагуу уг хэлэлцээрт өөрчлөлт оруулах замаар үүссэн асуудлыг шийдвэрлэх талаар санал гаргасан болно. Тус асуудлыг хамтарсан ажлын хэсгийн түвшинд гэрээг шинэчлэх талаар хоёр талын уулзалт, хэлэлцээрийн үед шийдвэрлэхээр төлөвлөж байна.	
110		1.8/. Газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэд техник, технологийг үе шаттай нэвтрүүлэх;	“Петрочайна Дачин Тамсаг”ХХК орд газрын олборлолтын үйл ажиллагаанд ашиглах усыг 300-500 метрийн гүнээс авч ашиглаж байгаа ба энэ нь олон улсын орд газрын олборлолт, ус шахалтын ажлын жишигт нийцсэн байдаг. Гүний ус агуулж буй давхарга нь үндсэн 3 бүсэд хуваагдана. 100 метр хүртэлх гүний ус нь ард иргэдийн ахуйн хэрэгцээ болон мал амьтныг ундаалах ус байдаг. Орд газрын хэрэгцээнд өрөмдсөн худгийн гүн нь 400-500 метр байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар авч ашиглаж буй усны давхарга нь 300 метрээс доош гүнд байгаа тул ард иргэдийн ахуйн хэрэгцээний усанд нөлөөлөхгүй. “Петрочайна дачин тамсаг” ХХК-ний үйл ажиллагаанд хөндлөнгийн олон улсад нэр хүнд бүхий хараат бус эксперт томилон ажиллуулах тохиолдолд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэн ажиллах талаар зөвлөмж боловсруулан мөрдүүлэх боломж бүрдэнэ” гэж ажлын дэд хэсэг үзсэн байна.	100%
111		1.9/. Газрын тосны хайгуул, олборлолтын үеийн үйл ажиллагаанаас үлдсэн чанарын шаардлага хангахгүй, устгах шаардлагатай химийн бодисын хог хаягдлыг олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу шийдвэрлэх;	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК Тосон-Уул XIX талбайд хуримтлагдсан хугацаа хэтэрсэн химийн бодисыг устгах ажлыг гүйцэтгэж байгаа ба 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд нийт 20 удаагийн тээвэрлэлтээр 592 тонн химийн бодисыг Налайх дүүрэгт байрлах өөрийн үйлдвэр рүү тээвэрлэн хүргэж бүрэн устгаж дууссан.	100%
112		1.10. Газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутгийн байгаль орчин, бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсч байгаа тул хатуу хучилттай автозамын барилгын ажлыг яаралтай	“Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн 58.5 км хатуу хучилттай автозамыг “Их Монгол Барилга” ХХК гүйцэтгэсэн байна. Баянхошуу хилийн боомт чиглэлийн 58.5 км автозамын ажлыг 2023 оны 08 дугаар	100%

		дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах;	сард бүрэн дуусгаж, холбогдох замын тэмдэг тэмдэглэгээг хийсэн бөгөөд Улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.	
113		1.12/. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн тоог нэмэгдүүлэх, сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах.	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран мэргэжлийн дипломтой ажилтан сонгон шалгаруулж ажилд авч байгаа бөгөөд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг Шинжлэх ухаан, технологийн их сургууль болон бусад сургалтын байгууллагатай хамтран жилд 1-2 удаа зохион байгуулж, бүх ажилтнуудыг хамруулдаг байна. Туслан гүйцэтгэгч компанийн тухайд улирлын чанартай ажил гүйцэтгэдэг ба орон нутгаас хөдөлмөр зуучийн компаниар дамжуулан түр ажилд ажилтан авахдаа мэргэжлийн диплом шаарддаггүй байна. Түр гэрээт Монгол ажилчид цооногын өрөмдлөг, туршилт үйлчилгээний зэрэг ажлуудад дагалдан ажилтнаар ажилладаг ба “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д 2022 оны 10 дугаар сард үндсэн 559 монгол ажилчид, туслан гүйцэтгэгч ангиудад 250 монгол ажилчид ажиллаж байсан бол 2023 оны 12 дугаар сарын байдлаар үндсэн 612 монгол ажилчид, туслан гүйцэтгэгч ангиудад 50 монгол ажилчид ажиллаж байна. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үндсэн монгол ажилчдын тоо нэмэгдсэн бөгөөд тухайн жилийн батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу гүйцэтгэх ажил, үүргээс хамааран туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд ажиллах монгол ажилчдын тоонд өөрчлөлт ордог болно.	100%
114		1.2/. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг хийснээс хойших хугацаанд Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт, үр ашиг, өгөөжийг тооцох, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаанд экспертийн дүгнэлт гаргах үүрэг бүхий холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсгийг томилж, ажиллуулах;	Хууль зүй, дотоод хэргийн Дэд сайд Б.Солонгоор ахлуулсан ажлын дэд хэсэг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд 4 удаа хуралдсан бөгөөд 06 дугаар сарын 15-ны өдрөөс 19-ний өдрүүдэд ажлын дэд хэсгийн зарим гишүүд Дорнод аймгийн удирдлагуудтай хамтарч “Петрочайна дачин тамсаг” ХХК-ний хэрэгжүүлж байгаа “Тосон-Уул-ХИХ”, “Тамсаг-ХХИ” талбайд газрын тосны ашиглалт явуулж байгаа үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан ажилласан. Энэ саналд Тосон-Уул ХИХ, Тамсаг ХХИ талбайд байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний хэрэгжилт болон гэрээлэгчийн батлуулсан газрын тосны нөөцийн тайланд /Орд ашиглах төлөвлөгөө/ мөн талуудын үр ашгийг нэмэгдүүлэх, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд ашиглаж буй техник,	100%

				технологийн нөхцөл байдалд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч, байгууллагаас зөвлөх үйлчилгээ авч, дүгнэлт, зөвлөмж гаргуулах нь зүйтэй гэж үзсэн. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч, байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах асуудлаар ажлын хэсэг хэлэлцэж шийдвэр гаргаагүй байна.	
42	115	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-10-26 Дугаар 2022 №08 ҮББХ	4/. Баруун, зүүн бүсийн үйлдвэрлэл, технологийн паркийн (Ховд, Дорнод) дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх, “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, цэвэрлэх байгууламжийн ажил удааширсан шалтгааныг тодруулан хариуцлага тооцож, цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг түргэвчлэх;	Баруун, зүүн бүсийн үйлдвэрлэл, технологийн паркийн (Ховд, Дорнод) асуудал нь ХХААХҮ-ийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул биелэлт гаргах боломжгүй юм.	Х.Б
43	116	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-12-07 Дугаар 2022 №10 ҮББХ	3.. Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан худалдаалах эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.	100%
44	117	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-11 Дугаар 2023№03 ҮБХ	1.3/. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжүүлэхтэй холбогдуулан хуульд заасан холбогдох журмуудыг хууль хэрэгжих хугацаатай нийцүүлэн баталж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн, арилжааг олон улсын жишигт нийцүүлж, нээлттэй, ил тод зохион байгуулах;	“Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 466 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Мөн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн борлуулалтын гэрээний асуудлаар ирүүлсэн санал хүсэлтүүдийг уламжлан ЭЗХЯ-нд 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2321 дугаартай албан бичгээр, ЭЗХЯ, СЯ болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2683 дугаартай албан	100%

				<p>бичгээр, ГЕГ-т 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2836 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэн холбогдох санал болон чиглэлийг хүргүүлж ажилласан. 2023 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан ил тод, дуудлага худалдаагаар 14.9 сая.тн нүүрс, 604.8 мян.тн төмрийн баяжмалыг тус тус арилжиж нийт 2.186.2 сая ам.долларын борлуулалтын орлого олохын зэрэгцээ үнийн өсөлтөөс хамаарч 155.3 сая ам.долларын нэмэлт орлого олсон эерэг үзүүлэлт гарсан байна.</p>	
118			<p>1.4/. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжих нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах.</p>	<p>“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина” гэж заасан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт /УИХ-ын 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/-аар 16 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан.</p> <p>Стратегийн ач холбогдол бүхий дээр дурдсан ордуудын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас өнөөгийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой”ХК нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасныг хангах чиглэлээр ажилласан байна.</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд тус тогтоолын 2 дугаар зүйлийн а-д “Монгол Улсын нийт иргэнд эхний ээлжинд хувьцааны 20 хувийг адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх”, б-д “хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах” гэж тус тус заасан.</p> <p>Улмаар Засгийн газрын 2011 оны 98, 2012 оны 116, 181, 201 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой”ХК-ийн хувьцааг үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах, иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх арга хэмжээг авахыг даалгасан.</p> <p>Энэ хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК хувьцааныхаа 10 хүртэлх хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд хаалттай худалдахаар</p>	100%

				<p>захиалга авахад 486 аж ахуйн нэгж байгууллага 0.05% -ийг худалдан авах захиалга ирүүлсэн байна.</p> <p>“Эрдэнэс Таван толгой” ХК нь нийт 14.0 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 15 тэрбум хувьцаатай байхаар дүрмэндээ тусгасан бөгөөд нэгж хувьцааны үнийг 933 төгрөг байхаар Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор баталсан.</p> <p>Дээр дурьдсан 15 тэрбум хувьцааг Монгол улсын төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллага нийлсэн нийт 2.511.819 хувьцаа эзэмшигч эзэмшиж байх бөгөөд үүнээс “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 65.2%-ийг “Эрдэнэс Монгол” ХХК, 14.75 % буюу 2.213.060.522 ширхэг хувьцааг Монгол улсын нийт хүн амын 77.5% буюу 2.511.332 иргэн, 486 аж ахуйн нэгж байгууллага 0.05% -ийг тус тус эзэмшиж байна.</p>	
	119		<p>2/. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их Хурлын “Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо”-нд 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр танилцуулга хийсэн.</p>	100%
45	120	<p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ</p>	<p>2ё/. гол нэр төрлийн эрдэс баялгийн үйлдвэрлэлийн биет хэмжээг тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл болон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн санал, тухайн салбарын урт, дунд хугацааны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний төсөөлөлд үндэслэн тооцоолдог аргачлалыг боловсруулж мөрдүүлэх, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр нөөц бололцоогоо бүрэн дайчлах;</p>	<p>Гол нэр төрлийн эрдэс баялгийн үйлдвэрлэлийн биет хэмжээний төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгуулсан.</p>	100%
	121		<p>3а/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн</p>	<p>Сангийн яамны чиг үүрэгт хамаарах тул хасуулах саналтай.</p>	Х.Б

		хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;		
122		бг/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул биелэлт гаргах боломжгүй байна.	Х.Б
123		5а/. аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянах;	УУХҮ-ийн Сайд 2020 оноос бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нартай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Аймгуудын өрсөлдөх чадварын индексийг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг жил бүр гаргаж байна. Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварт нөлөөлж буй үзүүлэлтүүдийг тогтоож, өрсөлдөх чадварыг үнэлэх боломж бүрдэж байна. Ингэснээр тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглаж болох, хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал эх үүсвэр болж байна. 2022 оны өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр Дорноговь аймаг тэргүүлж, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ аймгууд II, III, IV, V, VI эрэмбэлэгдсэн нь өнгөрсөн оноос эрэмбийн хувьд өөрчлөлтгүй байна. Харин Дундговь, Завхан, Булган, Говь-Алтай, Баянхонгор аймгууд хамгийн бага үнэлгээ авсан байна. Өрсөлдөх чадварыг хэмждэг үндсэн дөрвөн бүлгээр буюу Эдийн засгийн тамир тэнхээгээр Өмнөговь аймаг, Бизнесийн үр ашгаар Дархан-Уул аймаг, Засаглалын үр ашиг болон Дэд бүтцээр Дорноговь аймаг I эрэмбэлэгдээд байна.	100%

46	124	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-06-07 Дугаар 2023 №04 ҮББХ</p>	<p>1.1/. 1.Монгол Улсын Их Хурлаас баталсан ““Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай. 1/“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах төрийн захиргааны төв байгууллагыг тогтоох; “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл &#039; ажиллагаанд шаардагдах урсгал зардал, орон сууцны барилгын үлдэгдэл санхүүжилт болон бусад шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг 2024 оноос улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 323 дугаар тогтоолоор тус компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр УУХҮЯ-ыг тогтоосон. “Хөгжлийн банк”-ны санхүүжилтэд үүссэн асуудалтай холбогдуулан төсөл хэрэгжүүлэгч компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Эрдэнэс Монгол ХХК-ийг тогтоох нь зүйтэй гэж үзэж Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар “МГТБҮ” ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж 82 дугаар тогтоолыг батлуулсан. “МГТБҮ” ТӨХХК-ийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол”ХХК-ийг тогтоосон тул улсын төсөвт тусгуулах саналыг “Эрдэнэс Монгол”ХХК, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас холбогдох байгууллагад хүргүүлэх хуулийн зохицуулалттай.</p>	100%
47	125	<p>"Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн</p>	<p>1.1/. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг саадгүй, шат дамжлага багатайгаар явуулж, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахын тулд Засгийн</p>	<p>Зээлийн гэрээний тухай ТӨБЗГ-ын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор төслийн хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц болох хүнд даацын авто зам, төмөр замын салаа, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбай бэлтгэх, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулж</p>	100%

		<p>байгуулалтын явцын талаар" 2023-06-09 Дугаар 2023 №06 ҮБХ</p>	<p>газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 82 дугаар тогтоолыг өөрчилж, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоож, тус яам нь газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах;</p>	<p>250.0 тэрбум /хоёр зуун тавь/ хүртэлх төгрөгийн зээлийн гэрээг үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож зээл, зээлийн хүүг төлөх нөхцөлтэйгээр "Хөгжлийн банк"-тай байгуулахыг "МГТБҮ"ТӨХХК-д зөвшөөрсөн. "Хөгжлийн банк"-ны 250.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн 27 км салаа төмөр зам, 17.5 км хүнд даацын тусгай зориулалттай автозам, 18.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын дэд станцыг барьж байгуулан, 2019 оны 10 дугаар сард ашиглалтанд хүлээн авсан. Үүнээс гадна мөн зээлээр үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга, "МГТБҮ" ТӨХХК-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж ирсэн "Хөгжлийн банк"-ны зээл нь жилийн 11.89%-ийн хүүтэй бөгөөд 2023 оны 03 дугаар сарын байдлаар 166.3 тэрбум төгрөгийн зээлийг авсан ба хуримтлагдсан хүүгийн хэмжээ 62.7 орчим тэрбум төгрөг болсон байсан. "МГТБҮ" ТӨХХК-нд олгосон зээл болон барьцаа хөрөнгийн харьцаа алдагдах эрсдэл үүссэн. Барьцаа хөрөнгийг нэмэхгүй тохиолдолд үргэлжлүүлэн зээл олгох боломжгүй талаар "Хөгжлийн банк"-аас асуудал тавьж ирсэн бөгөөд зээлийн санхүүжилтийг зогсоосноор төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаа доголдох, төслийн бүтээн байгуулалтын ажлууд саатах нөхцөлд хүрсэн. "Хөгжлийн банк"-ны санхүүжилтэд үүссэн асуудалтай холбогдуулан төсөл хэрэгжүүлэгч компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр "Эрдэнэс Монгол"ХХК-ийг тогтоох нь зүйтэй гэж үзэж Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар "МГТБҮ" ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж 82 дугаар тогтоолыг батлуулсан.</p>	
126			<p>1.3/. Петроцайна Дачин Тамсаг" ХХК болон түүний дээд шатны байгууллага болох "Хятадын газрын тосны үндэсний корпорац (СМРС)" болон "Дачин Ойлфийлд" компанитай хэлцэл хийн, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ирээдүйд олборлох газрын тосыг Монголын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, олборлолтын хэмжээг орд ашиглалтын</p>	<p>"Петроцайна Дачин Тамсаг" ХХК газрын тосны орд ашиглах төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг хийж байна. 2024 онд нөөцийн тодотгол, орд ашиглах төлөвлөгөөг "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. "Петроцайна Дачин Тамсаг" ХХК-ийн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 96 дугаар Ерөнхий сайдын захирамжийг гаргуулан ажлын хэсгийг Монгол Улсын</p>	70%

			<p>төлөвлөгөөнд заасан 1.5 сая тонн/жилд хүргэх асуудлыг баталгаажуулах;</p>	<p>сайд ЗГХЭГ-ын даргаар ахлуулахаар шийдвэрлэж, ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсэг “Хятадын газрын тосны үндэсний корпораци (CNPC)”-ийн удирдлагатай БНХАУ-ын Бээжин хотод уулзалт хийж Хятадын тал ажлын хэсэг байгуулан хамтран ажиллахаар болсон. Тус ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу ирээдүйд олборлох газрын тосыг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-т нийлүүлэхийг баталгаажуулах, хамтарсан хайгуул хийх талаар судалж, ажлыг эрчимжүүлэх талаар хэлэлцэж шийдвэрлэхээр ажиллаж байна. “Эрдэнэс Монгол” ХХК, ЗГХЭГ, Сангийн яаманд хамаарна.</p>	
127			<p>1.4/. Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2023 оны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж бие дааж үйл ажиллагааг нь тогтвортой, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх.</p>	<p>Төрийн өмчит компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК хэрэгжүүлж байгаа тул тус компанийн санхүүжилтийн асуудлыг эрх хэрэгжүүлэгч болон Сангийн яам хариуцан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /ЕРС-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /ЕРС-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /ЕРС-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “МГТБҮ” ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, худалдан авалт-35.5%, барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, техникийн зураг төслийн ажил - 90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж</p>	70%

				155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	
	128		2.. Тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг 2023 оны намрын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд ирүүлэх.	“Байнгын хорооны хурал”-д хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр танилцуулсан.	100%
Ерөнхийлөгчийн зарлиг					
48	129	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮЯ-ны хаягийг Монгол бичгээр бичиж шинэчилсэн. Мөн яамны албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд үе шаттайгаар сургалтыг зохион байгуулж байна. 2023 онд анхан шатны мэдлэг олгох сургалтыг Чингэлтэй дүүргийн “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран зохион байгуулсан. 2024 онд дунд шатны буюу бичгийн чадвар сайжруулах чиглэлээр яамны албан хаагчдаас санал авч сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн болно.	100%
49	130	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Уул уурхайн компаниудын 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 1750.6 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1527 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 104337.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд 1571 га талбайд 7.2 сая мод тарихаар төлөвлөсөн байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.6.3 дахь заалтын дагуу 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг 2023 оны 02 дугаар сард ирүүлдэг. Одоогийн байдлаар ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан 166 тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг 919.45 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 520.1 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 44.081.52 га талбайд хийсэн байна. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1.411.2 га талбайд 2.612.788 ширхэг мод тарьсан байна. /АМГТГ-аас "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аж ахуй нэгжүүдээс	100%

				ирүүлсэн 2023 оны уулын ажлын болон баяжуулах үйлдвэрүүдийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1571.1 га талбайд 7.2 сая мод тарихаар тусгуулан ажиллалаа. Мөн 2022 оны албажсан тайлангаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1575.74 га талбайд 2.753.478 мод тарьсан байна. Газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна дачин тамсаг" ХХК 2023 онд 16.000 ш суулгацыг орон нутагт хүлээлгэн өгч, Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд 40.568 ш суулгац тариалсан бол "Доншен газрын тос" (Монгол) ХХК 3 га талбайд 6000ш суулгац тариалсан байна/	
ҮАБЗ-ийн зөвлөмж					
50	131	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурышлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,	ҮАБЗ, ОБЕГ, НЗДТГ хамтран “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах команд штаб”-ын сургуулилт хийхтэй холбогдуулан харъяа мэргэжлийн ангиудад мэдээллийг хүргүүлж 4 удаагийн сургалтанд хамрагдав. Мөн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан команд штабын сургуулилтад АМГТГ, ҮГА, ГСШТ ТӨҮГ-ын гамшгийн асуудал хариуцсан ажилтнуудын хамт амжилттай оролцсон.	100%
51	132	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах	“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 2019	70%

				оны 12 дугаар 01-ний өдрийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн.	
ЗГ-ын тогтоол					
52	133	Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 2021-04-28 Дугаар 2021_113	1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.	“Эрдэнэс Тавантолгой”ХК “Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” түлхүүр гардуулах нөхцөлтэй нээлттэй тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зарласан бөгөөд шалгаруулалтаар “Норинко Интернэшнл Күүперэшн” болон “Дэди инженеринг девелопмент групп” компаниудын ирүүлсэн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тул 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр ЕРС гэрээг байгуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2023 оны 12 дугаар сарын 30-ний байдлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн I модулийн бүтээн байгуулалтын гүйцэтгэл 65%-тай байна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь хатуу коксжих нүүрс, хагас коксжих нүүрс, завсрын бүтээгдэхүүн буюу эрчим хүчний нүүрс зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх бөгөөд техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу тус бүр нь жилд 10 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай 3 модуль буюу жилд нийт 30 сая тонн нүүрсийг хүлээн авч баяжуулах хүчин чадалтай үйлдвэр байхаар төлөвлөсөн. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс уг төслийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд I үе шатанд 10 сая.тн нүүрс хүлээн авч, баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулахаар, II үе шатанд 20 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг барихаар төлөвлөөд байна.	70%
53	134	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар,	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцооноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762.255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг “Эрдэнэт	70%

		<p>тухай 2021-05-05 Дугаар 2021_129</p>	<p>механикийн заводын өргөтгөл"-ийг тус тус "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.</p>	<p>үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан "Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцэж хүлээн авсан бөгөөд 362.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах "Уул уурхай, металлурги химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн ТЭЗҮ болон паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд 1590 сая, паркийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажилд 450.9 сая, үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрийн геоэкологи, гидрогеологийн суурь судалгааны ажилд 265.3 сая, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажилд 101.8 сая, автозамын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд 72.6 сая, төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 214.9 сая, ус хангамж, ариутгах татуургын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 590.8 сая, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулахад 68 сая, диспетчерийн үндэсний төвөөр горимын тооцоо хийлгэхэд 29.7 сая, 3 ширхэг дэд станцын техникийн нөхцөл гаргуулах төлбөрт 4.5 сая, үйлдвэрлэл, технологийн парк тойруулан хашаа барих ажилд 1168.6 сая, паркийн авто зам барьж байгуулах 4673.3, төмөр зам барьж байгуулах ажилд 9638 сая, паркийн цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд 351.5 сая, ҮТП-ийн хашаа 3,469.2, ЗББҮ-ийн ТЭЗҮ боловсруулахад 3340.4 сая, фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил 148.8 сая, аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын стандартуудыг боловсруулж, батлуулах 207.6 сая, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд 118.8 сая, ЗББҮ-ээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажилд 11349.2 сая, ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ 150 сая, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор</p>	
--	--	---	--	--	--

				катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 1.597.6 сая нийт 38.506.55 сая төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна.	
54	135	Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-10-20 Дугаар 2021_321	4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /Хөтөлбөрийн нэр/, индексийг БШУ-ны сайдын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/160 тушаалаар батлуулж, агуулга ижил, оновчгүй болон элсэлтгүй 1086 сургалтын хөтөлбөрийг хаасан. Орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газраас баталсан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн жагсаалттай уялдуулан 2022 оны "Төрийн өмчийн зарим боловсролын сургалтын байгууллагын талаар авах арга хэмжээний тухай" 293 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн дээд сургууль болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн харьяанд Эрдэнэт политехник коллежийг шинээр байгуулан Дорнод их сургуулийг Монгол Улсын их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль, Ховд их сургуулийг Монгол Улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийг Монгол Улсын Боловсролын их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль зэрэг орон нутаг дахь 6 их, дээд сургуулийн харьяалал, ангиллыг өөрчлөн зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд Дорнод аймаг дахь “Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв”-ийн Ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, эхний ээлжийн барилгажилтын зураг болон Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгууд дахь “Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор”-ын Ерөнхий төлөвлөгөөний загвар, ТЭЗҮ-ний ажлын даалгавруудын төслийг 2022 онд хийж гүйцэтгэсэн.	100%
				Үр нөлөө: Орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий	

				<p>төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулж байна.</p>	
136			<p>5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн “Эрдэнэт” сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга</p>	<p>Тогтоолын 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авсан. Тухайлбал, Өмнөговьд барих сургалт-эрдэм шинжилгээ-үйлдэрлэлийн цогцолборын ТЭЗҮ-г “Оюутолгой”ХХК-ийн санхүүжилтээр 2023 оны 07 дугаар сард, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай 2022 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд Орхон аймаг дахь “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хариуцан ажиллаж байна. Тогтоолын 1.1. дурдсан Дархан-Уул аймагт их сургуулийн цогцолборын газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 01/А-22 дугаартай захирамжаар Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багт 300,000 мкв газрыг боловсролын байгууллагын зориулалтаар 2 жилийн хугацаатайгаар олгосон.</p> <p>Үр нөлөө: Тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудтай хамтран сургалт-эрдэм шинжилгээ-үйлдэрлэлийн цогцолборын ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна.</p>	100%

			С.Батжаргал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай.		
55	137	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Яамны албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд үе шаттайгаар сургалтыг зохион байгуулж байна. Анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 онд Чингэлтэй дүүргийн “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран зохион байгуулсан. Дунд шатны буюу бичгийн чадвар сайжруулах чиглэлээр яамны албан хаагчдаас санал авч 2024 онд сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн болно. Ашигт малтмал, газрын тосны газар нь Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гадна хаяг болон Уул уурхай, газрын тосны төв лаборатори, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын хаягийг тус бүр Монгол бичиг болгож шинэчилсэн. Мөн удирдах албан тушаалтнууд өөрсдийн нэрийн хуудсаа монгол бичгээр шинэчлэн өөрчилж албан хэрэгцээндээ ашиглаж байна. 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын долоон өдөр 10:00-12:00 цаг хүртэл хурлын зааланд хэлтэс тус бүрийн тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнүүдийг монгол бичгийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн удирдлагууд гадаад, дотоод томилолтоор ажиллахдаа нэрийн хуудсаа Монгол бичгээр хэвлүүлэн бэлдэж хэрэглэдэг болсон. Ашигт малтмал, газрын тосны газар нь энэ оны 09 дүгээр сард багтааж албан хаагчдын өрөө тасалгааны хаягийг Монгол бичиг болгохоор нийт 51 өрөөний хаягийг монгол бичиг рүү хөрвүүлж шинэчилсэн.	100%
56	138	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай	2. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг газрын тос импортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтээр шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын улсын хилийн зурваст газрын тосны шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг баталсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тус 2 боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын	100%

		2022-01-26 Дугаар 2022_53		хэсгийг УУХҮ-ийн Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад "Шунхлай"ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №21, №22 дугаартай гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Өнөөгийн байдлаар Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрлах Гашуунсухайт хилийн боомт дахь газрын тосны бүтээгдэхүүний 8600м3 багтаамжтай, жилд 350-400 мянган тонн бүтээгдэхүүн шилжүүлэн ачих хүчин чадал бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төслийн ажлын гүйцэтгэл 90 хувь, инженер, геологийн судалгааны ажил 100 хувь, өндөршилт, нягтруулалт тэгшилгээний ажил 60 хувь, савны материал худалдан авалтын гүйцэтгэл 100 хувьтай үргэлжилж байна. Харин Өмнөговь аймгийн Гурван тэс суманд байрлах Шивээхүрэн хилийн боомт дагуу 1200м3 багтаамжтай, жилд 50-60 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих хүчин чадал бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахын байгууламжийн гүйцэтгэлийн явц 90 хувь, авто замын төлөвлөлт, гүйцэтгэлийн ажил 70 хувьтай үргэлжилж байна. Төслийн гүйцэтгэлд АМГТГ тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.	
57	139	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны төсвийн төслийн санал, 2025-2026 оны төсөөллийг боловсруулан 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1975 дугаартай албан бичгээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2024 оны урсгал зардлын хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалд Төрийн захиргааны албан хаагчдын мэргэшүүлэх сургалтад 25.4 сая төгрөгийг тусгуулах саналыг хүргүүлсэн бөгөөд 2024 оны төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны урсгал зардлын хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалд 7.5 сая төгрөгийг баталсан.	100%
58	140	Жагсаалт шинэчлэн батлах тухай	2. "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтын жагсаалт"-ыг хавсралт ёсоор	Хилийн зарим боомтыг шинээр нээснээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн импортын урсгалыг нэмэгдүүлж, үүсээд байсан хомсдолыг хэвийн болгон тогтворжуулсан. Тухайлбал	100%

		2022-05-31 Дугаар 2022_215	шинэчлэн баталсугай. 2. Хилийн зарим боомтоор шинээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллийг боомт бүрээр бэлтгэж, дипломат шугамаар хөрш улсуудтай харилцаж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус үүрэг болгосугай.	Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тэсрэх материалын импортыг хийх үйл ажиллагаа явагдаж байна. БНХАУ-ын талаас тэсрэх бодис импортоор авах асуудлаар БНХАУ-д суугаа Элчин сайдтай 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр цахим уулзалт хийсэн. Мөн хилийн Гашуунсухайт боомтоор тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох саналыг бэлтгэн Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн удирдлагатай хийх уулзалтад танилцуулсан бөгөөд БНХАУ-ын тал саналыг дэмжиж, холбогдох судалгааг хийж гүйцэтгэх талаар харилцан тохиролцсон. Мөн 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комисс V хуралдаанд “Хилийн зарим боомтоор шинээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох” саналыг хэлэлцүүлж, Ханги боомтоор тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох ажлыг эрчимжүүлэх талаар протоколд тусгуулсан.	
59	141	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-06-08 Дугаар 2022_229	1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн Онч хараат, Оорцог, Бортолгой хэсэгт хайгуул-судалгааны ажил гүйцэтгэж нөөцийг тогтоосны үндсэн дээр ил болон далд уурхайг нээж олборлолт эхлүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем нэвтрүүлж өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар) нарт тус тус даалгасугай.	1. Уурхай нээж олборлолт эхлүүлэх (ил болон далд): Тавантолгой ордын Ончхараат, Бортолгойн хэсэгт уурхай нээж, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхээр 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ЭТТХК/202312584 дугаарт тендерийг зарласан. 2. Конвейер: Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаан”-аар батлуулсан. Төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн ЭТТХК/202310502 дугаарт тендерийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан.	70%
	142		2. Шинээр нээх уурхайн санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн хувьд хэмнэлттэй шинэ дэвшилтэт техник, технологи бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг	Тавантолгой ордын Ончхараат, Бортолгойн хэсэгт уурхай нээж, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхээр 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ЭТТХК/202312584 дугаарт тендер зарласан. Тус тендерт шалгарсан оролцогч нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн хувьд хэмнэлттэй шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, эдгээрт шаардлагатай	70%

			татах замаар бүрдүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай.	хөрөнгө оруулалтыг бүрэн шийдвэрлэх талаар тендерийн баримт бичигт тусгасан.	
60	143	Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай 2022-09-05 Дугаар 2022_337	4. Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах ажлыг зохион байгуулж төлбөрийн үлдэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т, бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 337 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу АМГТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар "Ренова Илч" ХХК-тай Хар-Ус II, "Өмнөд Монголын газар нутгийн тос" ХХК-тай Номгон IX, "Монголиа Шин ий энерги" ХХК-тай Дарьганга XXIV, "Хонгконг Вэлпек Индастриал" ХХК-тай Хэрлэн тохой XXVIII талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг цуцалсан.	100%
61	144	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/30 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. УУХҮ-ийн Сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан "Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам"-ыг үндэслэн УУХҮ-ийн Сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/72 дугаар тушаалаар Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг "Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл" төрийн бус байгууллагад,	100%

			<p>Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451 мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p> <p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p>
--	--	--	--

				<p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/; Геоэкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/; Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/; Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38; Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/.</p> <p>/УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан "Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох" журмаар мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг ШУТИС-ийн механик, тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулиар гүйцэтгүүлж байна/</p>	
145		3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Засгийн газрын "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан "Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам"-ыг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/72 дугаар тушаалаар Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг "Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл" төрийн бус байгууллагад, Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг "Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл" төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, "Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл" ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ" 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн</p>	100%

				<p>мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451 мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p> <p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p> <p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/ Геозкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/ Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/ Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38 Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/ /УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан "Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох"</p>
--	--	--	--	--

				журмаар мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг ШУТИС-ийн механик, тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулиар гүйцэтгүүлж байна/	
62	146	Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай 2022-09-14 Дугаар 2022_349	4. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Д.Амарбаясгалан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт тус тус үүрэг болгосугай.	Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг “Смарт Эко транс”ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд төслийн ажлыг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр эхлүүлж ашиглалтад оруулсан.	100%
63	147	Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2022-10-05 Дугаар 2022_362	4. “Оюутолгой” ХХК, “Энержи Ресурс” ХХК, “Монголын алт” ХХК, “МоЭнко” ХХК зэрэг ашигт малтмал олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын экспортын үйл ажиллагаатай холбоотой гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	Тус яаманд “Оюутолгой”ХХК-иас БНХАУ-ын Ганцмодны боомтын зэсийн баяжмал тээврийн жолооч нараас 72 цаг тутамд 1 ПСР шинжилгээ авч байгааг 48 цаг болгох асуудлаар тус улсын талтай тохиролцсон тохиолдолд зэсийн баяжмалын экспортын хэмжээг 30 орчим хувиар нэмэгдүүлэх санал ирүүлснийг Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2022 оны 11 дүгээр сарын18-ны өдрийн 02/3051 дугаартай албан бичгээр уламжилсан. Үүний дагуу Хөх хот дахь Ерөнхий консулын газраас Баяннуур хотын Гадаад харилцаа боомтын алба, Ганцмод боомтын зөвлөлийн удирдлагатай утсаар холбогдож нөхцөл байдлыг тодруулан үүсээд буй “Оюу толгой” ХХК-ийн тээврийн жолооч нараас Хятадын талд авах 72 цагийн ПСР шинжилгээг 48 цагийн ПСР горимд шилжүүлэх талаар хүсэлт тавьсан. Ганцмод боомтын зөвлөлөөс асуудлыг судалж, тээврийн жолооч нараас 48 цагийн ПСР шинжилгээний горимд шилжүүлсэн талаар бидэнд мэдэгдсэн бөгөөд 150 жолоочийг 3 ээлжээр буюу эхний өдөр Монголын талд хоёр дахь өдөр Хятадын талд, гуравдахь өдөр хил нэвтрэн тээвэр хийж, уг өдрөө Монголын талд шинжилгээнд орох байдлаар тээврийн тасралтгүй зохион байгуулалтыг хэрэгжүүлэх боломжтой болсон. БНХАУ-ын Шивээхүрэн боомтын талд байгаа экспортод гаргасан нүүрсийг татан авах асуудлаар тус улсын талтай харилцан тохиролцох тухай Монголын алт (МАК) ХХК-иас	100%

				тус яаманд ирүүлсэн саналыг Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 02/3051 дүгээр албан бичгээр уламжилсан. Мөн хилийн Гашуунсухайт боомтын нүүрсний тээврийг эрчимжүүлэх асуудлыг Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн удирдлагатай хийсэн уулзалтад тавьсан. 2023 оны гүйцэтгэлээр нийт 69.6 сая тн нүүрс, 1.5 сая тн зэсийн баяжмал экспортод гарсан байна.	
148			6. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх, үргэлжлэн хэрэгжиж буй гэрээг 2022 онд багтаан шинэчлэх арга хэмжээ авахыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгож, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах талаар Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж зохих арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай.	Эдийн засаг, хөгжлийн дэд сайдын ахалсан Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна Тус яамнаас “Монголбанк”, “Ашигт малтмал, газрын тосны газар”, “Оюутолгой” ХХК, “Энержи ресурс” ХХК, “Монголын алт” ХХК, “МонЭнко” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Терра энерги” ХХК зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулсан санал солилцох уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд аж ахуйн нэгжүүдийн гэрээт ажлын төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх чиглэл өгсөн.	100%
149			11. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг 7 хоног тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Эдийн засаг, хөгжлийн дэд сайдаар ахлуулсан Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 7 хоног бүрийн мягмар гарагт тогтоолын хэрэгжилтийг гаргаж, Эдийн засаг, хөгжлийн яаманд цахимаар хүргүүлж байна.	100%
64	150	Ашигт малтмал хайх талбайн солбицол	3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай,	Ашигт малтмал, газрын тосны газраас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн шийдвэрээр дараах хайгуулын тусгай зөвшөөрлийг	100%

		батлах, эрх олгох тухай 2022-10-19 Дугаар 2022_379	хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	3 жилийн хугацаатайгаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т олгосон. Үүнд: 1.XV-022166 дугаартай "Хужир" нэртэй 62520.16 гектар; 2.XV-022167 дугаартай "Хөх асгат" нэртэй 7521.09 гектар; 3.XV-022168 дугаартай "Согоот" нэртэй 4016.87 гектар; 4.XV-022169 дугаартай "Зөөхийн гол" нэртэй 3009.44 гектар; 5.XV-022170 дугаартай "Ундрах" нэртэй 21451.23 гектар; 6.XV-022171 дугаартай "Оюут" нэртэй 1032.75 гектар талбай. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах албан томилолтын үеэр буюу 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр дээрх тусгай зөвшөөрлүүдийг ерөнхий захирал Г.Ёндонд хүлээлгэн өгч тус талбайнуудад хайгуулын үйл ажиллагааг эхлүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Оюутын талбайд хайгуулын ажил, бусад талбайд суурь судалгааны ажлыг 2023 онд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж байна.	
65	151	Журам батлах тухай 2022-11-16 Дугаар 2022_406	2. "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээдийн тэсрэх материалын үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчинд тооллого явуулж, шинэчилсэн бүртгэл хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 406 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор УУХҮ-ийн Сайдын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн "Тооллого явуулах тухай" А/319 дугаартай тушаалаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тэсрэх материалын үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчинд тооллого явуулж, шинэчилсэн бүртгэл хийх "Ажлын хэсэг"-ийг байгуулсан. Ажлын хэсэг үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах нийт 107 тусгай зөвшөөрөлтэй 94 аж ахуйн нэгжийн үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинд тооллого явуулсан.	100%

66	152	Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_417	3. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан холбогдох яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих өөрчлөлт оруулах шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагч нарыг яамны зохих бүтцийн нэгжид шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд салбарын мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 11 ажлын байр шилжин ирсэн. Уг албан хаагчдыг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар томилсон.	100%
67	153	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба зэрэг төсөвт байгууллагуудын албан хаагчдыг хөдөө орон нутагт шилжин ажиллах хүсэлтийг дэмжих чиглэл баримтлан ажиллаж байна. Мөн “Ашигт малтмалын тухай хууль”-д заасны дагуу гадаад ажилтны тоог нийт ажилтны 10 хувиас хэтрүүлэхгүй байх, Монгол ажилтнуудын 5-аас доошгүй хувийг уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тухайн сум, дүүргийн иргэдээс бүрдүүлэх, хуульд зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, хуульд зааснаас бага хэмжээгээр орон нутгийн иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр ногдуулах арга хэмжээ авч байна.	100%
68	154	Дүрэм батлах тухай 2022-12-07 Дугаар 2022_445	3. Батлагдсан дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангуулах чиг үүрэг бүхий байгууллагын удирдлагад тус	Дүрмийн хэрэгжилтийг хангах ажлыг Ашигт малтмал, газрын тосны газар болон бусад төрийн байгууллагууд хариуцан ажиллаж байна.	100%

			тус үүрэг болгосугай. 3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.		
69	155	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны багцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно.	Х.Б

			дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.		
70	156	“Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-09 Дугаар 2022_450	3.5. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;	Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн, хамтарсан шалгалт хийх удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэгт тус яамнаас төлөөлөл ажиллаж байна. Ажлын хэсгийн хурал 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, 04 дүгээр сарын 07-ны өдрүүдэд болсон бөгөөд санал, дүгнэлт боловсруулан 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.	70%
71	157	Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2022-12-21 Дугаар 2022_469	4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд салбарын мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 11 ажлын байр шилжин ирсэн. Уг албан хаагчдыг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар томилсон.	100%
72	158	Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476	8. Авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шуурхай шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай.	ЗТХЯ-аас ирүүлсэн 2023 оны 03/1301 дугаартай албан бичигт дурдсан асуудлыг “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.18, 11.1.22 дахь заалтыг үндэслэн “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто зам болон Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбосон трасстай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбай, салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн газар давхцалтай эсэхийг шалган, холбогдох мэдээллийг ЗТХЯ-нд 2023 оны 06 дугаар сарын 21-ний 03/1541 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Дээрх трассын дагуу давхцсан талбай байхгүй тул түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол, эрх олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	100%

73	159	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	2. Энэ тогтоолын 1-д заасан төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, хяналтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг салбарын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/125 дугаар тушаалаар улсын хэмжээнд 2023 онд геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын чиглэлээр хийгдэх хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталсан. Улсын хэмжээнд 2023 онд ХНХЯ, ЭМЯ, БШУЯ, ЗТХЯ, БХБЯ-дуудтай хамтран хийгдэх төлөвлөгөөт хяналт шалгалтын 06-00/005 дугаартай удирдамжийг салбарын ерөнхий байцаагчийн 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр баталж, аймаг нийслэлийн Засаг дарга нарт 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 11/1254 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. УУХҮ-ийн Сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу ажилласан.	100%
74	160	Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай 2023-01-25 Дугаар 2023_35	2. Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизель түлшний хангамж, нийлүүлэлт, жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Ц.Уртнасан) нарт үүрэг болгосугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас тус тогтоолын хэрэгжилтийг хангах болон шатахууны үнийн өсөлтийг сааруулах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын “Роснефть” НХН-тэй удаа дараа хэлцэл хийсний үр дүнд 2023 оны 01 дүгээр сараас дизель түлшний үнийг дахин 5 хувь буюу нийт 10 хувь бууруулахаар тохиролцсон байсныг өөрчилж, энэхүү хөнгөлөлтийг өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн үнэд шилжүүлэн тооцуулснаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Аи-92 автобензин хил үнийг тонн тутамд 758 ам.доллар, 2023 оны 4 дүгээр сараас тонн тутамд 705 ам.доллар болгон тус тус бууруулсан. Ингэснээр өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн дотоод дахь жижиглэн борлуулалтын үнэ литр тутамд 2390 төгрөг хэвээр үргэлжилж байна. 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар А-80 автобензин 34 хоног, Аи-92 автобензин 21 хоног, Аи-95 автобензин 45 хоног, дизель түлш 27 хоног, ТС-1 онгоцны түлш 22 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна.	100%
75	161	“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай	4. “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын төслийн нэгж буюу бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулагдсан үед УУХҮЯ-ны зүгээс төрийн захиргааны болон нутгийн захиргааны холбогдох байгууллагатай салбар хоорондын уялдааг хангах замаар үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах болно.	Х.Б

		2023-02-01 Дугаар 2023_40			
76	162	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
77	163	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар гүйцэтгүүлэх тухай 2023-02-08 Дугаар 2023_59	3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй.	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн борлуулалтын гэрээний асуудлаар ирүүлсэн санал хүсэлтүүдийг уламжлан ЭЗХЯ-нд 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2321 дугаартай албан бичгээр, ЭЗХЯ, Сангийн яам болон “Монголын хөрөнгийн бирж”ХК-д 2023 оны 11 дүгээр сарын 10-ны 01/2683 дугаартай албан бичгээр, ГЕГ-т 2023 оны 11 дүгээр сарын 30-ны 01/2836 дугаартай албан бичгээр тус тус холбогдох санал болон чиглэлийг хүргүүлж ажилласан. “Монголын хөрөнгийн бирж”ХК-иар дамжуулан 2023 онд ил тод, дуудлага худалдаагаар 14.9 сая.тн нүүрс, 604.8 мян.тн төмрийн баяжмалыг тус тус арилжиж нийт 2.186.2 сая ам.долларын борлуулалтын орлого олохын зэрэгцээ үнийн өсөлтөөс хамаарч 155.3 сая ам.долларын нэмэлт орлого олсон эерэг үзүүлэлт гарсан байна.	100%
78	164	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж	“Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоолын хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Хөдөөгийн сэргэлт” чуулганд Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба болон салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулж, чуулганаас гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлийг өгч ажилласан. Мөн хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит	70%

			байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2024 оны төсвийн төсөлд 50.0 сая төгрөг зарцуулахаар тусгасан. Хот хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд УУХҮЯ-наас тусгах саналыг боловсруулан хүргүүлэхээр ажиллаж байна.	
79	165	“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-03-01 Дугаар 2023_82	4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрчис ойл” ХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Ж.Ганбаатар)-нд даалгасугай.	УУХҮ-ийн Сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/258 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь “Эрчис Ойл”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн, хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэн, дүгнэлт гаргасан. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар АТГ хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/14168 дугаартай албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/304 дүгээр тушаалаар “Эрчис Ойл”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг томилж үйл ажиллагааг эхлүүлсэн.	100%
	166		5. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрчимжүүлэхийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэгт, ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай.	Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд ЕРС-1-ийн барилга угсралтад шаардлагатай бараа материалыг импортлох, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх, төлбөрийн нэхэмжлэлийг баталгаажуулах тухай 112 хүсэлтийг Сангийн яаманд, төслийн хүрээнд гадаадаас ажиллах хүч авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх 6 хүсэлтийг ХНХЯ-нд, /ЕРС-2/, /ЕРС-3/ багц ажлуудын барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэх хүсэлтийг БХБЯ-нд, үйлдвэрт түүхий тос нийлүүлэх асуудлаар БНХАУ-ын холбогдох байгууллага, компанид санал тавих тухай хүсэлтийг ГХЯ-нд тухай бүр санал хүргүүлж ажиллав. Төсөл хэрэгжүүлэгч МГТБҮ ТӨХХК нь ЕРС-02 болон ЕРС-03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан компанитай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, ЕРС-04 багц ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй 2023 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулсан.	100%

80	167	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.1. “Аж үйлдвэрийн сэргэлт”-ийн бодлогод тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад чиглэсэн техник, технологи, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны ажлын жагсаалт гаргаж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт;	Улсын Их Хурлын баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Өнөөгийн байдлаар Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, ил уурхайн техник, эдийн засгийн үндэслэл зэргийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан байна.	100%
	168		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	ХБНГУ-ын Гео-шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн /BGR/-тэй хамтран хэрэгжүүлж байгаа “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулах ажлыг ажлын хэсгийн хүрээнд эхлүүлээд байна.	30%
81	169	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-04-12 Дугаар 2023_129	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай.	1. Сүхбаатар аймгийн Бичигт боомтыг хатуу хучилттай авто замаар холбох зорилтын хүрээнд “Эрээнтөлгой” нүүрсний уурхайгаас “Бичигтийн боомт” хүртэлх 110.3 км барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох асуудлыг Засгийн газрын 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2.Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох	100%

				<p>асуудлыг Засгийн газрын 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>3.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хужирт-Бат-Өлзийт чиглэлийн 49 км барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох асуудлыг Засгийн газрын 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p>	
82	170	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-04-12 Дугаар 2023_130	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 130 дугаар тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймагт хийгдэж буй Алтанцөгц сумын 3 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 1 дүгээр хавсралт, Алтай сумын 2.4 км цемент бетон хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 2 дугаар хавсралт, Улаанхус сумын 24.7 метр урт төмөр бетон гүүрний авто зам, барилга угсралтын ажилд шаардагдах санхүүжилт батлагдсан. Батлагдсан солбицлын дагуу гүйцэтгэгч хуулийн этгээдэд ТТАМ ашиглах эрхийг орон нутгийн захиргааны байгууллага шийдвэрлэсэн.	100%
83	171	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160	1.1. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2023 оны 96 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж ажлын хэсгийн гишүүдэд холбогдох асуудлаар санал боловсруулан танилцуулах үүргийг өгөөд ажиллаж байна. Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд өөр өөрсдийн хариуцсан чиг үүргийн мэдээллийг бэлтгэж нэгтгэсэн. Тухайн асуудлаар ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдрүүдэд БНХАУ-д ажиллаж “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дай Хоулян болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Монгол Улсын	70%

			холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах ажлын хэсэг томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Хятадын талын ажлын хэсгийг “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн дэд захирал Жан Даовэй ахлан ажиллахаар болсон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх Монголын талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан.	
172		1.2. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой татварын маргааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт;	Тус яамнаас “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж тэмдэглэл гаргуулсан. Татварын ерөнхий газар нь “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээний зүйл, заалт, холбогдох тооцоолол, мэдээллийг хамтран нягталж шалгаж нэгдсэн саналд хүрэх шаардлагатай гэж үзэж байна. 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Татварын ерөнхий газрын дэргэдэх “Татварын маргаан таслах зөвлөл”-өөс энэхүү татварын маргааныг дахин хэлэлцээд шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлж, дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцаасугай гэж, мөн Татварын Ерөнхий Газрын дэргэдэх “Татварын маргаан таслах зөвлөл” 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 дүгээр шийтгэлийн хуудсыг хэвээр баталсугай гэж тус тус шийдвэрлэсэн. 2011 онд мөн адил асуудлаар татварын байцаагч 210098 тоот шийтгэлийн хуудсаар тавигдсан 350.7 тэрбум төгрөгийн торгууль, төлбөрийг “Татварын маргаан таслах зөвлөл” 26 дугаар тогтоолоор хүчингүй болгож байсан байна.	100%
173		2. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад	“Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга	100%

			харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	хэмжээний талаар өгөгдсөн үүрэг, чиглэлийн дагуу ажлууд хийгдэж, тухай бүр Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлэн ажиллаж байна. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сар бүр боловсруулан, шинэчилж ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.	
84	174	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-17 Дугаар 2023_179	1. “Газрын ховор элементийн судалгааны төслийн нэгж”-ийг татан буулгаж, чиг үүрэг, орон тоог “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн) нарт тус тус даалгасугай.	“Газрын ховор элементийн судалгааны төслийн нэгж”-ийг татан буулгаж, чиг үүрэг, орон тоог “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх арга хэмжээ авсан. Төслийн нэгжийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг “Эрдэнэс Монгол” ХХК цаашид үргэлжлүүлэн газрын ховор элементийн хэтийн төлөвтэй талбайд геологийн тойм судалгааны ажлыг гүйцэтгэж байна.	70%
85	175	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-05-17 Дугаар 2023_187	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 онд байгуулагдсан Зээлийн хэлэлцээр (МОН-3387) дугаартай “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын хилийн боомтын тусгаарлах зурвас бүхий авто зам, авто зогсоол, боомтын зам талбайн барилга угсралтын ажилд шаардагдах “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 187 дугаар тогтоол батлагдсан. Батлагдсан солбицлын дагуу гүйцэтгэгч хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийг орон нутгийн захиргааны байгууллага шийдвэрлэсэн.	Х.Б
86	176	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-05-17 Дугаар 2023_188	3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2016 онд байгуулагдсан Зээлийн хэлэлцээр (МОН-3387) дугаартай “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын хилийн боомтын тусгаарлах зурвас бүхий авто зам, авто зогсоол, боомтын зам талбайн барилга угсралтын ажилд шаардагдах “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 187 дугаар тогтоол батлагдсан. Батлагдсан солбицлын дагуу гүйцэтгэгч хуулийн этгээдэд түгээмэл тархацтай	100%

			өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж нарт үүрэг болгосугай.	ашигт малтмал ашиглах эрхийг орон нутгийн захиргааны байгууллага шийдвэрлэсэн.	
87	177	Жагсаалт шинэчлэн батлах тухай 2023-05-24 Дугаар 2023_202	2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.	"Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсаны дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн эргэлтэд холбогдох байгууллагуудын хамтаар хяналт тавьж ажилласан.	100%
88	178	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын цалинг 2023 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын батлагдсан төсөвт багтаан шинэчлэн баталсан.	100%
89	179	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2023-06-21 Дугаар 2023_245	2. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2024 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн хязгаарыг батлах тухай Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 245 тогтоолын хүрээнд УУХҮ-ийн Сайдын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсөөллийг боловсруулан 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1975 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Төсвийн бодлогын газартай холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. Мөн УУХҮ-ийн Сайдын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсөөллийн саналыг 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1976 дугаартай албан бичгээр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хүргүүлсэн.	100%
90	180	"Журам батлах тухай"	2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд, тогтоолын хэрэгжилтэд хяналт	Тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан 2023 оны байдлаар нийт 14 хүсэлт ирснээс төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 9 аж ахуйн нэгжид,	100%

		/Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх/ Засгийн газрын тогтоол 2023-07-05 Дугаар 2023_251	тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.	машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 аж ахуйн нэгжид, үнэт металл эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 аж ахуйн нэгж байгууллагад нийт 11 ААНБ-ын тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олголт, сунгалтыг хийж, журмын дагуу зөвшөөрлийн нэгдсэн санд мэдээллийг байршуулсан байна.	
181			1.2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай.	<p>Газрын тос:Газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн хүрээг тэлэх, өрсөлдөөнийг дэмжих, үнийн уян хатан бодлого зохицуулалтад эерэг нөлөөлөл үзүүлэх үүднээс бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийг 100 хувь цахимжуулсан. Шинээр батлагдсан “Зөвшөөрлийн тухай хууль”-д нийцүүлэн “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу бичиг баримт бүрдүүлэлтийн олон шат дамжлагыг бууруулж, бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийн талаарх хүсэлтийг www.license.mn цахим системээр хүлээн авч шуурхай шийдвэрлэж байна.</p> <p>Хүнд үйлдвэр:</p> <p>1.Зөвшөөрлийн нэгдсэн санд хандах хэрэглэгчийн эрхийн тохиргоо нэмэх талаар хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн. Тусгай зөвшөөрлийн цахим системээр олгогдож буй зөвшөөрлүүдийн хувьд журмын хэрэгжилт бүрэн хангагдсан бөгөөд цахим системээр дамжин зөвшөөрлийн нэгдсэн санд шууд бүртгэгдэж байна.</p> <p>2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 03/2064 дугаартай албан бичгээр Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх асуудлаар Тагнуулын ерөнхий газраас тодруулга хүссэн бөгөөд тус газраас 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн ТЕГ01/321 дүгээр албан бичгээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь терроризм, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэлтэй, онцгой бүтээгдэхүүн учир тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн мэдээллийг ил тод болгож, цахим системд байрлуулах, тусгай зөвшөөрлүүдийг цахим хэлбэрээр олгох саналыг дэмжихгүй байгаа талаар мэдэгдсэн.</p>	100%

91	182	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2023-07-05 Дугаар 2023_265	2. Энэ тогтоолын 1-д заасан улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай газрыг солих буюу эргүүлэн авах, шаардагдах зардал, газар чөлөөлөх хугацааг тооцож, тохиролцох асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн нарт тус тус үүрэг болгосугай.	АМГТГ-ын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/161 дүгээр тушаалаар "Матад-ХХ" талбайн тусгай хэрэгцээний газартай давхцал бүхий газартай иргэдтэй нөхөн олговрыг тохиролцох гэрээ байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.	30%
92	183	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг боловсруулан төсвийн төслийн саналд тусган төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1974 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөлтийг Хөрөнгө оруулалтын шинэчилсэн Pimis программаар төлөвлөсөн.	100%
93	184	Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай 2023-07-19 Дугаар 2023_280	2.. “Монгол-Хятадын экспо” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Х.Болорчулуун)-т, арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	БНХАУ-ын Хөх хотод 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Монгол-Хятадын экспо” арга хэмжээний үеэр Монголын Уул уурхайн үзэсгэлэнг гаргах ажлыг гүйцэтгэсэн.	100%

94	185	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2023 оны 10 дугаар сард эрүүл мэндийн сэдвээр (хоол зүй, сэтгэл зүй, нойр, дасгал, дархлаа, эрдэс) сургалт зохион байгуулсан.	100%
95	186	Халзан бүрэгтэйн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-09-06 Дугаар 2023_332	1. Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших Халзан бүрэгтэйн ордод хамаарах MV-012335, MV-006911 тоот тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж, орон нутгийн иргэдийн саналыг харгалзан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.	Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших Халзан бүрэгтэйн ордод хамаарах ашигт малтмалын MV-012335, MV-006911 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг эзэмшигч "Монголиан рийр ийрт корп" ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулж илэрсэн зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг нь түр зогсоосон.	100%
	187		2. Газрын ховор элемент болон ховор металлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт үүрэг болгосугай.	Газрын ховор элемент болон ховор металлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд боловсруулах ажлын өндөр технологийн түүхий эдийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	30%
96	188	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ЕРС-04 багц ажлын	1. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн ЕРС-04 багц ажлын хүрээнд	Төслийн ТЭЗҮ-д оруулсан тодотгосон ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж хүлээн авсан.	100%

		санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай 2023-09-13 Дугаар 2023_336	шаардлагатай нэмэлт санхүүжилтийн дүнг нарийвчлан тооцсоны үндсэн дээр техник, эдийн засгийн үндэслэлд холбогдох нэмэлт оруулах асуудлыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, баталгаажуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгасугай.		
	189		6. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн гадаадын зээлийн эх үүсвэрийг эргэн төлөх нөхцөл бүхий дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг холбогдох хууль журмын дагуу байгуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг)-д нарт даалгасугай.	Сангийн яамнаас ирүүлсэн Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Засгийн газрын шийдвэрийн төсөлд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлсэн.	100%
97	190	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_337	2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Татварын ерөнхий газар (Б.Заяабал)-т тус тус даалгасугай.	Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам” батлагдсантай холбогдуулан татвар төлөх хугацааг сунгуулах, хэсэгчлэн төлөх хүсэлтээ ирүүлэх тухай албан бичгийг ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ифинити спейс”ХХК, “Си Өү Эй Эл”ХХК-д тус тус хүргүүлж, тус компанийн удирдлагуудыг УУХҮЯ-ны ТНБ-ын дарга болон ХҮБГ-ын дарга нар 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авч уулзан тулгамдаж байгаа асуудал, хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцож, “Си Өү Эй Эл”ХХК-аас ЗГХЭГ-ын даргад хандаж гаргасан гаалийн 400 горимоор импортоор оруулж ирсэн барааны гаалийн бүрдүүлэлтийг гаалийн 500 горимд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/2598 дугаартай албан бичгээр Сангийн яаманд уламжилсан.	70%
98	191	Түгээмэл тархацтай ашигт малтмал	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтад тусгагдсан хилийн Бичигт боомтыг хатуу хучилттай авто замаар холбох зорилтын	100%

		хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-09-20 Дугаар 2023_351	үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай.	хүрээнд Эрээнтөлгой нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 110.3 км тусгай зориулалтын авто зам, Бичигт боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд 16 талбайд 1.012.956.4 м3 түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийг шийдвэрлэсэн.	
99	192	Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг тогтоох тухай 2023-10-18 Дугаар 2023_385	2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай.	Тогтоолд заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор Ашигт малтмал, газрын тосны газар 2024 онд бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн гэрээг тогтоолын хавсралтад нэр дурдсан газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэгч аж ахуйн нэгж тус бүртэй шинэчлэн байгуулна. Гэрээ байгуулах ажил үргэлжилж байна. 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 34 хоног, Аи-92 автобензин 21 хоног, Аи-95 автобензин 45 хоног, дизель түлш 27 хоног, ТС-1 агаарын хөлгийн түлш 22 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна.	100%
100	193	Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон) 2023-11-22 Дугаар 2023_411	9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.	-	Х.Б
101	194	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар	1.3. 1.3. “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой үүссэн асуудлыг судалж, холбогдох хууль	“Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой үүссэн асуудлыг судалж Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт төлбөрийн акт тавихдаа “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 43 дугаар зүйлд хамаарах	100%

		<p>авах зарим арга хэмжээний тухай 2023-11-29 Дугаар 2023_413</p>	<p>тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт.</p>	<p>асуудлыг үндэслэсэн нь мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Энэ хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд ойлголтын зөрүү гаргасан байх магадлалтай талаар тайлбар хүргүүлсэн. Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 3 шатны шүүхээр уг асуудлыг хэлэлцээд давж заалдах эрхгүйгээр хүлээн авахаас татгалзсан шийдвэр гарсан талаар хариу ирүүлсэн.</p>	
102	195	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456</p>	<p>1.1.. 1 Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 1.1. .Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явЦ байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны багцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно.</p>	Х.Б
	196		<p>1.2.. 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны багцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно.</p>	Х.Б
	197		<p>1.3.. 1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны багцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно.</p>	Х.Б

			олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.		
103	198	2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481	4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллах талаар “Удирдлагын академи” дээр зохион байгуулсан хэлэлцүүлэгт УУХҮЯ-ны холбогдох газар, хэлтсийн албан хаагчид оролцсон.	100%
Ерөнхий сайдын захирамж					
104	199	Ажлын хэсэг байгуулах тухай 2023-03-02 Дугаар 2023_40	2. Геологи, уул уурхайн салбарт Бүгд Найрамдах Солонгос Улстай хамтран ажиллах хүрээнд ховор металл болон газрын ховор элементийн хамтарсан судалгааны төв байгуулах асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Бүгд Найрамдах Солонгос Улстай ховор металл болон газрын ховор элементийн хамтарсан судалгааны төв байгуулах талаар 2023 оны 01 дүгээр улиралд багтаан Солонгосын талтай хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, санал, дүгнэлтийг танилцуулахыг Ажлын хэсэг (Ж.Ганбаатар)-т даалгасугай.	БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулах Монгол, Солонгосын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах ажлын Солонгосын талаас гүйцэтгэгчээр Геологи, эрдэс баялгийн хүрээлэн /КИГАМ/, Уул уурхайн нөхөн сэргээлт, ашигт малтмалын корпорац /КОМИР/ ажиллаж байна. Гүйцэтгэгч байгууллагын төлөөллүүдтэй Монгол Улсад 2023 оны 07 дугаар сард 2 удаагийн биечилсэн уулзалт, Солонгосын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яам, Гадаад харилцааны яамтай 2023 оны 08 дугаар сард 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, Монгол-Солонгос Улс хоорондын хамтарсан хорооны хурлыг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Хамтарсан хорооны хуралд БНСУ-ын талаас Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний Дэд сайд Kyungsung Kang, Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Нүүрс, ашигт малтмалын хэлтсийн дарга Dae-hwan Jung, КОМИР-ын дэд ерөнхийлөгч, Soon-jin Kwon, КИГАМ-ын дэд ерөнхийлөгч Se-ho Hwang, КИАТ-ын ерөнхий захирал Cheon Kyo Park болон бусад төлөөлөл оролцсон. Гүйцэтгэгч байгууллага болох КИГАМ, КОМИР-ын зүгээс төлөвлөгөөний дагуу төслийн талаарх мэдээллийг төрийн албан хаагчид, салбарын эрдэмтэн судлаачдад өгөх зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11-ний өдрүүдэд “Уул уурхайн 7 хоног” арга хэмжээний үеэр холбогдох сургалтыг зохион байгуулсан. Байгуулахаар	100%

				зорьж байгаа судалгааны төвийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, холбогдох хүмүүстэй яриа хэлцэл хийх асуудлаар 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 08-ны өдрүүдэд БНСУ-д томилолтоор ажилласан. Бүгд Найрамдах Солонгос Улсын дэвшилтэт технологийн хүрээлэн болон Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам хоорондын “Солонгос-Монголын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах” төслийн хэлэлцээний тэмдэглэлийг Сангийн яамнаас өгсөн саналын дагуу 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 476 дугаар тогтоолоор гарын үсэг зурах эрхийг авч, албажсан хувилбарыг Сангийн сайдад хүргүүлсэн.	
105	200	Ажлын хэсэг байгуулах тухай 2024-01-05 Дугаар 2024_04	2. Ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх нэгдсэн санал, дүгнэлт боловсруулан 2024 оны 3 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (С.Амарсайхан)-т үүрэг болгосугай. (Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил, ашиглалт, бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай)	Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УУБГ-ын дарга ажиллаж, холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлсэн.	100%
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
106	201	2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл 2021-02-24 Дугаар 2021_13	XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт.”	“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй 13 хөгжлийн төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг УУХҮ-ийн Сайдын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/2820 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Мөн дээрх төслүүдийн хэрэгжилтийн явцын тайланг ЭЗХЯ-нд улирал тутамд тайлагнан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар төслүүд 38.04 хувийн хэрэгжилттэй.	100%
107	202		XII.4. 4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой	Олон улсын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар Засгийн газрын 2022 оны 03	100%

	<p>2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14</p>	<p>барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, тус бүтээн байгуулалтын ажлыг ойрын үед эхлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт, Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийг судлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;</p>	<p>дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко интернэйшнл” компани ажиллаж байгаа ба төслийн инженерчлэл-70,0%, худалдан авалт-35,5%, барилга угсралт-38,6%-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, техникийн зураг төслийн ажил - 90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй байна. Тус газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл нь ҮАБЗ-ийн зөвлөмж болон Засгийн газрын шийдвэрийн хүрээнд дотоодын түүхий эдэд тулгуурласан үйлдвэр байх юм. /Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь газрын тос дамжуулах хоолойн санхүүжүүлэгчээр оролцож байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэгчээр “МГТБҮ” ТӨХХК, гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко” компани ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар дөрвөн багц ажлын хүрээнд төслийн ерөнхий гүйцэтгэл 38.8% байна/</p>	
203		<p>XII.4. 6. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг дахин хянаад дүгнэлт гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;</p>	<p>“Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Дүгнэлтийг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 03/678 дугаартай албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.</p> <p>Дүгнэлтээр:</p> <p>1.ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх;</p>	100%

			<p>2.“Сымбат инженеринг” ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын “Шинхай групп”-ийн саналтай дүйцэх саналыг хэрэгжүүлэх;</p> <p>3. Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг “Монгол банк”-нд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх;</p> <p>4.Эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар “Түлхүүр гардуулах”-аар төсөл хэрэгжүүлэгчээр өөрөөр нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гадны банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах гэсэн дүгнэлт гарсан.</p>	
204		<p>XII.4. 9. Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” компани, Бүгд Найрамдах Франц Улсын “Орано” группын хамтран хэрэгжүүлж буй “Бадрах Энержи” ХХК-ийн төслийн талаарх байр сууриа тодорхой болгох, цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;</p>	<p>Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” компани, Бүгд Найрамдах Франц Улсын “Орано” группын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах “Зөөвч овоогийн орд”-ыг ашиглах туршилтын олборлолтыг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхэлсэн тул Засгийн газрын хуралдаанд танилцуулах шаардлагагүй болсон. Туршилтын хугацаа 2022 онд дууссан бөгөөд “Зөөвч-Овоогийн орд”-оос 7913 кг уран олборлосон. Туршилтын олборлолтыг эхлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг төрийн зарим байгууллагаас өгөхгүй, удаашралтай, эхлүүлэх эсэх нь тодорхойгүй байх үед энэ асуудлыг Засгийн газарт танилцуулах үүргийг өгсөн. Засгийн газарт танилцуулахаас өмнө “Бадрах Энержи” ХХК нь холбогдох зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн тул Засгийн газрын хуралдаанд дээрх асуудлыг танилцуулах шаардлагагүй болсон.</p>	100%
205		<p>XII.2.Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй</p>	<p>УУХҮ-ийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр</p>	100%

		<p>холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2021 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;</p>	<p>нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.5-д заасны дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан. Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.</p>		
108	206	<p>2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41</p>	<p>ХХҮИ.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах асуудлын хүрээнд зарим талбайн “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г цуцлан олон улсад нээлттэй сонгон шалгаруулалт зарлан хайгуулын ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна. УУХҮ-ийн Сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/248, А/249 дүгээр тушаалаар “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Засгийн газрын тогтоолоор цуцалсан, гэрээний хугацаа дуусгавар болсон, гэрээлэгчгүй байсан зэрэг нийт 15 талбайд газрын тосны хайгуулын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. Сонгон шалгаруулалтад 4 талбайд аж ахуйн нэгжүүдээс санал ирүүлж “Газрын тосны тухай хууль”, “Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу</p>	100%

			судалгаа, тооцоог хийж, нөөц болон олборлолтыг өсгөх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав;	гүйцэтгэгчийг тодруулсан. Засгийн газрын хуралдаанаар 1 талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ хэлэлцүүлэхэд бэлэн болсон ба 2 талбайд гэрээний төсөлд холбогдох яамдуудаас санал авах шатанд, 1 талбайн гэрээний төслийг холбогдох хуульд нийцүүлэхээр Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна.	
109	207	2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2021-08-18 Дугаар 2021_47	XIY.5.Шатахууны үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаа болон бусад улс орны туршлага, эрх зүйн орчин, хүрэх үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан шатахууны үнийг тогтворжуулах сан байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтын эх үүсвэрийн талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав.	Тус тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус боловсруулж, санал авахаар УУХҮ-ийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/2432 дугаартай албан бичгээр яамдад хүргүүлсэн. Тус хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар Сангийн яамнаас санал ирүүлсэн тул хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй болсон.	Х.Б
110	208	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55	XV.13.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэдэх “Эрдэнэс газ” төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хаянхярваад;	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэдэх “Эрдэнэс газ” төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулах асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын албаны дарга Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс монгол” ХК-ийн дэд дарга Энхболд, “Эрдэнэс газ” төслийн нэгжийн дарга Амарсайхан нар уулзалт зохион байгуулсан ба “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шаардлагагүй гэж үзсэн.	100%
111	209	2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл 2021-11-10 Дугаар 2021_59	XIII.5.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд	Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн ажил эрчимтэй явагдаж байна. Монгол Улсын Засгийн газар болон "Газпром" НХН-ийн хамтарсан ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу 2021 онд төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, 2022 онд хий дамжуулах хоолойн шугамын чигийн дагуу нарийвчилсан инженерийн	70%

			<p>танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан уг төслийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав: 1.1. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; 1.2. Байгалийн хий нийлүүлэх магистраль шугамнаас Монгол Улс өөрийн дотоодын хийн хэргэлгээгээ авах эсэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт; 1.3. Уг төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт.</p>	<p>хайгуул судалгааг гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар талууд 2023 ондоо зураг төслийн баримт бичгийг боловсруулан дуусгаж, 2024 онд барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөгөөтэй эрчимтэй ажиллаж байна. Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авахаар Туркийн "BOTAS", Азербайжаны "SOCAR" компаниудтай хэлцэл хийж байна.</p>	
112	210	<p>2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл 2022-01-05 Дугаар 2022_1</p>	<p>ХХ.12.1. Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны суурь нөхцөл, олборлох технологи, нөлөөллийг тодорхойлсон Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал</p>	<p>УУХҮЯ-ны захиалгаар “Шинжлэх ухаан, технологийн сан”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр “Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны мониторинг үнэлгээ” сэдэвт судалгааны ажлыг Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн. БШУЯ-ны ШУТ-ийн салбар зөвлөлөөр 2022 оны 10 дугаар сард төслийн гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд тус төслийг ШУА-ийн “Хими, химийн технологийн хүрээлэн” гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/517 дугаар тушаалаар “Дорноговь аймгийн Улаанбадрах суманд орших ураны орд газрын байгаль орчны мониторинг” сэдэвт төслийг 3 жилийн хугацаатай ШУА-ийн “Хими, химийн технологийн хүрээлэн” хэрэгжүүлж байна.</p>	100%

			жуулчлалын сайд Н.Уртнасан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав;		
113	211	2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 6 дугаар тэмдэглэл 2022-01-26 Дугаар 2022_6	IX.9.2. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан тус хуулийн төсөлд ашигт малтмалын нөөц ашиглахтай холбогдолтой зарим татварыг орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалт тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;	Уг асуудлаар Сангийн сайдаас ирүүлсэн Засгийн газрын тогтоолын төсөлд 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2979 дугаартай албан бичгээр “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”-ын төслийн 7.3-т “Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 7.2-т заасны дагуу хувиарлалтыг хийхдээ хүн амын тоо-33 хувь, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ-34 хувь, ашигт малтмалын болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ-33 хувиар” гэснийг “Ашигт малтмал болон газрын тосны хайгуул ашиглалтын талбайн хэмжээ 100 хувь” гэж өөрчлөх саналыг хүргүүлсэн.	70%
	212		IX.9.4. Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар 2022 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт.	“Ханбогд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040” төлөвлөлтийн баримт бичгийн санхүүжилтийг “Оюутолгой” ХХК, “Цогтцэций сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иуд хариуцан ажилласан.	70%
	213		IX.10.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн “Техник эдийн засгийн үндэслэл”-ийг ОХУ-ын “Газпром” НХН-тэй хамтран баталсан талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, барилгын ажлыг 2024 оноос өмнө эхлүүлэх чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай,	Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн ажил эрчимтэй явагдаж байна. Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” НХН-ийн хамтарсан ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу 2021 онд төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, 2022 онд хий дамжуулах хоолойн шугамын чигийн дагуу нарийвчилсан инженерийн хайгуул судалгааг гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар талууд 2023 ондоо зураг төслийн баримт бичгийг боловсруулан дуусгаж, 2024 онд барилга угсралтын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй эрчимтэй ажиллаж байна. Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авахаар Туркийн “BOTAS”, Азербайжаны “SOCAR” компаниудтай хэлцэл хийж байна.	100%

			хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав.		
114	214	2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12	<p>Х.4.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх гэрээний багцын тендерийн ажлын явц, төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал, бүтээгдэхүүний үнийн тооцоолол, өөрчлөлт цар тахлын үеийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал, төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай бараа, материал, машин механизм, тээвэрлэлтийн асуудлаар холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөгжлийн банкны зээлийн хүүг бууруулах, үйлдвэрийн түүхий эдийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэргийг судлан үзэж, холбогдох тооцоо, судалгаа хийн Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар 21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг (Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан)-т танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт;</p>	<p>Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг 2021 оны 122, 133 дугаар, 2022 оны 156 дугаар захирамжаар тус тус шинэчлэн байгуулсан. Төслийн явц, тулгамдаж буй асуудлаар 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Шадар сайдын ахалсан ажлын хэсэгт танилцуулсан. Мөн УУХҮ-ийн Сайдын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/197 дугаар тушаалаар төслийн санхүүжилт болон “Хөгжлийн банк”-ны санхүүжилтэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий СЯ, ХБ, УУХҮЯ, МГТБҮ-ийн төлөөллөөс бүрдүүлсэн ажлын хэсгийг УУХҮ-ийн Дэд сайдаар ахлуулан ажиллуулсан. “Хөгжлийн банк”-ны санхүүжилтэд үүссэн асуудалтай холбогдуулан төсөл хэрэгжүүлэгч компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоох нь зүйтэй гэж үзэж Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар “МГТБҮ” ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж 82 дугаар тогтоолыг батлуулсан. Төслийн тендер шалгаруулалтыг дуусгаж ЕРС2, ЕРС3, ЕРС4 багцын ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын "Megha Engineering Infrastructure Limited" компанитай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус гэрээ байгуулсан. Төслийн нийт хөрөнгө оруулалт өссөнтэй холбогдуулан төслийн ТЭЗҮ-ийн тодотголыг УУХҮЯ-ны “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авахаар шийдвэрлэсэн. Цар тахлын үед БНХАУ, БНЭУ-д суугаа элчин сайдын яамтай хамтран бараа материалын татан авалтыг шуурхай зохион байгуулж ажилласан. Төсөлд нийлүүлэх бараа, материалын зээлдүүлэгчийн талын эзлэх хувийг бууруулах талаар төсөл хэрэгжүүлэгчээс Энэтхэгийн талд хүсэлт тавьж, 2019 онд 75%-аас 65%, 2022 оны 03 дугаар сард I, II багцыг 65%-аас 55%, 2022 оны 05 дугаар сард II, III, IV багцыг 50% болгож бууруулсан.</p>	100%

115	215	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	<p>ХҮИИ.10.“Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 5.1-д заасны дагуу аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулан Засгийн газрын хуралдаанд 2022 оны 4 дүгээр сард багтаан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт даалгав.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж” Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>	100%
	216		<p>ХҮИИ.11.“Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 4.8-д заасны дагуу эрчим хүчний салбарт цөмийн эрчим хүч ашиглах чиглэлээр баримтлах бодлогын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг Монгол Улсад ашиглах суурь судалгааны ажлыг эхлүүлж, цаашид бодлогын ямар чиглэл баримтлах талаар саналаа боловсруулан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цөмийн энергийн комиссын дарга Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх,</p>	<p>“Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө”-г (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахтай холбогдуулан Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих 12 төслийн танилцуулга мэдээлэл, Аж үйлдвэржилтийн сэргэлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө гэх мэт 53 хуудас материалыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>	100%

			Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав.		
116	217	2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2022-03-23 Дугаар 2022_17	IX.2.3. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд төрийн өмчит болон оролцоотой уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг Монголбанканд төвлөрүүлэх талаар судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав;	“Эрдэнэс-Тавантолгой”ХК болон БНХАУ-ын “Чалко Трэйдинг Хонгконг” компани хооронд байгуулсан “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”-ний гол нөхцлүүдийг сайжруулан 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөрийг хүлээн авч “Монгол банк”-д төвлөрүүлэх асуудлыг Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн. Мөн “Оюутолгой” ХХК нь 2022 оны 04 дүгээр сараас хойш гадаад валютын эх үүсвэрийг 100% “Монгол банк”-нд төвлөрүүлж байна.	100%
	218		IX.3.3. Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг судлан санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт нарт;	Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийн талаар судлах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах асуудлаар холбогдох байгууллагаас санал ирүүлээгүй байна.	30%
	219		IX.4. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт томилолтоор ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд “Асгат”-ын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;	“Эрдэнэс Монгол”ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил хийж, ордын нөөцийг баталгаажуулахаар 2023 оны төсөвт 9.182.096.276 төгрөг тусгасан. Одоогоор худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ТХААГ-т хүргүүлсэн байна. Мөн ордын бэлтгэл ажлын хүрээнд “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах”, “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх”, “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажлууд”-ыг ТХААГ-аар зохион байгуулагдаж, тус тендерүүдэд шалгарсан гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна.	70%

117	220	2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2022-04-08 Дугаар 2022_21	I.1.Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөл батлагдмагц хуулийг хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээний талаарх саналаа Монголбанктай хамтран боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;	“Монгол Улсын гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулахаар тусгагдсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд УУХҮ-ийн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх “Хариуцлагын гэрээ”-ий загвар баталсан. Уг батлагдсан загвар гэрээний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий “Шунхлай” ХХК, “Ойн бирж” ХХК, “Синчи газ” ХХК, “Тод петролиум” ХХК, Монсуль ХХК, “Магнайтрейд” ХХК, “Содмонгол групп” ХХК, “Энгүүнжим” ХХК, “М-Ойл групп” ХХК, “Нью энерги стар” ХХК, “Эн Пи петролиум” ХХК, “НИК” ХХК, “Гор газ” ХХК, “Ундарга-Увс” ХХК зэрэг 14 аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100%
118	221	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	ХИҮ.8. . Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайлангийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай	АМГТГ-ын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 199 дүгээр шийдвэрээр MV-016965 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн усан сангийн хил заагтай давхцалтай 5.6 га талбайг арилгасан.	100%

		давхцалтай ашигт малтмалын зөвшөөрөлтэй талбайнуудын давхцлыг арилгах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт;		
222		<p>XIY.14.1. Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;</p>	<p>“Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 4-т “Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно” гэснийг үндэслэн “Монголын алт” (МАК) ХХК-ийн Цагаан суваргын уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд 2023 онд нарийн мэргэжлийн 700 гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг ХНХЯ-нд 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 03/2812 дугаартай албан бичгээр уламжилсан.</p>	100%
223		<p>XIY.14.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт.</p>	<p>УУХҮ-ийн Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар “Дотоодын болон гадаадын зах зээлд борлуулсан, худалдсан, худалдахаар ачуулсан эрдэс бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хэрхэн ногдуулах асуудлаар санал, дүгнэлт” гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн тушаалыг баталсан. Ажлын хэсэг нүүрс, төмрийн хүдэр, жоншны АМНАТ-ийн олон улсын туршлагын талаарх судалгааг Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЕРИ)-ээр хийлгэсэн бол бусад ашигт малтмалын АМНАТ-ын судалгааг Уул уурхайн үндэсний ассоциатай хамтран Олон Улсын PWC судалгааны байгууллагаар хийлгэсэн. Дээрх судалгаануудад үндэслэн гадаадын зах зээлд борлуулсан нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг</p>	100%

				шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 305 дугаар тогтоолоор батлуулсан.	
119	224	2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2022-04-27 Дугаар 2022_25	ХХ.3.1. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав;	Талбайн мэдээлэл “Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэлгүй” гэсэн шалтгаанаар “Капкорп Монголиа”ХХК-ийг газрын тосны хайгуулын Онги V болон газрын тосны ашиглалтын Матад-ХХ талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад орон нутгийн зүгээс талбайд орж ажиллах боломж олгохгүй байна. “Петро Матад” ХХК нь Матад ХХ талбайд 2022 оноос эхлэн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх газрын тосны ашиглалтын төслийн хүрээнд газар ашиглах зөвшөөрөл авах хүсэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 104/21 дугаартай албан бичгээр, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 002/022 дугаартай албан бичгээр, 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 028/022 дугаартай албан бичгээр, 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 078/022 дугаартай албан бичгүүдээр Дорнод аймгийн Матад сумын Засаг даргад хүргүүлсэн боловч Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хүсэлтийг дэмжээгүй тухай хариу албан бичгийг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1/167 дугаар албан бичгээр өгсөн. Иймд дээрх асуудалтай холбоотойгоор тус яамнаас Барилга, хот байгуулалтын яаманд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 01/547 дугаар албан бичиг, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр 01/1990 дугаартай албан бичгээр тус тус хандсан хэдий ч Барилга, хот байгуулалтын яам тус асуудлыг өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна. Хариу ирүүлээгүй болно. Газрын тосны ашиглалтын Матад-ХХ талбайг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар тухайн талбайн хэмжээнд нөлөөлөлд өртөж байгаа айл өрхтэй 2023 оны 03 дугаар 06-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрүүдэд уулзалт хийж, санал авсан ба Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын тосны салбарын талаарх мэдээллийг өгч ажилласан. Хуралдаанд ИТХ-ын дарга Б.Ганбатаар ахлуулсан 15 төлөөлөгч оролцсон. Танилцуулга,	100%

				<p>асуулт хариулт өндөрлөж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар Матад ХХ талбайн ашиглалтын талбайг ашиглах зөвшөөрөл олгох асуудал хэлэлцэгдсэн боловч төлөөлөгчдийн олонхын саналаар уг асуудал дэмжигдээгүй.</p> <p>Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших “Петро Матад” ХХК-ийн газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Матад-ХХ талбайн 213.93 км2 газрыг газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 265 тоот тогтоолыг гаргуулаад байна. Уг тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх асуудлыг хүрээнд АМГТГ-ын даргын тушаалаар Улсын тусгай хэрэгцээний талбайтай давхцал бүхий иргэдийн газрыг чөлөөлөх, газрын нөхөх олговрыг тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан газар дээр 2 удаа очиж айл өрхтэй уулзалт зохион байгуулж газар чөлөөлөх гэрээ байгуулж, нөхөх олговрын хэмжээг тохиролцоод байна.</p> <p>Матад-ХХ талбайн 213.93 км2 газрыг газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авахтай холбоотой гурван талт гэрээ байгуулах асуудалд орон нутгийн зүгээс Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны тогтоолоор аймаг зарим газрыг нөөцөд авсан бөгөөд ашиглалтын талбайтай хэсэгчилсэн давхцалтай байгаа тул гэрээ байгуулах боломжгүй талаар 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өд1/35 тоот албан бичгийг ирүүлээд байна.</p>	
225		XX.5.6. Сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ашигтай ажиллуулах зорилгоор хагас коксын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, холбогдох судалгааг үндэслэн үйлдвэр барих санхүүжилтийг шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион	Багануурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах стратегийн ач холбогдол бүхий “Нүүрс, химийн технологи-эрчим хүчний цогцолбор” төслийг хэрэгжүүлэгч “Тавантолгой түлш” ХХК болон төсөл боловсруулагч тал болох “Евро азиа майнз” ХХК-иас 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 25/23 дугаар, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03/694 дугаар албан хүсэлт тус тус ирүүлснийг үндэслэн УУХҮ-ийн Сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/229 дүгээр тушаалаар төслийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий “Шинжээчдийн хэсэг” байгуулагдан 2023 оны 09 дүгээр сарын 27,	100%	

			байгуулахыг “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нарт.	2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрүүдэд тус тус дүгнэлт, зөвлөмж гаргасан.	
120	226	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр	ХХ.3.1.2. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцлын асуудлыг судалж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;	Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/2238 дугаар албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч “Тахилт хайрхан транс” ХХК нь “...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй давхацсан эсэх, давхацсан хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал”-ыг судалж байгаа талаар дурдсан болно. Мөн тус замын трасттай давцалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тус яаманд ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн удирдлагатай 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр уулзалт хийж уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон.	70%
	227	28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн	1.Тусгай зөвшөөрлийн цахим системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулан олгож байгаатай холбоотойгоор цахим гарын үсгийг нэвтрүүлэн ашиглаж байна. 2.Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага болох “Tridum Key” ХХК-тай хамтран ажиллаж баримт бичгийн баталгаажуулах эрх бүхий албан хаагчдад олгож, төрийн байгууллага хооронд болон албан бичиг хөтлөлтийн Able-системд тоон гарын үсгийг ашиглаж байна.	100%

			болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.		
121	228	2022 оны 5 дугаар сарын 18-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2022-05-18 Дугаар 2022_29	ХИҮ.4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах танилцуулгыг бэлтгэсэн. Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх хэлэлцээр хийх үүргийг Шадар Сайдад өгсөн. Үүний дагуу “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх асуудлаар Шадар сайдаас 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн ЗГ-2/679 дугаартай “Хэлэлцээнд урих тухай” албан бичгийг тус компанид хүргүүлээд байна. Ажлын хэсгийн явцыг 2023 оны 05 сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 96 дугаар захирамжаар “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан. “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн байгуулах ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулахаар тогтсон. Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд өөр өөрсдийн хариуцсан чиг үүргийн мэдээллийг бэлтгэж нэгтгэсэн. Тухайн асуудлаар ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдрүүдэд БНХАУ-д ажиллаж “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дай Хоулян болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах ажлын хэсэг томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Хятадын талын ажлын хэсгийг “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн дэд захирал Жан Даовэй ахлан ажиллахаар болсон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх Монголын талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий	70%

				сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан.	
122	229	2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2022-05-25 Дугаар 2022_30	I.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан) нарт даалгав.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах асуудлыг судалж байна. “Эрдэнэс Тавантолгой”ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 385 дугаар тогтоолын 2, 3.1-т заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтцээс 14 нэгж /алба/-ийг татан буулгаж, нийт 53 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж орон тоог бууруулсан байна.	70%
123	230	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, агентлагууд болон харьяа геологийн судалгаа шинжилгээний төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг, нэмэлт тайланг нэгтгэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%

			тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.		
124	231	2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 35 дугаар тэмдэглэл 2022-06-29 Дугаар 2022_35	ХХҮИ.8. . Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” жишиг төслийн бүтээн байгуулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн хугацаанд дуусгахад төслийн нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн судалж шийдвэрлэх, жишиг нөхөн сэргээлтийн бүтээн байгуулалтын ажилд уул уурхайн салбарын төрийн өмчит томоохон компаниудын оролцоог хууль тогтоомжид нийцүүлэн хангуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;	Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийг 2024 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байна	70%
125	232	2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл	ХХ.6.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн явц болон газрын тос дамжуулах хоолойн төслийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга	“Норинко” компанитай байгуулсан гэрээний барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тос дамжуулах хоолойн трассын дагуу байр зүйн зураглал, инженер геодези, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж нарийвчилсан солбицлын цэгүүдийг тодорхойлон хоолойн трассын тэнхлэгээс 2 тал руу тус бүр 100 метр (нийт 200 м) зурвас	100%

		2022-07-05 Дугаар 2022_36	хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Газрын тос дамжуулах хоолойн тос дамжуулах трассын дагуу инженер геологийн судалгаа хийх, дамжуулах хоолойн нарийвчилсан зураг, төсөл боловсруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;	газарт аливаа газрын давхцлыг арилгасан. Хоолой дайран гарах Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймагт дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан улсын тусгай хэрэгцээнд авахыг эдгээр аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр тус тус гарсан. Хоолойн трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай БХБЯ-аас ирүүлсэн Засгийн газрын “Нууц” тогтоолын төсөлд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/..., 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/... дугаартай албан бичгээр тус тус хариуг хүргүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар инженерчлэл-70.0%, худалдан авалт-35.5%, барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, техникийн зураг төслийн ажил - 90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй байна.	
	233		ХХ.6.2. Газрын тос боловсруулах үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг сургаж бэлтгэхэд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судалж танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;	ШУТИС, МУИС-иудтай хамтран сургалтын төлөвлөгөөг боловсруулж ШУТИС-ийн “Хөтөлбөрийн дэд хороо”, “Хөтөлбөрийн ерөнхий хороо”-гоор хэлэлцүүлэн Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлд оруулсан. Мөн “Газрын тосны инженерчлэл” бакалаврын хөтөлбөрт БШУ-ны сайдын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаалаар 072407 дугаар индекс батлуулсан. ШУТИС-ийн 2022-2023 оны намар, хаврын улиралд тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг газрын тосны “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний сургалтын сангийн хөрөнгөөс шийдвэрлэсэн.	100%
126	234	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	ХҮИИ.3.1.5. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын бүтээн байгуулалтын талбайтай давхцал бүхий газрын асуудлыг 2022 оны 8 дугаар сард багтаан шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт;	Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/2238 дугаартай албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч “Тахилт хайрхан транс” ХХК нь “...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй	70%

				давхацсан эсэх, давхацсан хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал"-ыг судалж байгаа талаар дурдсан болно. Мөн тус замын трасттай давцалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тус яаманд ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн удирдлагатай 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр уулзалт хийж уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон.	
	235		ХҮИИ.3.2.7. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн бүтцийг нарийвчлан тогтоож зохиомол хомсдол, далимдуулсан үнийн хөөрөгдлөөс сэргийлэх, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэр, логистикийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах ажлыг харьяа салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, инфляцын шалтгаан, нөхцөлийг судалж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох салбарын төлөөллийг оролцуулан яаралтай байгуулж ажиллуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Засгийн газрын холбогдох гишүүдэд;	Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн үнийг тогтворжуулах зорилгоор Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай" 160 дугаар тогтоолыг батлуулж, Аи-92 автобензинийн урьдчилгаа төлбөр болох 100.8 сая ам.долларын үнийн дүнгийн 85 хүртэлх хувийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зээл олгуулах ажлыг Сангийн яам болон Монголбанк, арилжааны банкуудтай хамтран шийдвэрлэсэн. Аж ахуйн нэгжүүд 2022 оны 10 дугаар сард уг баталгаагаар олгогдсон зээлийг бүрэн төлж дуусгасан.	100%
127	236	2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46	Х.10. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийг тооцож байгаа асуудлыг дахин нягтлан үзэх, уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдээс тавьж буй асуудлыг судлан үзэж, холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 100 дугаар тушаалаар Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар судлан үзэж холбогдох хууль, тогтоомжийг боловсронгуй болгох эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн дэд сайдаар ахлуулан байгуулсан. Тус ажлын хэсэг санал, дүгнэлтээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүргүүлсэн болно.	100%

237		<p>Х.12. Гадаадын ажиллагчдад тавих дотоод хяналтыг сайжруулах, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний квотыг өөрчлөх санал боловсруулж танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т;</p>	<p>“Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасны дагуу “Гадаадаас авах ажиллах хүчний 2023 оны хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд салбарын квотыг дахин нэмэгдүүлж, “Уул уурхай, олборлолт” хэсгийн 6000 гэснийг 8000 хүргэх саналыг ХНХЯ-нд 2022 оны 10 сарын 10-ны өдрийн 01/2673 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>	100%
238		<p>Х.4.1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3-т заасан Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг эрчимжүүлж, ажлын явцыг 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК (Н.Цэрэнбат)-д;</p>	<p>Рио Тинтогийн Зэсийн группийн Өсөлт, хөгжил хариуцсан захирал С.Мөнхсүхээс 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдөр ХЗДХЯ-ны сайд, Засгийн газрын ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт “Оюутолгой төсөл”-ийн санхүүжилтийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийн тухай албан бичиг хүргүүлж, тус албан бичигт дараах агуулгыг дурдаж, холбогдох албан бичиг, дүгнэлтийг хавсаргасан. Үүнд:</p> <p>Хөрөнгө оруулагчдын хүсэлтээр “Оюутолгой”ХХК-д зарцуулсан төслийн санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалтын талаар “Эрнст энд Янг” фирм хөндлөнгийн аудит хийж, иж бүрэн тайлан болон дүгнэлт гаргасан.</p> <p>Хөндлөнгийн аудитын дүгнэлт нь төслийн санхүүжилтийн зээлдүүлэгчдээс авсан нийт 4.274.320.585.41 ам.доллартой тэнцэх төлбөрийг Туркойз Хилл Ресурсэс компаниас Хувь нийлүүлэгчдийн зээл болон өөрийн хөрөнгө хэлбэрээр “Оюутолгой”ХХК-д буцаан оруулсан эсэхийг тухайлан авч үзсэн.</p> <p>Хөндлөнгийн аудитор дараах дүгнэлтийг гаргасан. “Төслийн санхүүжилтийн зээлдүүлэгчдээс “Туркойз Хилл Ресурсэс” /ТХР/ компанид “Оюутолгой”ХХК-иар дамжуулан 4.274,320.585.41 ам.доллартой тэнцэх хэмжээний санхүүжилт олгосон болохыг нотолж байгаа бөгөөд ТХР нь эргүүлээд хувьцаа эзэмшигчдэд хувьцаа эзэмшигчдийн зээл болон өөрийн хөрөнгө хэлбэрээр 4.274.320.585.41 ам.долларын санхүүжилт олгосон гэдэгт баталгаа өгч байна. Үүгээр төслийн санхүүжилтийн бүх хөрөнгийг эцсийн дүндээ “Оюутолгой”ХХК-ийн бүтээн байгуулалтыг дэмжихэд зарцуулсан бөгөөд ямар нэг өөр зориулалтаар ашиглаагүй болох нь батлагдаж байна. Өмнө нь бидний зүгээс мэдэгдэж байсанчлан, “Оюутолгой”ХХК-ийн төлөх ёстой хувьцаа</p>	100%

				<p>эзэмшигчийн өндөр хүүтэй зээлийг төлөхийн тулд төслийн санхүүжилтийн хөрөнгийг ТХР-ын талаас эхэндээ бүрэн хэмжээгээр татжээ. Дараа нь “Оюутолгой”ХХК-ийн зардлыг бууруулж, шаардлагатай хэмжээгээр “Оюутолгой” ХХК-д дахин хөрөнгө оруулсан байна. Энэхүү тайлбар нь бүх сонирхогч талуудын сэтгэлд нийцэж уг асуудлыг тодорхой болгосон гэдэгт итгэлтэй байна.” гэсэн.</p> <p>“Энэхүү аудитыг хийлгүүлж, хавсаргасан албан бичгүүдийг хүргүүлснээр Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилттэй холбоотой хөндлөнгийн аудит хийх тухай 103 дугаар тогтоолын 1(3) дахь хэсэгт заасан шаардлагыг биелүүлж дууслаа гэж бидний зүгээс үзэж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам энэхүү дүгнэлттэй санал нийлж байгаа гэж итгэж байна.” гэсэн.</p> <p>Иймд УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1.3-т Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн зүгээс дээр дурдсан хөндлөнгийн аудит “Эрнст энд Янг”-ийн тайлантай танилцаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах болон;</p> <p>Хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт (ICG)-тэй холбоотойгоор Оюутолгой ХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 253 дугаар тогтоолоор Монголын талын санаачилгаар байгуулагдсан "Тусгай хороо" нь Далд уурхайн бүтээн байгуулалтын календарчилсан төлөвлөлт, ЗАРДЛЫН ТООЦООНД ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ХИЙЛГЭХ асуудлаар Оюутолгой төслийн Монголын талын хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.</p>	
128	239	2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019	Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт мөрдөгдөж байгаа стандартын нэгтгэж, Стандартчилал хэмжил зүйн газрын холбогдох албан тушаалтнуудтай санал солилцох уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.	70%

			оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд;		
	240		<p>XII.3. .1. Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн хүрээнд:</p> <p>1.1. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;</p>	<p>“Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран баталсан. Түүний дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн төсөл /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулан яамдаас холбогдох саналыг авсан. Ирүүлсэн саналыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгах шаардлагатай зохицуулалтыг тусгасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээс 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/2849 дугаартай албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тухай зөвшөөрөл хүссэн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, бүрдүүлбэрийг ханган ажилласан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.</p>	70%
129	241	2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49	<p>III.1. Агаарын хөлгийн шатахууны үнийг бууруулах, шатахууны улсын нөөц бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав.</p>	<p>Тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах болон агаарын хөлгийн шатахууны үнийг бууруулах, нөөцийг тогтворжуулах зорилтын хүрээнд “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-ийн 7.2 заалтад нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулсан. “Газрын тосны</p>	100%

				<p>бүтээгдэхүүний тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно” гэсэн заалтыг “дамжуулан” гэсний дараа “агаарын хөлгийн түлшнээс бусад” гэж нэмсүгэй гэж өөрчлөн УИХ-ын нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хуулийн төсөл батлагдсанаар “Эрчис ойл” компани ОХУ-ын төрийн өмчит “Роснефть-Аэро” компанитай 60:40 харьцаатай хамтарсан компанитай байгуулах замаар Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын түлшний хангамжийг олон улсын стандартад нийцсэн, хямд үнэтэй бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг хангах боломж бүрдсэн.</p>	
	242		<p>XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.</p>	<p>Хайгуулын тусгай зөвшөөрлийн цахим системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулан олгож байгаатай холбоотойгоор цахим гарын үсгийг нэвтрүүлэн ашиглаж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас тус яаманд хамтран ажиллах тухай 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02/281 дугаартай албан бичгийн хүрээнд цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж буй хуулийн этгээдэд зориулсан И-Бизнес нэгдсэн платформ төсөлд хамрагдан Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өөрийн чиг үүрэгт хамаарах мэдээллийг төрийн солилцооны үндсэн систем (ХУР)-д, И-Монгол академи УТҮГ-ийн төсөлд хүргүүлсэн.</p>	100%
130	243	<p>2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2022-10-26 Дугаар 2022_52</p>	<p>X.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1.</p>	<p>Төслийн Анхдагч процессын болон дагалдах байгууламж /EPC-02/, Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-03/-ын ажлын барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон БНЭУ-ын “Мега Инженеринг Инфраструкчер Лимитед” компанитай MR-03/2022, MR-04/2022 дугаартай гэрээнүүдийг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тус тус байгуулан ажиллаж байна.</p>	100%

			<p>Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Анхдагч процесс, Дагалдах байгууламжууд (EPC-2)-ын болон Үйлдвэрийн цахилгаан станцын ажил (EPC-3)-ын сонгон шалгаруулалтад шаардлага хангасан тендерийн санал ирүүлсэн оролцогчтой холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах арга хэмжээ авахыг захиалагч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэгт;</p>		
244			<p>Х.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад шаардагдах газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тосны нөөц шинээр тогтоох боломжтой талбайн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт;</p>	<p>Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан.Цаашид газрын тосны хайгуулын талбайнуудад нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 зэрэг талбайн мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулсан. Газрын тосны хайгуулын Номгон IX, Төхөм X хойд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Дарьганга XXIV талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах УУХҮ-ийн Сайдын 2022 оны А/294 дүгээр тушаалаар тус талбайнуудад 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Номгон IX, Цагаан Элс XIII, Дарьганга XXIV талбайн багц материалыг 2 аж ахуйн нэгж худалдаж авсан. Номгон IX, Дарьганга XXIV талбайнуудад захиалга орж ирсэн байна. АМГТГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/17 дугаар тушаалын дагуу Номгон IX талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах захиалга авах эцсийн хугацаа 2023 оны 02</p>	100%

				дугаар сарын 20-ны өдрийн 17.30 цагт тасалбар болж, ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байна. АМГТГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/27 дугаар тушаалын дагуу Дарьганга XXIV талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах захиалга авах эцсийн хугацаа 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 17,30 цагт тасалбар болж, гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсэг байгуулагдсан. Мөн УУХҮ-ийн Сайдын 2023 оны А/43 дугаар тушаалаар Хонгор VIII, Баянхошуу XXII, Чойр XXV, Цайдам XXVI, Хэрлэнтохой XXVIII талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.	
131	245		Х.8.11.“Монголросцветмет” ТӨҮГ-ын туршилтын журмаар олборлосон цайрын хүдрийн төрөл, тоо, хэмжээг бүртгэж экспортод гаргахад шаардлагатай зөвшөөрлийг холбогдох журмын дагуу олгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т;	“Монголросцветмет” ТӨҮГ-ын туршилтын журмаар олборлосон цайрын хүдрийг экспортод гаргаж эхэлсэн бөгөөд тус компани оны эхнээс өнөөг хүртэлх хугацаанд 8.1 тонн цайр экспортод гаргасан байна.	100%
	246	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.8.14.Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дизель түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах талаар арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт;	Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дизель түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах ажлыг зохион байгуулах хүрээнд ОХУ-ын гол нийлүүлэгч “Роснефть” НХН-ийн Худалдаа, логистик эрхэлсэн Дэд ерөнхийлөгч Андрей.В Богатенковтой холбогдож, дизель түлшний нийлүүлэлт, ачилтын хэмжээг нэмэх талаар хүсэлтээ илэрхийлж санал солилцсоны дүнд 17 мянган тонн дизель түлшийг 2022 оны 11 дүгээр сарын нийт захиалга дээр нэмж, нийт 62,000 тонн түлш нийлүүлэхээр болсон. Мөн БНХАУ-ын Хөх хотын боловсруулах үйлдвэрээс 2022 оны 12 дугаар сард нийт 20,000 тонн дизель түлш худалдан авахаар тохиролцож, хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг ханган ажилласан. 2022 онд манай улсын хэмжээнд нийт 988 мян.тонн дизель түлш импортлон хэрэглэсэн байна.	100%
132	247	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл	XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа		

		2022-12-07 Дугаар 2022_58	болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд;		
	248		XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж буй docx.gov.mn системийн сайжруулалтын ажилд тус яамны бичиг хэрэг хөтлөлтийн УУХҮЯ-ны ашиглаж буй албан бичиг солилцооны Able системийг Албан бичиг солилцооны дундын систем болох DocX-тэй холбож албан хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.	100%
133	249	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2022-12-21 Дугаар 2022_62	ХҮI.1.“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа тодорхой үндэслэл, судалгаатай боловсруулж Эдийн засаг,	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх танилцуулга, мэдээ мэдээллийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр илгээн ажиллаж байна. Мөн УУХҮЯ-нд харьяалагдаж буй 13 төсөл, хөтөлбөрүүдийг ач холбогдолоор нь эрэмбэлэн Эдийн засаг, хөгжлийн яамны удирдлагуудтай зөвшилцөж Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр төсөл буюу “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлэх гангийн үйлдвэрийг хасаж, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн далд уурхайн төслийн хэрэгжих хугацааг сунгахаар тогтов.	70%

			хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав.		
134	250	2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5	VI.2. Уламжлалт бус газрын тосны хайгуулын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, шатдаг занараас газрын тос гаргах асуудлыг судалж танилцуулах, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хууль тогтоомжийн хүрээнд дэмжиж ажиллах, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд октант өндөртэй бензин рүү үе шаттайгаар шилжих асуудлыг судалж хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгав.	Уламжлалт бус газрын тосны хайгуулын 6 талбайд 4 “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2018 оны 265 дугаар тогтоолоор уламжлалт бус газрын тосны хайгуулын Номгон IX талбайд 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр “Жи Өү Эйч”ХХК-тай “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан бөгөөд хайгуулын ажлын доод хэмжээ /10 жилд/ 30 сая ам.доллар. 2023 оны жилийн ажлын уулзалт хийсэн бөгөөд 2.754.974.10 ам.доллар зарцуулахаар төлөвлөж, хөтөлбөр төсвөө батлуулаад байна. Засгийн газрын 2020 оны 57 дугаар тогтоолоор уламжлалт бус газрын тосны хайгуулын Номгон Богд IV, Онги V, Т1 талбайд 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “Петровис ресурс”ХХК-тай “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан бөгөөд хайгуулын ажлын доод хэмжээ /10 жилд/ талбай тус бүрд 10 сая ам.доллар. 2023 оны жилийн ажлын уулзалт хийсэн бөгөөд Т1 талбайд 780.156 ам.доллар зарцуулахаар төлөвлөж, хөтөлбөр төсвөө батлуулаад байна. Засгийн газрын 2020 оны 143 дугаар тогтоолоор уламжлалт бус газрын тосны хайгуулын Тавантолгой ХХХIII талбайд 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Метан газ ресурс”ХХК-тай “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан бөгөөд хайгуулын ажлын доод хэмжээ /10 жилд/ 25 сая ам.доллар. 2023 оны жилийн ажлын уулзалт хийсэн бөгөөд 14.969.201.3 ам.доллар зарцуулахаар төлөвлөж, хөтөлбөр төсвөө батлуулаад байна. Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс ХХХV талбайд 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдөр “Тэлмэн ресурс”ХХК-тай “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан бөгөөд хайгуулын ажлын доод хэмжээ /10 жилд/ 8.9 сая ам.доллар. 2023 оны жилийн ажлын уулзалт хийсэн бөгөөд 4.929.861 ам.доллар зарцуулахаар төлөвлөж, хөтөлбөр төсвөө батлуулаад байна. 2023 оны байдлаар нийт 2.187.065 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлосноос бүх төрлийн шатахуун 1.912.740 тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 198.365 тонн буюу нийт шатахууны 11 хувийг эзэлж байна. К5 ангиллын дизель түлш, автобензиний хэрэглээ шаардлага нэмэгдсэнтэй холбогдуулан К5/Евро-5/ шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг ОХУ, БНХАУ-ын гол нийлүүлэгч	70%

			компаниудтай К5 ангиллын шатахууныг тогтвортой нийлүүлэх, хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, үнийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр яриа, хэлэлцээ хийн ажиллаж байна.2023 оны 12 сард БНХАУ-аас 31.500 К5 ангиллын шатахууныг импортлосон. Энэ хэмжээг нэмэгдүүлэхээр БНХАУ-ын талтай Монголын импортлогч компаниуд яриа хэлцэл хийж байна.	
251		IX.1. Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй танилцаад 100 жилийн ойн арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр, уул уурхайн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, салбарыг сурталчлах, тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг явуулах “Монголын уул уурхайн 7 хоног” олон улсын чуулга уулзалтыг 2023 оны 09 дүгээр сард тус тус зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгав.	Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хурал, концертыг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 1200 орчим иргэд оролцсон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци хамтран Монгол улсын эрдэс баялгийн салбарыг гадаадын хөрөнгө оруулагч нарт сурталчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Уул уурхайн долоо хоног - 2023” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрийн хооронд 5 өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Австрали, Австри, Канад, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, ИБУИНХУ (Их британи), Герман, Энэтхэг, Япон, Финлянд, ӨАБНУ, Арабын нэгдсэн Эмират улс, Франц, Испани, Пакистан зэрэг 20 орчим улсын 300 гаруй зочин төлөөлөгч, хөрөнгө оруулагчид хүрэлцэн ирж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл болох 5000 орчим (давхардсан тоогоор) зочид төлөөлөгч оролцсон, олон талын оролцоог хангасан арга хэмжээ болсон.	100%
252		X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга	УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн №52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/81 дүгээр тушаалаар Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

			хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.		
	253		Х.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг газар тус бүрээр гарган, хэрэгжих боломжгүй төсөл, арга хэмжээг хасуулах, эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн №52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсантай холбогдуулан УУХҮ-ийн Сайдын 2021 оны А/81 дүгээр тушаалаар Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%
	254		Х.3.Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхэлсэн асуудлын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/81 дүгээр тушаалаар Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг баталсантай холбогдуулан салбарын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг жил тус бүр УУХҮЯ-ны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%
135	255	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	ХИҮ.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон	Эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг боловсруулж нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал www.opendata.gov.mn цахим хуудсанд сар, хагас жил, жилийн эцсийн байдлаар боловсруулан байршуулж байна. Мөн Засгийн газрын дэргэдэх e-mongolia академийн хөгжүүлэлт хийж буй sudalгаа.gov.mn цахим хуудсанд УУХҮЯ-ны захиалгаар улсын төсвөөр болон гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг нээлттэй байршуулсан.	100%

			төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;		
136	256	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	XXV.3. "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын 11 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Батлан хамгаалахын дэд сайд, Ажлын хэсгийн дарга Б.Баярмагнайд, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгав.	"Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын 11 дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, орон нутаг, мэргэжлийн холбоод зэрэгтэй хамтран бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд орж, салбар хоорондын уялдааг хангах чиглэлээр хамтран ажиллаж байна.	70%
	257		III.5. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд авлигыг таслан зогсоох, хүнд суртлыг арилгах чиглэлээр хариуцсан салбар бүрдээ тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Яамны 2023 оны Авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний болон бусад ажлын төлөвлөгөөг АТГ-тай хамтран гаргасан. Уг ажлын хүрээнд 14 арга хэмжээ бүхий ажлыг төлөвлөн хэрэгжилтийг khutulbur.iacc.mn тайлангийн вэб хуудсанд байршуулсан болно.	100%
137	258	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	III.6. Засгийн газрын бодлого, шийдвэр нийгмийн хүлээлттэй хэрхэн уялдаж байгаа талаар судалгаа хийж, гарсан дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэл бүхий тайлбар, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	"Үндэсний баялгийн сангийн тухай хууль"-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу "Үндэсний баялгийн сангийн тухай хууль"-ийн төсөл болон "Хөгжлийн сангийн тухай хууль"-ийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, "Хууль тогтоомжийн тухай хууль"-д заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. "Хууль	70%

				<p>тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төслийг ЗГХЭГ- аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар “Үндэсний баялгийн сан”-г байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлэн хүргүүлсэн.</p>	
138	259	<p>2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11</p>	<p>XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.</p>	<p>“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан www.1212.mn салбарын жендэрийн статистик мэдээг цахимаар байршуулсан. Мөн “Жендэрийн үндэсний хороо”-ны ээлжит хуралдаанаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2023 оны үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг хэлэлцэхтэй холбогдуулан тайлан мэдээллийг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/62 дугаартай албан бичгээр “Жендэрийн үндэсний хороо”-нд хүргүүлсэн.</p>	100%
139	260	<p>2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13</p>	<p>IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар</p>	<p>Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршил, суурьшлын бүсэд ойрхон газарт, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт үйл ажиллагаа явуулах, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх чиглэл баримталж байна. Мөн ашигт малтмалын орд ашиглах урьдчилсан үнэлгээ, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг тухайн аймаг</p>	100%

		<p>өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөлттэй нягт уялдаатай боловсруулах чиглэлийг ашигт малтмалын /тэсэлгээний болон хүнд үйлдвэрийн/ тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж болгож, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.</p>	
261		<p>IX.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа дараах төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын дор дурдсан гишүүдэд даалгав: Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д;</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /EPC-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /EPC-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “МГТБУ” ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, Худалдан авалт-35.5%, Барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил - 90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт</p>	100%

				19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	
140	262	2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14	XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;	БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт 2023 онд магистрийн сургалтад хамрагдаж төгссөн 1 албан хаагчийг өмнө нь эрхэлж байсан албан тушаалд нь томилсон.	100%
	263		XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад	Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй JDS хөтөлбөрийн магистр, докторын сургалтын талаарх мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан.	30%

			улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;		
141	264	2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2023-04-05 Дугаар 2023_15	XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав: Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр системээр төлөвлөн УУХУ-ийн Сайдын 2024 оны Төсвийн хөрөнгө оруулалтын саналыг боловсруулан 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1974 дугаатай албан бичгээр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. / УУХУ-ийн Сайдын 2023 оны багцад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв батлагдаагүй болно/	100%
142	265	2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл 2023-04-12 Дугаар 2023_16	XIX.1. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах цэгийг нэмэгдүүлэх, төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаалах цэг гаргах, аймаг, орон нутгаас мах ачсан тээврийн хэрэгслийг нийслэл хот руу	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Монголын уул уурхайн үндэсний ассоциаци болон аймаг, орон нутгийн удирдлагуудтай хамтран "Хариуцлагатай уул уурхай" сэдэвт чуулга уулзалтыг бүсчилсэн байдлаар /баруун, зүүн, төвийн бүсээр/ зохион байгуулж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, Монгол Улсад ил тод,	100%

			<p>саадгүй нэвтрүүлэх, нөөцийн махны чанарын асуудлаар мэдээлэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийх уулзалтын үеэр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулж, хэрэгжилтийн явцын талаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. Төрийн ордны хашааны засварын асуудлаар иргэд, олон нийтээс ирүүлж буй шүүмжлэлийг харгалзан үзэх, засварын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.</p>	<p>хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн ач холбогдол, олон улсын сайн туршлагын талаар олон нийтэд нээлттэй хэлэлцүүлсэн.</p>	
143	266	<p>2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл</p>	<p>XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон</p>	<p>Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хүний эрх, жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП2) дэмжлэг үзүүлэн “Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай хамтран эрдэс баялгийн</p>	100%

		<p>2023-04-19 Дугаар 2023_17</p>	<p>бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов</p>	<p>салбарын ажилтнуудад зориулсан цахим сургалтын 7 модулыг боловсруулсан. Нэгдсэн үндэстний байгууллага, Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Бизнес ба хүний эрх”, “Хүний эрхийн магадлан шинжилгээ” хийх чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулж байгууллага аж ахуйн нэгжүүдээс 30 гаруй хүн хамрагдсанаас Хараагүйчүүдийн үндэсний төвөөс харааны бэрхшээлтэй 3 иргэн оролцсон. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хүний эрх, жендэрийн талаар баримтлах бодлого 2019-2026 батлагдсан бөгөөд, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.7-д Салбарын төр, хувийн хэвшлийн байгууллага, оролцогч талуудын удирдах албан тушаалтан, албан хаагч, ажилтанд зориулсан хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй сургалтын модуль боловсруулж “Үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх” гэсэн арга хэмжээний хүрээнд Эрдэс баялгийн салбарын жендэрийн сургалтын гарын авлагыг боловсруулан сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>2022 оны 9 дүгээр сарын байдлаар Монгол Улсын нийт газар нутгийн 75.8% нь холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон болон хязгаарласан талбай байна.</p> <p>“Ашигт малтмалын тухай хуул”-ийн 41 дүгээр зүйлийн 41.1-дэх хэсэгт “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан. Үүний дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь малчдын нүүлгэн шилжүүлэх зардлыг хариуцан ажиллаж байна</p> <p>Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хүний эрх, жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП2) дэмжлэг үзүүлэн “Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай хамтран эрдэс баялгийн</p>	
--	--	--------------------------------------	--	---	--

				<p>салбарын ажилтнуудад зориулсан цахим сургалтын 7 модулыг боловсруулсан.</p> <p>Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүдийн хүсэлтээр 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Уул уурхай хүнд үйлдвэрийн Дэд сайд О.Цэндсүрэн болон яамны газар хэлсийн дарга, хариуцсан албан тушаалтнууд оролцож Уул уурхайн салбарын хүний эрхийн асуудлаар санал солилцох уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтаар Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар ярилцлаа.</p>	
144	267	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19	<p>II.2. Нүүрснээс бусад төрлийн ашигт малтмалын нээлттэй цахим арилжааг үе шаттай эхлүүлэх, нээлттэй цахимаар арилжсан ашигт малтмалыг хилийн бүх боомтоор экспортлох нарийвчилсан төлөвлөгөөг 2023 оны 2 дугаар улиралд багтаан гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нарт даалгав.</p>	<p>“Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Уг тогтоолд заасны дагуу 2023 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан ил тод, дуудлага худалдаагаар 604.8 мян.тн төмрийн баяжмалыг тус тус арилжаалсан байна.</p>	100%
	268		<p>ХҮIII.2.3. Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системд бүртгэгдсэн ашигт малтмалтай холбоотой бүх төрлийн гэрээний мэдээллийн үнэн зөв байдлыг тулган нягтлах, төрийн байгууллагын бусад мэдээллийн сантай уялдуулах арга хэмжээ авахыг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т даалгав;</p>	<p>Геологи, уул уурхайн мэдээллийн системээр дамжуулан сар бүр Гаалийн ерөнхий газраас уул уурхайн бүтээгдэхүүний экспортын мэдээг хүлээн авч ажиллаж байна.</p>	30%

	269		ХҮИИ.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд өөр өөрсдийн хариуцсан чиг үүргийн мэдээллийг бэлтгэж нэгтгэсэн. Тухайн асуудлаар ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдрүүдэд БНХАУ-д ажиллаж “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дай Хоулян болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж дээр “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах ажлын хэсэг томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Хятадын талын ажлын хэсгийг “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн дэд захирал Жан Даовэй ахлан ажиллахаар болсон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г шинэчлэх Монголын талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан.	100%
	270		ХҮИИ.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төслийг Сангийн сайдтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	УУХҮ-ийн Сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй заалт тул хэрэгжилт гарах боломжгүй.	Х.Б
145	271	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар 2023 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувь, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 71 хувь, экспортын орлогын 92 хувь, төсвийн орлогын 34 хувийг дангаараа бүрдүүлж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна. Зөвхөн	100%

		2023-05-17 Дугаар 2023_17	хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	2023 онд 11.7 тн алт, 69.6 сая тн нүүрс, 4.7 сая баррель газрын тос, 1.524.8 мян.тн зэсийн баяжмал, 6.4 мян.тн молибдений баяжмал, 5.712.9 мян.тн төмрийн хүдэр, 1.087.8 мян.тн жоншны хүдэр, баяжмал, 150.5 мян.тн цайрын баяжмал, 12.5 мян.тн катодын зэс үйлдвэрлэж, 8.898.1 сая ам.долларын нүүрс, 2.625.4 сая ам.долларын зэсийн баяжмал, 738.0 сая ам.долларын алт, 364.7 сая ам.долларын газрын тос, 444.8 сая ам.долларын төмрийн хүдэр, 272.4 сая ам.долларын жоншны хүдэр, баяжмал, 220.0 сая ам.долларын цайрын баяжмал, 102.5 сая ам.долларын катодын зэс экспортлоод байна. Улс орны хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлж байна.	
	272		XVIII.3.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд;	Ажлын хэсэг хуралдаж гишүүдэд хариуцсан асуудлуудаар санал боловсруулж нэгтгэх үүрэг даалгаварыг өгч ажилласан. Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Бээжин хотод Хятадын газрын тосны корпорацийн удирдлагуудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар ажлын уулзалт хийсэн ба Хятадын талаас мөн ажлын хэсэг гаргаж хамтран ажиллах талаар санал солилцсон. УУХҮ-ийн Сайдын 2023 оны А/199 дугаартай тушаалаар дээрх ажлын хэсгийг мэдээллээр хангах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Дэд ажлын хэсэг “Петрочайна Дачин Тамсаг”ХХК-тай эхний уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хийсэн ба “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-нд өөрчлөлт орсноор гарах санхүүгийн тооцооллыг хийхээр харилцан тохиролцоод байна. Мөн “Доншен газрын тос Монгол”ХХК-тай “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” шинэчлэх талаар ажлын хэсэг байгуулж хамтран ажиллах талаар албан бичгийг тус компанид хүргүүлээд байна.	70%
146	273	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан УУХҮЯ-ны ТНБД-ын 10 дугаар сарын 24-ний “Нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулах тухай” 4-р албан даалгаврыг гаргасан. Албан даалгаварын хүрээнд нээлттэй мэдээллийн тухай хуулийн 8.2.1-8.6.22-г заасан мэдээллийн мэдээлэл хариуцагчийг тодорхойлж, хэрэгжилтийг	100%

			<p>холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов:</p> <p>1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах;</p> <p>2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах;</p> <p>3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.</p>	<p>ханган ажиллахыг харъяа байгууллагад даалган албажуулж хүргүүлсэн.</p> <p>2. Нийтийн мэдээллийн ил,тод байдлын тухай хуулийн 8.2.1-8.6.22-т заасан мэдээллийг УУХҮЯ-ны албан ёсны цахим хуудаст байршуулан ЦХХХЯ-ны шил ажиллагаагаар shilen.gov.mn сайтад тус яам нь 98.83%-иар үнэлэгдсэн.</p>	
147	274	<p>2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2023-06-07 Дугаар 2023_24</p>	<p>XXV.12.1. Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд яам, агентлаг, харьяа байгууллагын байруудын нийтлэг үйлчилгээ (байр ашиглалт, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ), сургалтууд (давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох гэх мэт), салбарын мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа (мэргэшсэн инженер, зөвлөх инженер гэх мэт), мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх болон бусад тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүрэг (аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой), харьяа амралт, сувилал, сургалтын төвийн үйл ажиллагааг тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр сонгон шалгаруулах зарчмаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2023 онд багтаан хувийн хэвшил, төрийн бус</p>	<p>Засгийн газрын "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>УУХҮ-ийн Сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан "Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам"-ыг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/72 дугаар тушаалаар Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг "Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл" төрийн бус байгууллагад, Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг "Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл" төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p>	100%

		<p>байгууллагуудад шилжүүлэх, эсхүл гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451 мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p> <p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p> <p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/; Геозкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/; Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/;</p>
--	--	---	--

				<p>Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38; Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/.</p>	
275			<p>XXV.12.2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 151 дүгээр захирамжаар байгуулагдсан “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл боловсруулах Ажлын хэсгээс баталсан “2023 онд яам, агентлаг, харьяа байгууллагын эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p>	<p>Засгийн газрын "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>УУХҮ-ийн Сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/72 дугаар тушаалаар Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” төрийн бус байгууллагад, Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451 мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p>	100%

			<p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p> <p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/; Геозкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/; Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/; Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38/; Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/.</p> <p>/УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан "Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох" журмаар мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл, ШУТИС-ийн механик, тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулиар гүйцэтгүүлж байна/</p>	
276		XXV.11.3. Тавантолгойн бүлэг ордын ашиглалт, эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, компанийн үйл ажиллагааны урт хугацааны төлөвлөгөөг хамтран	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/86 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших "Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордын Цанхийн зүүн, Цанхийн баруун, Оорцог, Бортээгийн хэсэгт 2017-2022 онуудад	70%

			<p>боловсруулж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлагад даалгав;Төлөвлөг</p>	<p>гүйцэтгэсэн хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн нөөцийн шинэчилсэн тайлан"-д дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг тайланд Тавантолгойн ордын дээр дурдсан хэсгүүдийг ашиглах урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг тусгасан болно.</p>	
277			<p>XXV.12.4. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т даалгаж, хэрэгжилтийн явц, тайланг хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд улирал тутам оруулж, ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p>	<p>Засгийн газрын "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/72 дугаар тушаалаар Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” төрийн бус байгууллагад, Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451</p>	100%

				<p>мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p> <p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p> <p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/ Геозкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/ Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/ Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38 Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/</p>	
278		XXV.7.5. Авто зам, гүүрийн барилга, засвар, арчлалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судалж, саналаа танилцуулахыг Уул уурхай, хүнд	Тус яаманд Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулсан Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, ээлжит засвар, арчлалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж ирүүлсэн бөгөөд уг		100%

			<p>үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт;</p>	<p>тогтоолын төсөлд 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 01/2253 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.</p>	
279			<p>XV.2. Засгийн газрын тогтоол батлагдсантай холбогдуулан хайлуур жоншны хүдэр, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, төмрийн баяжмалын холбогдох стандартад өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгав.</p>	<p>Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.</p>	70%
280			<p>XXV.8.2. Гангийн үйлдвэр барих асуудлаар бодлогын санал боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав.</p>	<p>Бодлогын санал боловсруулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: 1. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны 06 дугаар сард БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр тус улсын Жөжян мужийн зарим удирдлага, “Ханжөү ган төмөрлөг групп” компани болон “Нинбө ган төмөрлөг” компанийн төлөөлөгчид УУХҮ-ийн Сайдын урилгаар 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд Монгол Улсад хүрэлцэн ирж, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн гангийн үйлдвэр байгуулах асуудлыг газар дээр нь судалж, урьдчилсан дүгнэлт гаргаж УУХҮ-ийн Сайдад танилцуулсан. 2. БНХАУ-ын Жөжян мужийн Намын хорооны нарийн бичгийн дарга, Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга И Ляньхунд Гангийн үйлдвэр барих үр дүнгийн талаар тодорхой санал, хариу ирүүлэх тухай албан хүсэлтийг уламжилж өгөх тухай УУХҮ-ийн Сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2674 дугаартай албан бичгийг гадаад харилцааны сайдад хүргүүлсэн.</p> <p>3.Мөн УУХҮ-ийн Сайдын урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр БНХАУ-ын “Бугатын Ган төмөрлөг групп” компанийн</p>	30%

			Монгол Улс дахь Бүрэн эрхт төлөөлөгч Гуо Жюнь тэргүүтэй төлөөлөгчид ирж Гангийн үйлдвэр байгуулах асуудлаар уулзалт яриа хийсэн ба мөн УУХҮ-ийн Сайдыг Бугатын “Ган төмөрлөгийн үйлдвэр”-тэй танилцах урилга ирүүлсэн.	
281	XXV.18.1. Хөдөлмөрийн тухай хуульд заасан уул уурхайн салбарт ээлжээр ажиллах асуудлыг ажил олгогч, ажилтан нарт хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэх боломжийг судалж, танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	2022 онд Уул уурхайн салбарын уртын ээлжийн талаарх “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэ зохицуулалтын хэрэгжилтийг судлах үүрэгтэй ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд ахлан Говийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүд дээр очиж, ажил олгогч болон ажилтнуудын төлөөлөлтэй уулзалт ярилцлага хийн, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт боловсруулсан. Уг ажлын хэсэгт тус яамны төлөөлөл орж ажилласан. Одоогоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/181 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа ба үүнд уул уурхайн салбарын уртын ээлжийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, хуулийн нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулахаар ажиллаж байна. Уг ажлын хэсэгт уул уурхайн салбарын ажил олгогчдыг төлөөлж, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөлөл орж ажиллаж байна.	70%	
282	XXV.18. . Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах баримт бичгийг баталгаажуулах үйл ажиллагааг хялбаршуулах боломжийг судалж, танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар ажиллаж байна. Мөн аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчныг хамгаалах талаарх бичиг, баримтыг хянан баталгаажуулах үйл ажиллагааг 100% цахимжуулсан бөгөөд тус яамнаас Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн БОННУ болон БОМТ зэргийг хянан, шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцон ажиллаж байна.	100%	
283	XXV.18.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь болон жишиг үнэ, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үед авч байгаа татварыг оновчтой тогтоох асуудлыг судлан үзэж, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд	Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулж, Сангийн сайдад хүргүүлсэн. Улмаар Сангийн сайдын 2023 оны А/191	100%	

			Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	дүгээр тушаалаар дээр дурдсан аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үед авч байгаа татварыг оновчтой тогтоох боломжийг бүрдүүлсэн. УУХҮ-ийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн боловч Сангийн яамнаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь буурч Төсвийн орлогод сөрөг нөлөөг үзүүлэхээр байх тул дэмжих боломжгүй саналыг өгсөн болно.	
	284		XXV.18.4. Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий бүс нутагт геологийн суурь судалгаа, эрлийн ажлыг орчин үеийн, өндөр технологийн шийдэл ашиглан явуулах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн этгээдээр гүйцэтгүүлэх боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт	Улсын төсвөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг 2023 оны 10 дугаар сараас хойш Испани улсын “XCalibur” компани гүйцэтгэж байна. Энэ оны хээрийн ажил дууссаны дараа үр дүнг засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%
148	285	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	Монгол Улсын Ерөнхий сайдын “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 21 аймагт ажилласан 2023 оны III улиралд ажилласан томилолтод тус яамны төлөөлөл ажилласан бөгөөд салбартай холбоотой иргэдээс тавьсан хүсэлт, саналд тухай бүр хариулт өгсөн болно.	100%
149	286	2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2023-06-21 Дугаар 2023_27	2. Автобензин, дизелийн түлшний хангамжийн тасалдал, хомсдол үүсгэхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай авч хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгав.	Газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч улс ОХУ-ын Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэр 2023 оны 08, 09 дүгээр сард ээлжит урсгал засвар хийх болсон талаар 2023 оны 06 дугаар сард албан захидал ирүүлсний дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран 2023 оны 07,08 , 09 дүгээр саруудад захиалах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, автобензин, дизель түлшний нөөц бүрдүүлэлтийг хангалттай хэмжээнд бүрдүүлсний үр дүнд 2023 оны 08, 09 дүгээр саруудад газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаагүй,	100%

				<p>нөөц бүрдүүлэлт хэвийн үргэлжилсэн. Импортлогч аж ахуйн нэгжүүд ОХУ-ын “Роснефть” компанитай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний худалдан авалтыг хэвийн үргэлжлүүлж байсан боловч ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1537 дугаар тогтоол гарч, түлш, шатахууны экспортыг түр хугацаанд хориглох болсны улмаас Монгол Улс руу ачигдах газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт түр зогссон. Хориг эхэлсэн өдөр буюу 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд нийт 21 хоногийн хугацаанд Монгол Улсад автобензин, дизель түлшний нийлүүлэлт хийгдээгүй бөгөөд энэ үеийг өмнөх саруудад бүрдүүлсэн нөөцөөр зохицуулалт хийх арга хэмжээг авсан. Эдгээр нөхцөл байдлын улмаас 2023 оны 12 дугаар сард газрын тосны бүтээгдэхүүний хангамж, зохицуулалтад тодорхой асуудлууд үүссэн боловч тус яамны зүгээс холбогдох байгууллагууд, импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласны дүнд нийлүүлэлтийг тогтворжуулж, хангамж, түгээлт хэвийн түвшинд шилжсэн. 2023 онд газрын тосны бүтээгдэхүүний нийт импорт өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 500.0 мянган тонноор нэмэгдэж, 2.4 сая тонн болсон. Мөн түлш, шатахууны жижиглэн борлуулалтын үнэ тогтвортой хэвээр байгаа бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдал, хомстол үүсэхээс урьдчилан сэргийлж, тус яамны зүгээс шаардлагатай ажлуудыг тухай бүр шуурхай зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 34 хоног, Аи-92 автобензин 21 хоног, Аи-95 автобензин 45 хоног, дизель түлш 27 хоног, ТС-1 агаарын хөлгийн түлш 22 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна.</p>	
150	287	<p>2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2023-07-05 Дугаар 2023_28</p>	<p>1.1. Дорноговь, Өмнөговь аймагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /ЕРС-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /ЕРС-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /ЕРС-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон</p>	70%

			<p>ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав.</p>	<p>шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “МГТБҮ” ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, Худалдан авалт-35.5%, Барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил -90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	
288		<p>1.1. Аж үйлдвэрийн парк байгуулах бүтээн байгуулалтын урагшлуулах зорилгоор Алтанширээ аж үйлдвэрийн парк болон Айл баян уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох хуулийн хүрээнд судлан шийдвэрлэх</p>	<p>Алтанширээт” ҮТП-ийн төсөл хэрэгжүүлэгч “Инфинитиспейс” ХХК, “Гэрэлт говь” ҮТП-ийн төсөл хэрэгжүүлэгч “Си Өү Эй Эл” ХХК-ийн хүсэлтийн дагуу Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8.1.5-д заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 267 дугаар тогтоолоор уул уурхай, хүнд үйлдвэрийн зориулалтаар үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компаниудад 15 жилийн хугацаатайгаар олгоод байна. “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 16.1.1-т “Паркийн удирдлага, нэгжийн үйл ажиллагаанд татварын дэмжлэг үзүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль”-ийн 40.6-д заасны дагуу үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах, татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн</p>	100%	

			үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх харилцааг зохицуулсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг Сангийн яамтай хамтран боловсруулж Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн "Журам батлах тухай" 337 дугаар тогтоолоор батлуулсан.	
289		1.5. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний борлуулалтыг эрчимжүүлэх, боомтын үйл ажиллагаа дэмжих зорилгоор Оюутолгой ХХК-ийн ашиглаж байсан сайжруулсан шороон замыг холбогдох хууль дүрмийн дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-д ашиглуулах	Тухайн тэмдэглэлтэй холбоотой "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнбатаас ЗТХ Сайд, БОАЖ Сайд, Монгол Улсын сайд Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга руу 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр холбогдох байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулах тухай албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу Монгол улсын Сайд, Боомтын Сэргэлтийн үндэсний хорооны дарга, Зам, Тээврийн Хөгжлийн Сайдын хамтарсан тушаалаар холбогдох ажлын хэсгийг 2023 оны 09 дүгээр сарын 21 өдөр байгуулан ажиллаж байна.	70%
290		11. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын орд газрыг "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр" болон Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулах "Катодын зэсийн үйлдвэр" байгуулах ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах талаарх саналаа танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Г.Ёндон) нарт үүрэг болгов.	"Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" Засгийн газрын 2021 оны 129 дугаар тогтоолын 2 дахт хэсэгт "Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр", "Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр" ..."-ийг тус тус "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг УУХҮ-ийн сайд Г.Ёндон, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Үйлдвэрлэл, технологийн парк /ҮТП/ байгуулах төсөлд 21744.14 сая төгрөг, Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төсөлд 15.164.8 сая төгрөг, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах төсөл /SX-EW/-д 1597.6 сая төгрөг нийт 38.506.5 сая төгрөгийг "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх	30%

			<p>“Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762.255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-ийн боловсруулсан Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцэж хүлээн авсан бөгөөд 362.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглээр даалгасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын орд газрыг түшиглэн байгуулах “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр”, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулах “Катодын зэсийн үйлдвэр” байгуулах ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах талаарх санал, цаашид авч хэрэгжлүүлэх ажлыг төлөвлөгөөг танилцуулах тухай УУХҮ-ийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 01/2380 дугаартай албан бичгийг “Эрдэнэс Монгол”ХХК-ийн гүйцэтгэх захиралд хүргүүлсэн бөгөөд “Эрдэнэс Монгол”ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/944 дугаартай хариу албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Ерөнхий захирал Г.Ёндон 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн ГЁ-69-12/6357 дугаар албан бичигт БНХАУ-д хийгдэж байгаа элементийн хүхрийн үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тодотгох бөгөөд бараа материал үнийн өсөлтөөс хамаарч хөрөнгө оруулалт нэмэгдэх талаар болон төслийн хөрөнгө оруулагчийг холбогдох хууль, журмын дагуу олон улсад нээлттэй тендэр зарлаж, сонгон шалгаруулах боломжтой талаар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эдгээр төслүүдийг гадаад, дотоодод танилцуулж байх үед гадаадын зарим компаниас хамтран хөрөнгө оруулах сонирхолоо илэрхийлж байсан талаар тус тус дурдсан. Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн</p>
--	--	--	--

				төсөлд хөрөнгө оруулалт татах хувилбарыг боловсруулахаар судлан ажиллаж байна.	
151	291	2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2023-07-05 Дугаар 2023_28	XLV.8.10. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т өмнө нь олгосон “Үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар холбогдох арга хэмжээг хуульд нийцүүлэн авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон) нарт тус тус үүрэг болгов;	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хууль”-д нийцүүлэн шинээр авах ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэхь “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагын “Эрдэнэс ҮТП” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулаад байна. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг ирүүлэхэд “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангах шаардлагатай бөгөөд энэ ажлын хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ-ийг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Эрдэнэт ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх, SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, техник технологийн түвшний үнэлгээний ажлыг 2024 онд гүйцэтгэхээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зохион байгуулан ажиллаж байна.	100%
	292		XLV.8.11. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын орд газрыг “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр” болон Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулах “Катодын зэсийн үйлдвэр” байгуулах ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах талаарх саналаа танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон) нарт үүрэг болгов;	“Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын 2021 оны 129 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт “Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр” ...”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг УУХҮ-ийн сайд Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Үйлдвэрлэл, технологийн парк /ҮТП/ байгуулах төсөлд 21744.14 сая төгрөг, Зэсийн баяжмал хайлуулах,	70%

			<p>боловсруулах үйлдвэрийн төсөлд 15.164.8 сая төгрөг, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах төсөл /SX-EW/-д 1597.6 сая төгрөг нийт 38.506.5 сая төгрөгийг “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762.255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-ийн боловсруулсан Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор “Катодын зэс боловсруулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцэж хүлээн авсан бөгөөд 362.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын орд газрыг түшиглэн байгуулах “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр”, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулах “Катодын зэсийн үйлдвэр” байгуулах ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах талаарх санал, цаашид авч хэрэгжлүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулах тухай УУХҮ-ийн Сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 01/2380 дугаартай албан бичгийг “Эрдэнэс Монгол”ХХК-ийн гүйцэтгэх захиралд хүргүүлсэн бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 11 сарын 09-ны өдрийн 01/944 дугаартай хариу албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Ерөнхий захирал Г.Ёндон 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн ГЁ-69-12/6357 дугаартай албан бичигт БНХАУ-д хийгдэж байгаа элементийн хүхрийн үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ-ийг тодотгох бөгөөд бараа материал үнийн өсөлтөөс хамаарч</p>
--	--	--	---

				хөрөнгө оруулалт нэмэгдэх талаар болон төслийн хөрөнгө оруулагчийг холбогдох хууль, журмын дагуу олон улсад нээлттэй тендэр зарлаж, сонгон шалгаруулах боломжтой талаар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эдгээр төслүүдийг гадаад, дотоодод танилцуулж байх үед гадаадын зарим компаниас хамтран хөрөнгө оруулах сонирхолоо илэрхийлж байсан талаар тус тус дурьдсан. Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулалт татах хувилбарыг боловсруулахаар судлан ажиллаж байна.	
152	293	2023 оны 7 дугаар сарын 19-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2023-07-19 Дугаар 2023_29	IX.2.2. Төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтад олон улсын мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, чиг үүрэг, орон тоог оновчтой тогтоох асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, төрийн албан хаагчдыг батлагдсан төсөв, орон тоонд нь багтаан ажиллуулах, орон тоо, төсөв хэтрүүлсэн асуудлыг улсын жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө цэгцлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав;	УУХҮЯ 2023 оны төсвийн гүйцэтгэлээр нийт 89 орон тоотой ажиллахаас 80 хүн ажилласан байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардлаас 142.6 сая төгрөгийн хэмнэлт гарсан.	100%
153	294	2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тэмдэглэл 2023-07-26 Дугаар 2023_30	1. 1. Эрхлэх асуудал, хариуцсан салбарын хүрээний тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам”-д нийцүүлэн цахимжуулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгаж, зөвшөөрөл олгох холбогдох бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зөвлөв.	Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгогдох 3 төрлийн тусгай зөвшөөрөл/Үнэт металл эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх болон төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх/-ийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, Тусгай зөвшөөрлийн цахим систем(www.license.mn)-ээр дамжуулан олгож байна. Тусгай зөвшөөрлийн цахим систем хөгжүүлэгчид "Зөвшөөрлийн нэгдсэн сан"-д хандах хэрэглэгчийн эрхийн тохиргоо нэмэх талаар хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн. Тусгай зөвшөөрлийн цахим системээр олгогдож буй зөвшөөрлүүдийн хувьд журмын хэрэгжилт бүрэн хангагдсан бөгөөд цахим системээр дамжин зөвшөөрлийн нэгдсэн санд шууд бүртгэгдэж байна.	100%

	295		<p>2. 2. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1, 1.17, 1.22, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 5.1, 7.1, 7.2, 7.3, 7.4, 8.3, 8.13, 8.26, 8.27, 11.13-д заасан тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар судлан зохих арга хэмжээ авахыг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-д зөвлөж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав.</p>	<p>Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЦХХХЯ, ЭЗХЯ, e-mongolia академиас хэрэгжүүлж буй тусгай зөвшөөрлийн олголтыг 100% цахимжуулахтай холбоотой гарах журам, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд өөрийн болон харьяа байгууллагуудын зүгээс идэвхтэй оролцон санал солилцож хамтран ажиллаж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1, 1.17, 1.22, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 5.1, 7.1, 7.2, 7.3, 7.4, 8.3, 8.13, 8.26, 8.27, 11.13-т заасан тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар судлан саналыг ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 03/1692 дугаартай албан бичиг, УУХҮ-ийн Сайдын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/2487 дугаартай албан бичгээр ЦХХХЯ-руу, мөн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд олгогддог тусгай зөвшөөрлийн мэдээлэл дамжуулах сервисийг хөгжүүлж, тус төвөөс хүргүүлсэн загварын дагуу 2023 оны 02 дугаар сарын 17 өдөр ГТСМТТ УТҮГ - ийн цахим хаягаар мэдээллийг боловсруулан хүргүүлсэн.</p>	100%
	296		<p>3. 3. Тусгай зөвшөөрлийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон талаарх мэдээллийг тухай бүр зөвшөөрлийн нэгдсэн санд оруулах, шаардлагатай тохиолдолд төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан зөвшөөрлийн нэгдсэн санд нэгтгэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгаж, зөвшөөрөл олгох холбогдох бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зөвлөв.</p>	<p>Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийн талаарх хүсэлтийг www.license.mn цахим хуудсаар дамжуулан хүлээн авч шуурхай шийдвэрлэж байгаа бөгөөд зөвшөөрөл олгосон, хугацаа сунгасан аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээлэл www.license.mn цахим хуудасны Зөвшөөрлийн нэгдсэн сан бүлэгт тухай бүр шинэлэгдэн байршиж, хадгалагдаж байна.</p>	100%
154	297	<p>2023 оны 8 дугаар сарын 19-ний өдөр 32 дугаар тэмдэглэл 2023-08-16 Дугаар 2023_32</p>	<p>XIII.3.Үүнтэй холбогдуулан “Уул уурхайн долоо хоног (Mining week-2023)” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, тус арга хэмжээний зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллахыг</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци хамтран Монгол улсын эрдэс баялгийн салбарыг гадаадын хөрөнгө оруулагч нарт сурталчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Уул уурхайн долоо хоног - 2023” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрийн хооронд 5 өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Уг арга</p>	100%

			Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Соёлын сайд Ч.Номин нарт даалгав.	хэмжээнд Австрали, Австри, Канад, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, ИБУИНХУ (Их британи), Герман, Энэтхэг, Япон, Финлянд, ӨАБНУ, Арабын нэгдсэн Эмират улс, Франц, Испани, Пакистан зэрэг 20 орчим улсын 300 гаруй зочин төлөөлөгч, хөрөнгө оруулагчид хүрэлцэн ирж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл болох 5000 орчим (давхардсан тоогоор) зочид төлөөлөгч оролцсон, олон талын оролцоог хангасан арга хэмжээ болсон.	
155	298	2023 оны 8 дугаар сарын 30-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2023-08-30 Дугаар 2023_34	XXIV.6.3. Монгол, Францын хамтарсан “Бадрах энержи” ХХК-ийн хувьцааны төрийн эзэмшлийн хувь болон ногдуулах татвар, төлбөрийн хувь, хэмжээг өөрчлөх зэргээр санхүүгийн загварчлал гаргаж, үндэслэл бүхий хувилбар танилцуулах, шаардлагатай бол Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгав.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол, Францын хамтарсан “Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж санал, дүгнэлт боловсруулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан ажлын дэд хэсэг удирдамжийн дагуу холбогдох санал, дүгнэлтийг боловсруулахын зэрэгцээ “Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч О”рано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төсөлтэй танилцаж, холбогдох санал, дүгнэлтийг гаргасан болно. Уг санал, дүгнэлтэд Монгол, Францын хамтарсан “Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг судлан үзэхэд “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасан ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлэн тооцох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээний хүснэгтэд ураны баяжмалыг нэмэх асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийн зэрэгцээ “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 47.2.3-т стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна гэж тус тус заасны дагуу “Бадрах Энержи” ХХК-ийн 5 хувь хүртэлх стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг төлөх тухай Засгийн газрын	100%

				тогтоолын төслийг батлуулах шаардлагатай байгааг анхааралдаа авах нь зүйтэй байгаа талаар тусгасан болно.	
156	299	2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр 35 дугаар тэмдэглэл 2023-09-01 Дугаар 2023_35	IV.2.3. Гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, ээлжит болон урсгал засварын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав.	Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайх, ашиглах тусгай журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтоос 2023 оны 01/5910 дугаартай албан бичгээр ирүүлснийг судлаад холбогдох саналыг журмын 5.3 дахь заалтын “Авто зам” гэснийг өмнө “Төмөр зам” гэж нэмэх” гэж санал боловсруулан хүргүүлсэн.	70%
157	300	2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2023-09-06 Дугаар 2023_36	XIII.7.4. Монгол Улсын талаар болон Монголоос олон улсын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН 7 ХОНОГ 2023” олон улсын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын үеэр “Монгол Улс, Оросын холбооны улсын стратегийн түншлэл” сэдэвт уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан.	100%
	301		XIII.9.5. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрлийг (төмрийн хүдэр, хайлуур жонш) нэмэгдүүлж, биржийн арилжааг эхлүүлэх арга хэмжээ авах, Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалын тодорхой хувийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр	Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилал”-ыг батлах тухай тогтоолд зэсийн баяжмалыг нэмэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.	100%

		худалдаалах талаар санал боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;		
302		XIII.10.. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023 оны 09 дүгээр сарын 03-05-ны өдрүүдэд Говь-Алтай, Ховд, Увс аймагт ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Говь-Алтай, Ховд, Увс аймгийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр санал авч, эрэмбэлсэн аймаг тус бүрд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийг Монгол Улсын 2024 оны төсөвт тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Монгол Улсын Ерөнхий сайдын “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 21 аймагт 2023 оны III дугаар улиралд ажилласан томилолтод тус яамны төлөөлөл ажилласан бөгөөд салбартай холбоотой иргэдээс тавьсан хүсэлт, саналд тухай бүр хариулт өгсөн болно.	100%
303		XIII.11.“Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал” болон “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам”-ыг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэлтэй асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан ашигт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол, Францын хамтарсан “Бадрах энерги”ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж санал, дүгнэлт боловсруулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан ажлын дэд хэсэг удирдамжийн дагуу холбогдох санал, дүгнэлтийг боловсруулахын зэрэгцээ “Бадрах энерги” ХХК-ийн хөрөнгө оруулагч О”рано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө	70%

			<p>малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулах, шилжүүлэхэд ногдуулах татварыг зах зээлийн бодит үнэлгээнд тулгуурлан үндэслэлтэй тооцох чиглэлээр холбогдох журам, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав.</p>	<p>оруулалтын гэрээ"-ний төсөлтэй танилцаж, холбогдох санал, дүгнэлтийг гаргасан болно. Уг санал, дүгнэлтэд Монгол, Францын хамтарсан "Бадрах энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч "Орано Майнинг" компаниас ирүүлсэн "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийг судлан үзэхэд "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасан ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлэн тооцох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээний хүснэгтэд ураны баяжмалыг нэмэх асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийн зэрэгцээ "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 47.2.3-т стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна гэж тус тус заасны дагуу "Бадрах Энержи" ХХК-ийн 5 хувь хүртэлх стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг төлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг батлуулах шаардлагатай байгааг анхааралдаа авах нь зүйтэй байгаа талаар тусгасан болно.</p>	
158	304	<p>2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 37 дугаар тэмдэглэл 2023-09-13 Дугаар 2023_37</p>	<p>II.2. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн ажлыг эрчимжүүлж, 2027 онд багтаан ашиглалтад оруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК (Д.Алтанцэцэг)-д, үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаанд шаардагдах бүтээгдэхүүн авах хэлэлцээрийг холбогдох талтай байгуулах арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /EPC-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /EPC-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр "МГТБУ" ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructures Limited" компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, Худалдан авалт-35.5%, Барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн</p>	100%

				ажил - 90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	
	305		XI.2. “Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монголбанкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр”-д нэмэлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны талаарх мэдээлэл, үр ашгийн байдлыг Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгав.	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны явцын талаарх танилцуулгыг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/2251 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.	100%
159	306	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	1.1. “Монголын эдийн засгийн чуулган-2023” хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	“Монголын эдийн засгийн чуулган-2023” хуралдааны үеэр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан "Ашигт малтмалын салбар, сайжруулах орон зай" болон "Ирээдүйн хөгжил-газрын ховор элемент, зэс, уран" сэдэвт салбар хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийн хүрээнд тус яамнаас хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-ын 2023 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар салбарт	70%

			тулгамдсан асуудлуудыг цогцоор нь буюу геологийн судалгаа, эрлийн үйл ажиллагаанаас уурхай, уулын үйлдвэрийг хаах хүртэлх бүхий л үе шатаны харилцааг иж бүрэн зохицуулахаар тусгасан. Мөн “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн шинэчлэлтээр санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгох боломжийг бүрдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, тогтвортой хөгжлийг хурдасгах, эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэхэд томоохон дэмжлэг болно гэж үзсэн.	
307		XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
308		XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
309		XVIII.8.3. 3. Ургац хураалт, хадлан, тэжээл татан авахад шаардагдах шатахууныг тасралтгүй хангах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт;	Тус тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах болон газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ОХУ-ын “Роснефть” компаниас манай улсын импортлогч аж ахуйн нэгжүүдийн 2023 оны 07, 08, 09 дүгээр саруудад захиалах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, автобензин, дизель түлшний нөөц бүрдүүлэлтийг хангалттай хэмжээнд бүрдүүлсний үр дүнд 2023 оны 08, 09 дүгээр саруудад газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаагүй, нөөц бүрдүүлэлт хэвийн үргэлжилсэн. Мөн Дархан, Сэлэнгэ, Булган, Дорнод, Төв зэрэг газар тариалангийн бүс нутаг бүхий аймгуудад	100%

			газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, нөөцийг бүрэн бүрдүүлэхэд анхаарч ажиллах чиглэлийг Монголын нефть хийн үндэсний ассоциаци, Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо ТББ-уудад ТНБД-ын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 03/2588 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, импортлогч аж ахуйн нэгжүүдтэй тухай бүр хамтран ажилласан. 2023 онд Монгол Улсын хэмжээнд нийт 2.4 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс дизель түлш 1.3 сая тонныг импортолсон байна.	
310		XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
311		XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2023 онд Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
312		XVIII.3.2. Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар нэгдсэн санал дүгнэлтээ танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын Шадар сайд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол, Францын хамтарсан “Бадрах энержи”ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ,	100%

			бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав.	холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж санал, дүгнэлт боловсруулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан “Ажлын дэд хэсэг удирдамж”-ийн дагуу холбогдох санал, дүгнэлтийг боловсруулахын зэрэгцээ “Бадрах энерги” ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг” компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төсөлтэй танилцаж, холбогдох санал, дүгнэлтийг гаргасан болно.	
160	313	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	2.9. Бичил уурхай эрхлэгчдийн талаар судалгаа хийж, шийдвэрлэх саналаа танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар болон Ерөнхий сайдын ажлын алба (Д.Амгаланбаатар)-нд;	Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 296 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах дотоод хяналтын хуудасны загвар”-ыг баталж нийт 240 талбайд бичил уурхайн эрхлэх дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлснээс 10 аймгийн 15 сумын 89.83 га 28 талбайд бичил уурхайн дүгнэлт гаргасан байна.	100%
	314		2.10. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дийлэнх хувийг тухайн аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;	Монгол Улсын 2024 оны “Төсвийн тухай хууль”-д уул уурхайн салбар нийт 8.001.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тусгасан нь төсвийн орлогын 29 хувийг бүрдүүлэхээр байна. Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь хэсэгт “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 47.3 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь” гэж, 60 дугаар зүйлийн 60.2.7 дахь заалтад “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь”, мөн зүйлийн 60.6 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно” гэж тус тус заасан. Дээр дурдсан хуульд заасны дагуу	100%

			Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд нийт 482.076.7 сая төгрөгийг шилжүүлэхээр тусгасан нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд заасан хэмжээнээс 112.167.4 сая төгрөгөөр илүү байна.	
315		2.31. Баянхонгор аймгийн Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэ Монгол” ХХК-ийн уурхайтай холбоотой асуудлыг судалж, шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг томилж ажиллуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт;	Эрдэнэ Монгол” ХХК-д олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Баянхонгор аймгийн “Амьд хууль төв” НҮТББ-аас Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх шатанд үргэлжилж байна. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан “Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиргааны саналыг үндэслэнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэж буруутгажээ. Энэхүү асуудлыг харьяаллын дагуу шийдвэрлүүлэхээр УУХҮЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 03/2699 дугаартай албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн.	70%
316		2.42. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн улс, орон нутагт өгөх үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар судлан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;	Монгол Улсын Их Хурлаар 2014 онд баталсан Газрын тосны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т нийцүүлэн 2016-2019 онд 13 хайгуулын гэрээг шинэчилсэн ба ашиглалтын үе шатны 3 талбайн гэрээ шинэчлэх ажил гэрээлэгч талаас зарчмын зөрүүтэй санал гаргасны улмаас шинэчлэгдээгүй, мөн 4 талбайн гэрээг Засгийн газрын тогтоолоор цуцалсан ба 1 талбайн гэрээ шүүхийн маргаантай байсан болно. 2024 оны 01 дүгээр сарын байдлаар газрын тосны хайгуулын 9, газрын тосны ашиглалтын 4 талбайн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Орон нутгийн иргэд болон Төрийн бус байгууллагуудын зүгээс гэрээг шинэчлэх Монгол улсад ногдох хэмжээг нэмэгдүүлэх, газрын тосны нөөц ашигласны төлбөрийг авах зэрэг асуудлаар газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, газрын тосны экспортын тээвэрлэлтэд саад учруулах зэрэг үйлдлийг удаа	100%

дараа гаргах болсон. Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг-XXI талбайнуудад байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний эрх үүргийг шилжүүлэн авсан БНХАУ-ын төрийн өмчит “Петрочайна дачин тамсаг” ХХК болон Бүтээгдэхүүн хуваах гэрээт-97 /БХГ-97/ талбайд мөн БНХАУ-ын төрийн өмчит “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг 2016-2018 онд холбогдох яам, агентлагийн түвшинд 4 удаа Ажлын хэсэг байгуулж ажиллаж байсан боловч талууд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй.

Гэрээлэгч талаас тухай бүр Бүтээгдэхүүн хуваах гэрээг хэвээр хадгалах байр суурийг илэрхийлж ирсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжаар “Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулсан. Мөн Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тушаалаар дээрх ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажиллах Ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн дэд сайд Б.Солонгоор ахлуулан байгуулсан. Тус Ажлын дэд хэсгийн гишүүд “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж холбогдох танилцуулга, саналыг боловсруулан Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Монгол Улсын Шадар сайд 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн ЗГ-2/679 тоот албан бичгээр “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хөрөнгө оруулагч болох “Петрочайна Дачин Ойлфийлд лимитэд” компанийг гэрээ шинэчлэх талаар яриа, хэлэлцээ хийхээр урьсан. Манай талаас яриа, хэлэлцээрийг эхлүүлэх

				<p>талаар санаачилга гарган ажилласан. Тус Ажлын хэсгийн явцыг 2023 оны 05 сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 96 дугаар захирамжаар “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн байгуулах Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулахаар тогтсон. Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд өөр өөрсдийн хариуцсан чиг үүргийн дагуу мэдээллийг бэлтгэж нэгтсэн. Тухайн асуудлаар Ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд БНХАУ-д ажиллаж “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Дай Хоулян болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж дээр “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах Ажлын хэсэг томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Хятадын талын Ажлын хэсгийг “Хятадын үндэсний газрын тосны корпораци”-ийн дэд захирал Жан Даовэй ахлан ажиллахаар болсон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх Монголын талын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан.</p>	
	317		2.50. Салхитын мөнгөний орд болон уурхайн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	<p>“Эрдэнэс Монгол” ХХК нь нэгдлийн компаниудын охин болон хараат компаниудын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд “Эрдэнэс Силвер” ХХК-ийг “Эрдэнэс Алт” ХХК-д нэгтгэж Төлөөлөн удирдах зөвлөлгүй болгож шийдвэрлэсэн байна. УУХҮЯ-наас БОАЖЯ, ХНХЯ, АМГТГ зэрэг төрийн байгууллагуудын оролцоотой улсын комисс томилон тус компанийн хоёрдугаар баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтанд хүлээн авах бэлтгэл</p>	100%

			<p>Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;</p>	<p>хангагдсан байдалтай 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр газар дээр танилцаж ажиллав. Энэ үед тус компанийн холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх бичиг баримтуудын бүрдэл хангалтгүй, батлагдсан бичиг баримтууд нь уурхайн болон баяжуулах үйлдвэрийн бодит байдалтай нийцэхгүй зэрэг зөрчил, дутагдлууд байсныг улсын комисс компанийн удирдлага болон менежментийн багт хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.</p>	
318			<p>2.52. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай холбоотой ажлын байрны дарамт, удирдлагуудын болон ажилтан, ажилчдын цалингийн хэт зөрүүтэй байдал, үйлдвэрийн харьяа орон сууцны хувьчлал, “Уурхайчин-2” орон сууцны төслийн явц, дүн зэрэг асуудлаар Ажлын хэсэг байгуулан ажиллуулан, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;</p>	<p>Хамтын гэрээг байгуулах ажлыг амжилттай зохион байгуулсан байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын байгуулагдсан 40 гаруй жилийн хугацаанд орон сууц хувьчлалд хамрагдсан ажилтнуудын бүтэн үе солигдсон. 2012 онд үйлдвэрийн газраас ажилтнуудыг орон сууцжуулах зорилгоор анх “Москва-300” хорооллыг Эрдэнэт Медикал эмнэлгийн урд, “Залуус-600” хороолол (байршил нь тодорхойгүй), “ЭКО-400” хорооллыг Сархиа уулын энгэрт барихаар төлөвлөсөн боловч дэд бүтэц, газрын асуудлаас шалтгаалан төслүүд хэрэгжих боломжгүй болсон тул төслүүдийг нэг байршилд нэгтгэн сургууль, цэцэрлэг, худалдааны төв бүхий цогц төлөвлөлттэй суурьшлын шинэ бүс “Уурхайчдын цогцолбор хороолол” буюу Уурхайчин-I, II, III төслүүд болгон 2018 оны 12 сараас хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>“Уурхайчин-I” 300 айлын орон сууцны хороолол төслийн барилгын 274 айлын 4 блок орон сууцыг “Химон констракшн” ХХК, 96 айлын 2 блок орон сууцыг “Неман констракшн” ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж гүйцэтгэхээр 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 391 айлын орон сууцыг ашиглалтад хүлээлгэн өгсөн. Үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн ажлыг “Одкон эрчим” ХХК, “Химон констракшн” ХХК барьж гүйцэтгэсэн.</p> <p>“Уурхайчин-II” 600 айлын орон сууцны хороолол төслийн барилгын ажлыг “Өргөө хаан констракшн” ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж гүйцэтгэхээр 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр гэрээ байгуулсан. Гэвч өнөөдрийн байдлаар барилгын талбайн тэгшилгээний ажил, 6 барилгын ул бетон суурийн ажил хийгдэж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй. “Өргөө хаан констракшн” ХХК-тай үүссэн асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсэг</p>	100%

			<p>үйлдвэрийн газрын Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/705 дугаар тушаалаар байгуулж, нийт 12 удаагийн хамтарсан хурал зохион байгуулсан боловч үйлдвэрийн газрын саналыг гүйцэтгэгч компани хүлээн зөвшөөрөөгүй, өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсээр байна. Иймд үйлдвэрийн газрын удирдлага, Ажлын хэсэг, “Эрдэнэс монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тус компанид захиалга өгч хохирсон 309 ажилтны хохирлыг үйлдвэрийн газар төлөх, тус компанийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Өнөөдрийн байдлаар захиалагчдын гэрээ, байрны урьдчилгаа төлбөр төлсөн баримт, итгэмжлэлийн баримтуудыг бүрдүүлж, шүүхэд хандахаар ажиллаж байна.</p> <p>“Уурхайчин-III” 400 айлын амины орон сууцны хороолол төслийн барилгын ажлыг 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж гүйцэтгэхээр “Люксвүүд групп” ХХК 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан байна.</p>	
319		2.79. “Халзан Бүргэтэй” төслийн талаар Ховд аймагт үүсээд байгаа нөхцөл байдлыг судлан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт;	Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших “Халзан бүрэгтэйн орд”-д хамаарах ашигт малтмалын MV-012335, MV-006911 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг эзэмшигч “Монголиан рийр ийрт корп” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулж илэрсэн зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг нь түр зогсоосон.	100%
320		2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	<p>Засгийн газрын “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/30 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А-341 дүгээр тушаалаар батлагдсан “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”-ыг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/72 дугаар тушаалаар Геологийн</p>	100%

			<p>салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх эрхийг “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” төрийн бус байгууллагад, Уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл” ТТБ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 13 дугаар гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгон, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлөөс нийт 451 мэргэшлийн зэрэг олгосноос 210 зөвлөх, 241 мэргэшсэн зэргийг олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 2 удаа сургалт зохион байгуулж 24 мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Зөвлөх инженерийн зэрэг олгогдоогүй. Үүнээс:</p> <p>Ашигт малтмал баяжуулагч чиглэлээр 14 /зөвлөх 0, мэргэшсэн 14/ Уул уурхай ашиглалтын технологи чиглэлээр 10 /зөвлөх 0, мэргэшсэн 10/</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-тай 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “ГЕОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” 14 дүгээр гэрээг байгуулж мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх эрх олгож, гэрчилгээг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж байна. Тус эрхийн хүрээнд “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-</p>	
--	--	--	--	--

				<p>аас нийт 432 мэргэшлийн зэрэг олгосноос 213 зөвлөх, 219 мэргэшсэн зэргийг тус тус олгосон байна.</p> <p>2023 оны байдлаар нийт 9 сургалт зохион байгуулж Зөвлөх инженерийн зэрэг 42, мэргэшсэн инженерийн зэрэг 6, нийт 103 мэргэшсэн, зөвлөхийн зэрэг олгосон. Үүнээс:</p> <p>Гидрогеологийн чиглэлээр 2 /зөвлөх 1, мэргэшсэн 1/; Геоэкологийн чиглэлээр 2 /зөвлөх 2/; Геофизикийн чиглэлээр 20 /зөвлөх 6, мэргэшсэн 14/; Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 57 /зөвлөх 19, мэргэшсэн 38/; Геологийн чиглэлээр 22 /зөвлөх 14, мэргэшсэн 8/.</p>	
161	321	2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр 44 дүгээр тэмдэглэл 2023-11-01 Дугаар 2023_44	XV.5.2. Засгийн газрын гадаад өрийн зохицуулалт хийх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд хууль зүйн магадлан шинжилгээ хийлгэх, үнэт цаасны танилцуулга бэлтгэх ажилд холбогдох яамдын бодлогын асуудал хариуцсан албан тушаалтныг оролцуулж, хамтарч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Сангийн яамны чиг үүрэгт хамаарах тул хасуулах саналтай.	Х.Б
	322		XV.2.1. Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдүүд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-д заасан системийг ашиглаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны явцыг бүрэн цахимжуулж, мэдээллийг "АРГ холболтоор бодит цагийн горимд Зөвшөөрлийн нэгдсэн сан (Нсепзе.тп)-д нийлүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-т заасан системийг ашиглаж аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлж, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны явцыг бүрэн цахимжуулж, мэдээллийг "Зөвшөөрлийн нэгдсэн сан"-д тухай бүр нь байршуулсан.	100%

			Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан), Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Эрчим хүчний зохицуулах хороо (Э.Түвшинчулуун)-нд зөвлөв		
162	323	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу УУХҮ-ийн Сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтын хэрэгжилтийг сар бүр яамны газар, хэлтэс болон харъяа агентлагаас хүлээн авч нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д хэрэгжилт, үнэлгээг байршуулж байна.	100%
163	324	2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2023-11-15 Дугаар 2023_46	XVI.12.8. Төрөөс иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ танилт, нэвтрэлтийн “ДАН” систем ашиглахыг Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллагын удирдлагуудад	УУХҮЯ-ны эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд олгодог тусгай зөвшөөрлийн үйлчилгээнд танилт, нэвтрэлтийн “ДАН” системийг ашиглаж байна.	100%
	325		XVI.14.3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн	“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой салбарын бодлого, үйл ажиллагааг уялдуулан ажиллаж байна. Тухайлбал, 2023 оны	100%

			<p>үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлж, шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд</p>	<p>байдлаар 6.91 сая га талбайд ашигт малтмалын 2726 тусгай зөвшөөрөл, үүнээс 1721 ашиглалтын, 1005 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 4.4 хувийг эзэлж байна. Геологийн судалгааны 10 чиглэлээр 70 гаруй төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.</p> <p>Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, салбарын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж, геологийн судалгаанаас уурхай, уулын үйлдвэрийг хаах хүртэлх бүхий л үе шатны харилцааг уг хуулиар иж бүрэн зохицуулахаар тусгаад байна. Газрын тосны 9 талбайд хайгуулын, 4 талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулж, газрын тос боловсруулах үйлдвэр болон газрын тос дамжуулах шугам хоолой барих төслүүд амжилттай хэрэгжиж байна. Хүнд үйлдвэрийн чиглэлээр төмөрлөг боловсруулах 26, металл хийцийн 5, машин, тоног төхөөрөмж эд анги үйлдвэрлэх 10, резин материал үйлдвэрлэлийн 7, кокс, хагас коксын 3, будаг, химийн 3, шохойн чулуу, цементийн 8, барилгын дулаалгын чулуун хөвөнгийн 1, чулууны 1, зэс утас үйлдвэрлэх чиглэлээр 2 аж ахуйн нэгж ажиллаж байна.</p>	
164	326	<p>2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48</p>	<p>3. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60.6 дахь хэсэгт заасныг чанд мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.</p>	<p>Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 16.3-т “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна”, Захиргааны ерөнхий хуулийн 60.6-д “Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийг хүчингүй болгох, шинэчлэн найруулах, эрх олгосон заалтад агуулгын өөрчлөлт оруулах тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулна” гэж мөрдөж энэ талаар яамны нэгжүүдийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.</p>	100%

165	327	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49</p>	<p>XVI.3.5. Газрын тос дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, уг төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс олгож байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг тус компанид хэрхэн үр ашигтай байдлаар шийдвэрлэх боломжийн талаар судалж, санал боловсруулан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /ЕРС-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /ЕРС-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /ЕРС-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “МГТБҮ” ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, Худалдан авалт-35.5%, Барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил -90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	100%
166	328	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэл 2023-12-13 Дугаар 2023_50</p>	<p>XVII.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр зэсийн баяжмалыг үе шаттайгаар арилжаалах асуудлыг судалж, туршилтаар арилжааг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай) нарт даалгав</p>	<p>Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилал”-ыг батлах тухай тогтоолд зэсийн баяжмалыг нэмэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.</p>	100%

ЗГ-ын албан даалгавар

167	329	Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01	12.1. 12.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд: 12.1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх;	“Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл болон “Хөгжлийн сангийн тухай хууль”-ийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасны дагуу ХЗДХЯ болон Сангийн яамнаас 2022 оны 06 дугаар сард зохих зөвшөөрлийг авч, хуулийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 192 дугаар захирамжийн дагуу “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл, дагалдах хуулийн төсөл болон холбогдох бусад баримт бичгийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/3297 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн болно.	Х.Б
	330		12.3. 12.3. Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад байнгын хяналт тавьж, газрын түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх;	Газрын тос дамжуулах хоолойн төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор төсөлд шаардагдах санхүүжилтийг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг зөвшөөрсөн. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК, Ерөнхий гүйцэтгэгч “Norinco International Cooperation” компани, санхүүжүүлэгч “ЭТТ” ХК,	100%

			захиалагч УУХҮЯ хооронд 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр гэрээ байгуулж хоолойн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.	
331		12.4. 12.4. Зэс хайлуулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх;	"Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах" төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг бэлтгэн УУХҮ-ийн Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/127 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон боловч удаа дараа хойшлогдсон. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр "Албан даалгавар"-аар даалгасны дагуу "Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар" танилцуулгыг УУХҮ-ийн Сайдын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1590 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100%
332		12.6. 12.6. Хар төмөрлөгийн (кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр) үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлэх асуудлыг судлан ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;	Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанд УУХҮ-ийн Сайд Г.Ёндон "Болдтөмөр Ерөө гол" ХХК-ийн Дорноговь аймгийн Алтан ширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа "Алтан ширээт аж үйлдвэрийн парк" байгуулах төслийн ажлын явц, тулгамдаж байгаа асуудлаар танилцуулга, Засгийн газрын тэмдэглэлийн төсөл боловсруулж танилцуулсан. ЭЗХЯ-аас 2022 оны 03 дугаар сард гаргасан хуваарийн дагуу "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хар төмөрлөгийн чиглэлээр тусгагдсан Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа "Монгол ган цогцолбор I" төслийг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, Орхон аймагт хэрэгжүүлж байгаа "Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл"-ийг 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуваарийн дагуу төслүүдийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулга бэлтгэж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлэн болгосон боловч уг төслүүдийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах шаардлагагүй болсон талаар ЭЗХЯ-наас мэдэгдсэн.	70%

168	333	<p>Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2022-01-11 Дугаар 2022_1</p>	<p>5. 5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд:</p> <p>5.1. Аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>5.2. Тавантолгой болон бусад нүүрсний ордын усан хангамжийн асуудлыг судлан үзэж, хэрхэн шийдвэрлэх саналаа, говийг усжуулах төслийн хамт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>5.3. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>5.4. Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2024 онд багтаан дуусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;</p> <p>5.5. Эрдэнэт, Оюутолгой болон зэсийн бусад ордуудыг иж бүрнээр нь ашиглаж, зэс боловсруулалтыг нэмэгдүүлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөрт багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>5.6. Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулалт татан хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1</p>	<p>5.2. Тавантолгой бүлэг ордыг түшиглэн баригдах төслүүдийн усан хангамжийн талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.</p> <p>5.3. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.</p> <p>5.4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.8%-тай. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /EPC-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79%-тай. Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /EPC-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “МГТБҮ” ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11.0%-тай. Үйлдвэрийн төслийг 2026 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тос дамжуулах хоолойн төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70.0%, Худалдан авалт-35.5%, Барилга угсралт-38.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил -90%, БОННУ хийх ажил-100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй, төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	100%
-----	-----	--	---	---	------

			<p>дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>5.7. Цагаан суваргын зэсийн ордын ашиглалтыг дэмжих талаар хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах;</p> <p>5.8. Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;</p> <p>5.9. Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;</p> <p>5.10. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2022 оны 03 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p>	<p>5.5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр “Албан даалгавар”-аар даалгасны дагуу “Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар” танилцуулгыг УУХҮ-ийн Сайдын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1590 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>5.7. Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 24 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан.</p> <p>5.10. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 15.5-д заасны дагуу “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан. Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна</p>	
169	334	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг	1.4. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл,	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан УУХҮЯ-ны ТНБД-ын 10	100%

		<p>эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01</p>	<p>санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт хүргүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд;</p>	<p>дугаар сарын 24-ний “Нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулах тухай” 4-р албан даалгаврыг гаргасан. Албан даалгаврын хүрээнд нээлттэй мэдээллийн тухай хуулийн 8.2.1-8.6.22-т заасан мэдээллийн мэдээлэл хариуцагчийг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг харъяа байгууллагад даалган албажуулж хүргүүлсэн.</p> <p>2. Нийтийн мэдээллийн ил,тод байдлын тухай хуулийн 8.2.1-8.6.22-т заасан мэдээллийг УУХҮЯ-ны албан ёсны цахим хуудаст байршуулан ЦХХХЯ-ны шил ажиллагаагаар shilen.gov.mn сайтад тус яам нь 98.83%-иар үнэлэгдсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2008 оноос хойш Засгийн газрын тусгай сангаас, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй болно.</p>	
335			<p>1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг албан ёсны цахим хуудаст байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байна. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.17 дахь хэсэгт “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана” гэж заасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нээлттэй мэдээлэл ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх” журмын дагуу үнэлгээний тайланг ХЗДХЯ-ний дэргэдэх зөвлөлд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тус зөвлөлийн Zuvlul@mojha.gov.mn албан хаягаар хүргүүлсэн</p>	100%

170	336	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан болон санаачлан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-07-03 Дугаар 2023_02</p>	<p>5.1.“Газрын тос боловсруулах үйлдвэр” төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж нийт 4 багц ажлаас бүрдэж байгаа бөгөөд "Технологийн бус барилга байгууламжийн /ЕРС-1/-ийн барилга угсралтын ажил 2023 оны эцсийн байдлаар 98.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Төсөл хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь үйлдвэрийн Анхдагч процессын байгууламж /ЕРС-2/, Үйлдвэрийн цахилгаан станц /ЕРС-3/-ын барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийг 2022 онд, Лицензтэй технологийн байгууламж /ЕРС-4/-ийн ерөнхий гүйцэтгэгчийг 2023 онд тус тус шалгаруулж БНЭУ-ын “Megha Engineering Infrastructures Limited” компанитай гэрээг байгуулаад байна. Үйлдвэр ашиглалтад орсноор Шингэрүүлсэн шатдаг хий 43 мян.тн, Авто бензин 339 мян.тн, Дизель түлш 824 мян.тн, Тийрэлтэт хөдөлгүүрийн түлш 80 мян.тн, Зуухны түлш 47 мян.тн, нийт 1,33 мян.тн стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тооцоололтой бөгөөд энэ нь манай улсын дотоодын хэрэглээний 55.0 хувийг хангах боломж бүрдэх юм.</p>	100%
-----	-----	--	---	---	------

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ